



ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНС, УС УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН НАРИЙВЧИЛСАН СУДАЛГАА



Хөдөө аж ахуй, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын нарийвчилсан судалгааг Хөгжлийн Шийдэл ТББ-ийн захиалгаар Бизнес Меридиан Консалтинг ХХК-н судалгааны баг гүйцэтгэв.

Судалгааны багийн үндсэн бүрэлдэхүүн:

| | |
|---------------|---|
| Г.Сайнбилэг | Багийн ахлагч Докторант, СЭЗИС-ийн ахлах багш, БМК ХХК-ийн судлаач |
| Т.Оюунгэрэл | Ph.D., СЭЗИС-ийн дэд профессор, БМК ХХК-ийн судлаач |
| Б. Баярсайхан | Докторант, СЭЗИС-ийн ахлах багш, БМК ХХК-ийн судлаач |

Төслийн зөвлөх:

| |
|-----------------------------|
| Hitesh Jayshukhlal Upadhyay |
|-----------------------------|

Өгөгдлийн шинжилгээ:

| | |
|---------------|--|
| Б.Баярцэцэг | МВА, СЭЗИС-ийн дадлагажигч багш, БМК ХХК-ийн судлаач |
| Ж.Сувд-Эрдэнэ | Докторант, СЭЗИС-н ахлах багш, БМК ХХК-ийн судлаач |

Эх бэлтгэл:

| | |
|----------------|--|
| Г.Болор-Эрдэнэ | Докторант, СЭЗИС-ийн багш, БМК ХХК-ийн судлаач |
|----------------|--|

Өгөгдөл цуглуулалт:

| | | |
|---------------|---------------|-------------|
| Г.Ганбат | М.Сүлдбаяр | С.Золзаяа |
| Б.Янжиндулам | У.Түмэнхүслэн | Б.Нямхүү |
| Б.Дөлгөөн | Т.Хишигдулам | Б.Энххүслэн |
| Б.Цэвээнсүрэн | А.Одонбаяр | |
| Г.Тэлмүүн | М.Золзаяа | |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|----------|---|
| ААН | Аж ахуйн нэгж |
| БЖДБЭ | Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч |
| БЖДҮ | Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БОАЖЯ | Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам |
| ДББ | Дахин боловсруулагдсан бүтээгдэхүүн |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЖХҮ | Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ |
| ЗАА | Зөгийн аж ахуй |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |
| МУ | Монгол Улс |
| МҮХАҮТ | Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрлэлийн Танхим |
| НӨС | Нэмүү өртгийн сүлжээ |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| ӨҮА | Өөрийн үнэлгээний асуулга |
| ТЭЗ | Тойрог эдийн засаг |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үндэслэл |
| ТЭМ | Түүхий эд материал |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХААЗД | Хөдөө аж ахуйн зохистой дадал |
| ХААХУУҮС | Хөдөө аж ахуй, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбар |
| ХББ | Хамтын баталгаажуулалтын байгууллага |
| ХК | Хувьцаат компани |
| ХУУҮ | Хүнс, ус ундаа үйлдвэрлэл |
| ХХАА | Хүнс, хөдөө аж ахуй |
| ХХААХҮЯ | Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрлэлийн Яам |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХЯ | Хүлэмжийн хийн ялгарал |
| ШУБЯ | Шинжлэх Ухаан Боловсролын Яам |
| ШТС | Шатахуун түгээх станц |

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| Нэр томьёо | | Тайлбар |
|--|----------------------------|--|
| Ногоон гэрчилгээ | Green certificate | Ногоон буюу байгаль орчинд ээлтэй байх зарчим, стандарт, дүрэм журмын дагуу үйл ажиллагаа эрхэлдгийг баталгаажуулсан гэрчилгээ |
| Нэмүү өртгийн сүлжээ | Value chain | Бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход бизнесийн үйл ажиллагааны хэлхээг тодорхойлсон ойлголт |
| Саад бэрхшээлийг тодорхойлох шинжилгээ | Bottle neck analysis | Үйл ажиллагаанд тулгарч буй асуудал, саад бэрхшээлийг тодорхойлох шинжилгээ |
| Тойрог туршлагын төлөвшлийн загвар | Circular maturity level | Тойрог эдийн засгийн туршлагын хэрэгжүүлэх буюу тойрог болохын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шинж чанаруудыг тодорхойлсон үнэлгээний загвар |
| Тойрог эдийн засаг | Circular economy | Үйлдвэрлэл, хуваарилалт болон эцсийн хэрэглээний явцад түүхий эд материалын хэрэглээг багасгах (түүхий эдийн хамгийн бага ашиглалт), дахин хэрэглэх (бүтээгдэхүүн, эд ангиудыг олон дахин ашиглах), дахин боловсруулах зэрэг бүх л үйл ажиллагааг хамруулсан ойлголт |
| Тойрог эдийн засгийн туршлагын зөрүүтэй байдал | Circular practices gap | Тойрог эдийн засгийн олон улсын сайн туршлага, өнөөгийн нөхцөл байдал хоёрын зөрүүтэй байдал |
| Тойрог эдийн засгийн туршлага | Circular economy practices | Бараа материал, бүтээгдэхүүнийг аль болох урт хугацаанд хуваалцах, түрээслэх, дахин ашиглах, засварлах, шинэчлэх, дахин боловсруулахыг хамарсан үйлдвэрлэл, хэрэглээг эрхэлдэг сайн туршлага |
| Шалтгаан, үр дагаврын схем | Cause effect scheme | Асуудлын үр дагавар, шалтгааныг тодорхойлоход ашигладаг арга хэрэгсэл |
| Эко шошгожуулалт | Eco labeling | Ногоон буюу байгаль орчинд ээлтэй байх зарчим, стандарт, дүрэм журмын дагуу үйл ажиллагаа эрхэлдгийг баталгаажуулах тэмдэг, тэмдэглэгээ авах үйл явц |

АГУУЛГА

| | |
|--|----|
| СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ..... | 10 |
| 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ | 16 |
| 1.1. Судалгааны хүрээ ба хүлээгдэж буй үр дүн | 16 |
| 1.2. Өөрийн үнэлгээний асуулга | 17 |
| 1.2.1. Судалгааны дизайн | 17 |
| 1.2.2. Судалгааны арга | 18 |
| 1.2.3. Түүврийн хэмжээ | 19 |
| 1.2.4. Судалгааны хуваарь | 20 |
| 1.2.5. Судалгааны хяналт..... | 20 |
| 1.3. Ганцаарчилсан ярилцлага..... | 23 |
| 2. ХАА, ХҮНС, УС УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ҮНЭЛГЭЭ | 24 |
| 2.1. ХАА, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал..... | 24 |
| 2.2. Дэд салбаруудын ерөнхий мэдээлэл | 28 |
| 2.3. Салбарын ерөнхий нөхцөл байдлын үнэлгээ | 30 |
| 2.4. Салбарын хувьд тулгамдаж буй асуудал | 31 |
| 3. ХАА, ХҮНС, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЧАДАВХ | 33 |
| 3.1. Эко шошгожуулалт | 33 |
| 3.1.1. Ногоон гэрчилгээ | 33 |
| 3.1.2. Эко шошгожуулалтын тухай ойлголт | 36 |
| 3.2. Сургалт, санхүүгийн хэрэгцээ | 37 |
| 3.2.1. Сургалтын хэрэгцээ | 37 |
| 3.2.2. Санхүүгийн хэрэгцээ | 39 |
| 3.3. Байгууллагын чадавх | 41 |
| 4. ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ТУРШЛАГА | 43 |
| 4.1. Тойрог эдийн засгийн ойлголт..... | 43 |
| 4.1.1. Тойрог эдийн засгийн зөрүүтэй байдал | 43 |
| 4.1.2. Тойрог эдийн засгийн элементүүд | 45 |
| 4.2. Тойрог эдийн засгийн туршлагын өнөөгийн нөхцөл байдал | 46 |
| 4.2.1. Тойрог эдийн засаг дахь стратеги ба менежментийн туршлагууд | 46 |
| 4.2.2. Тойрог эдийн засаг дахь олон нийтийн ба дотоод үйл ажиллагааны туршлагууд | 49 |
| 4.2.3. Тойрог эдийн засгийн туршлагын зөрүүтэй байдал | 56 |
| 5. НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭ | 63 |
| 5.1. Нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ | 63 |

| | | |
|--------|--|-----|
| 5.1.1. | Газар тариалангийн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ | 63 |
| 5.1.2. | Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ | 66 |
| 5.1.3. | Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ | 70 |
| 5.1.4. | Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ..... | 74 |
| 5.2. | Нэмүү өртгийн сүлжээний саад бэрхшээл (bottleneck)..... | 77 |
| 5.3. | Газар зүйн байршил | 80 |
| 6. | ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА | 82 |
| 6.1. | Тойрог эдийн засгийн хэрэгжүүлэлт ба түүний сайн туршлагууд | 82 |
| 6.2. | Тойрог эдийн засгийн практик туршлагууд ба сайн жишээнүүд | 84 |
| 6.2.1. | Нөөцийн хэрэглээг бууруулах туршлага /REDUCE/ | 88 |
| 6.2.2. | Бүтээгдэхүүний дахин хэрэглээг эрчимжүүлэх /REUSE/..... | 90 |
| 6.2.3. | Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг сунгах | 90 |
| 6.2.4. | Нөөцөд шинээр тойрог амьдрал бий болгох | 91 |
| 7. | ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ | 94 |
| 7.1. | Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбар | 94 |
| 7.2. | Тойрог эдийн засгийн төлөвшлийн түвшин (Maturity level)..... | 96 |
| 7.3. | Шалтгаан, үр дагавар | 98 |
| 8. | САНАЛ ЗӨВЛӨМЖ | 100 |
| 9. | АШИГЛАСАН МАТЕРИАЛ ЭХ ҮҮСВЭРИЙН ЖАГСААЛТ | 106 |
| 10. | ХАВСРАЛТУУД..... | 108 |
| 10.1. | Нарийвчилсан судалгааны ажлын даалгавар | 108 |
| 10.2. | Газар тариалан эрхлэгчийн өөрийн үнэлгээний хуудас | 109 |
| 10.3. | Зөгийн аж ахуй эрхлэгчийн өөрийн үнэлгээний хуудас | 117 |
| 10.4. | Хүнс, ус ундаа үйлдвэрлэгчийн өөрийн үнэлгээний хуудас..... | 125 |
| 10.5. | Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн өөрийн үнэлгээний хуудас | 134 |

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|-----|
| Зураг 1. Өгөгдөл цуглуулах явцын хяналт | 21 |
| Зураг 2. Түүврийн хяналт | 22 |
| Зураг 3. Газар зүйн байршлын зураглал | 22 |
| Зураг 4. Нэн тэргүүн хэрэгжүүлэх ажлын саналууд | 32 |
| Зураг 5. МҮХАҮТ-н “Органик бүтээгдэхүүн” эко тэмдэг авах үйл явц | 34 |
| Зураг 6. ХХААХҮЯ- Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг- ХББ-н гэрчилгээ авах үйл явц ... | 36 |
| Зураг 7. Тойрог эдийн засгийн зөрүүтэй байдал | 43 |
| Зураг 8. Тойрог эдийн засгийн зураглал | 44 |
| Зураг 9. Тойрог эдийн засгийн элементүүд | 45 |
| Зураг 10. Тойрог эдийн засгийн стратеги | 45 |
| Зураг 11. Газар тариалангийн өртгийн сүлжээний зураглал | 66 |
| Зураг 12. Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний зураглал | 69 |
| Зураг 13. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний зураглал | 73 |
| Зураг 14. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний өртгийн сүлжээний зураглал | 77 |
| Зураг 15. БЖДҮ-ийн газар зүйн байршил | 80 |
| Зураг 16. Оролцогчдын холбоо барих мэдээлэл | 80 |
| Зураг 17. Оролцогчдын холбоо барих мэдээллийн хүснэгт | 81 |
| Зураг 18. Тойрог эдийн засгийн төлөвшлийн загвар | 96 |
| Зураг 19. Шалтгаан, үр дагаврын схем | 99 |
| Зураг 20. Хөдөө аж ахуйн салбарын Метан болон Хүлэмжийн хийн ялгаруулалт | 100 |
| Зураг 21. Эрчим хүчний эрчим болон Нүүрстөрөгчийн эрчим | 101 |
| Зураг 22. Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарал | 102 |

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|-----|
| Хүснэгт 1. Асуулгын төрлүүд..... | 17 |
| Хүснэгт 2. ӨҮА-н агуулга..... | 17 |
| Хүснэгт 3.Түүврийн хэмжээ | 19 |
| Хүснэгт 4. Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан хүмүүс | 23 |
| Хүснэгт 5. Тариалангийн талбайн хэмжээ..... | 24 |
| Хүснэгт 6. Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо..... | 25 |
| Хүснэгт 7. Тариалан эрхэлдэг өрхийн тоо..... | 25 |
| Хүснэгт 8. Зөгийн аж ахуйн тоо | 26 |
| Хүснэгт 9. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, улсын дүнгээр, жилээр | 26 |
| Хүснэгт 10. Төрөл бүрийн ундааны үйлдвэрлэл, мян.л | 26 |
| Хүснэгт 11. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээний газруудын тоо, ангилалаар | 27 |
| Хүснэгт 12.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын байгууллагуудын тоо, ангилалаар | 27 |
| Хүснэгт 13. Стандартуудын хэрэгжилтийн үнэлгээ | 33 |
| Хүснэгт 14. ХАА-н ногоон гэрчилгээнүүд..... | 33 |
| Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн сургалт..... | 38 |
| Хүснэгт 16. МУ-н хүрээлэн буй орчиндоо хариуцлагатай байх зорилго, зорилт хөтөлбөрүүдийг баримталдаг байдал | 47 |
| Хүснэгт 17. ТЭЗ-ийн зөрүүтэй байдал..... | 56 |
| Хүснэгт 18. Газар тариалангийн салбарын ТЭЗ-ийн зөрүүтэй байдал | 57 |
| Хүснэгт 19. ЗАА эрхлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал..... | 58 |
| Хүснэгт 20. ХУУҮ-н ТЭЗ-ийн зөрүүтэй байдал | 59 |
| Хүснэгт 21. ЖХҮ эрхлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал | 60 |
| Хүснэгт 22. Газар тариалан ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал | 64 |
| Хүснэгт 23. Зөгийн аж ахуйн ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал | 68 |
| Хүснэгт 24. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал..... | 72 |
| Хүснэгт 25. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчид ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал | 76 |
| Хүснэгт 26. Хүнсний хаягдлын хувь бодох коэффициент | 78 |
| Хүснэгт 27. Тойрог эдийн засгийн стратеги, зорилго, практикууд..... | 87 |
| Хүснэгт 28. Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбар тодорхойлох шинжилгээний үр дүн. 95 | |
| Хүснэгт 29. Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбарын үнэлгээ үр дүн, эрэмбэ | 96 |
| Хүснэгт 30. Тойрог төлөвшлийн түвшин | 97 |
| Хүснэгт 31. Тойрог төлөвшлийн түвшин, дэд салбараар..... | 98 |
| Хүснэгт 32. Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах ажлууд | 104 |

ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| График 1. Судалгааны хамрах хүрээ..... | 16 |
| График 2. ДНБ, 2021-2022 он | 24 |
| График 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний төрөл, 2021 он | 25 |
| График 4. Газар тариалан эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл | 28 |
| График 5. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл | 29 |
| График 6. Хүнс, ус, ундаа үйлдвэрлэгчдийн ерөнхий мэдээлэл | 29 |
| График 7. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл | 30 |
| График 8. Салбарын нөхцөл байдлын дундаж үнэлгээ | 31 |
| График 9. Салбарын хувьд тулгамдаж буй асуудлууд | 32 |
| График 10. Тойрог эдийн засгийн тухай мэдлэг | 36 |
| График 11. Эко шошгожуулалтын тухай хандлага..... | 37 |
| График 12. Сургалтын чадавхын өөрийн үнэлгээ..... | 38 |
| График 13. Сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ | 38 |
| График 14. Санхүүгийн салбарын үнэлгээ | 39 |
| График 15. Санхүүжилт авахад тулгардаг бэрхшээл..... | 40 |
| График 16.. Санхүүгийн чадавхын өөрийн үнэлгээ, дунджаар | 40 |
| График 17. Санхүүжилтийн эх үүсвэр | 40 |
| График 18. Шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ | 41 |
| График 19. Байгууллагын чадавх | 42 |
| График 20. Эко төсөл боловсруулсан байдал..... | 47 |
| График 21. Эко зорилгыг хэмжих үзүүлэлтүүд ашигладаг эсэх | 47 |
| График 22. Газар тариалан эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага | 50 |
| График 23. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага | 51 |
| График 24. Хүнс, ус ундаа үйлдвэрлэгч нарын тойрог эдийн засгийн туршлага | 53 |
| График 25. Жижиглэн худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага | 54 |
| График 26. Газар тариалан эрхлэгчдийн орц | 63 |
| График 27. Тариалангийн хэлбэр | 64 |
| График 28. Газар тариалангийн гарц | 65 |
| График 29. Зөгийн аж ахуйн орц..... | 67 |
| График 30. Зөгийн балаа хадгалдаг аргууд | 68 |
| График 31. Зөгийн аж ахуйн гарц..... | 69 |
| График 32. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаа | 70 |
| График 33. ХУУҮ-н орц..... | 71 |
| График 34. Хүнс, ус ундааны хадгалалт | 72 |
| График 35. ХУУҮ-н гарц | 73 |
| График 36. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний орц | 75 |
| График 37. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээний бүтээгдэхүүний хадгалалт | 75 |
| График 38. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний хэрэглэгчид | 76 |

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсын хөдөө аж ахуй, хүнсний салбар нь улсын нийт ДНБ-ний 13 хувь, хөдөлмөр эрхлэлтийн 30 хувийг бүрдүүлдэг хэдий ч хүлэмжийн хийн ялгарал, хог хаягдал зэргээрээ байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг салбаруудын нэг. ХХААХҮЯ 2030 он гэхэд нийт хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүний 5 хувийг шошгожуулж, гэрчилгээжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Салбарын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд жижиг дунд үйлдвэрлэгч нарын тойрог эдийн засгийн (ТЭЗ) тэргүүн туршлагауудыг нутагшуулах ажлыг дэмжих нь нэн чухал юм.

Европын холбооны Свич Эйшиа хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй ТЭЗ-т шилжих, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой “Эдийн засгийн ногоон шилжилт” төсөл хэрэгжиж байна. Европын холбооны Свич Эйшиа хөтөлбөрийн санхүүжилтээр Пипл ин Нийд ОУТББ, Каритас Чех Репаблик ОУТББ, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо болон Хөгжлийн Шийдэл ТББ-ууд хамтран уг төслийг хэрэгжүүлж байгаа ба Улаанбаатар, Орхон, Сэлэнгэ аймгуудад дөрвөн жилийн хугацаанд үргэлжилнэ.

Төслийн хүрээнд Монгол Улсын хөдөө аж ахуй, хүнс, ундааны салбарын (ХААХУУҮС) бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, борлуулагч нарыг дадал, зан төлөвөө өөрчлөхөд шаардлагатай мэдээлэл, аргачлалаар хангах, улмаар зах зээлд суурилсан эко шошгыг нэвтрүүлж, ногоон санхүүжилтийн эх үүсвэртэй болох, ТЭЗ-т шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ. Төслийн үр дүнд бичил, жижиг, дунд үйлдвэр (БЖДҮ) болон жижиглэнгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчид баримтлах эко шошгоны нэгдсэн стандарт боловсруулж, эко шошгожуулалтын шинэ онлайн платформ бий болгож, санхүүгийн дижитал хэрэгслүүдтэй эко шошгожуулах үйл явцыг холбож өгнө.

Дэлхий даяар хүний хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний гуравны нэг орчим нь (жилд ойролцоогоор 1.3 тэрбум тонн)¹ хаягдаж байхад 1 тэрбум орчим хүн² өлсгөлөнд нэрвэгдэж байдаг байна. Хүнсний сүлжээ нь зөвхөн нийгэм, ёс суртахууны асуудал бус байгаль орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой. Хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хадгалалтад байгалийн асар их нөөцийг ашигладаг ба хүнсний хог хаягдал дангаараа хүлэмжийн хийн ялгарлын 8 орчим хувийг бүрдүүлдэг зэргээр уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлсөөр байна. Иймд хүнсний хог хаягдлын тогтвортой менежментийн асуудал нь нийгэм, байгаль орчин, эдийн засгийн аль ч үүднээс зайлшгүй анхаарах зүйл юм. Европын Байгаль Орчны Агентлагийн мэдээлсэнээр хүнсний хог хаягдлын гол эх үүсвэр нь айл өрх (42%), хоол боловсруулах болон үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд (39%), зочид

¹ Food waste refers to the decrease in the quantity or quality of food resulting from decisions and actions by retailers, food service providers and consumers (SOFA, 2019).

² <http://www.fao.org/food-loss-and-food-waste/en/>

буудал, ресторан (14%), эцэст нь бөөний болон жижиглэнгийн худалдаачид, хүнсний дэлгүүр, супермаркет, томоохон дэлгүүрүүд (5%) байна.³

2022 оны 4 сарын 28-нд Бизнес Мэридиан Консалтинг ХХК нь Хөгжлийн Шийдэл ТББ-тай “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн нарийвчилсан судалгааг хийхээр гэрээ байгуулсан ба суурь судалгааны зорилго нь уг төслийг хэрэгжүүлэх талуудыг шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Судалгааны ажил нь төслийг хэрэгжүүлэх Улаанбаатар, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь аймгуудын (i) хөдөө аж ахуй, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын (ХААХУУҮС) өнөөгийн байдал, (ii) салбарын чадавх (iii) тойрог эдийн засгийн туршлага, (iv) нэмүү өртгийн сүлжээ, (v) олон улсын тэргүүн туршлага гэсэн үндсэн таван хэсгээс бүрдэх ба судалгааны үр дүнд нэн тэргүүнд хөгжүүлэх дэд салбар, хамгийн оновчтой нэмүү өртгийн сүлжээг (НӨС) тодорхойлж, зөвлөмжүүдийг боловсруулсан.

ХААХУУҮС-ын өнөөгийн нөхцөл байдал

ХААХУУҮС-ын өнөөгийн нөхцөл байдлыг газар тариалан, зөгийн аж ахуй (ЗАА), хүнс, ус ундаа үйлдвэрлэл (ХУУҮ), жижиглэнгийн худалдаа үйлчилгээний (ЖХҮ) гэсэн дэд салбарын хүрээнд нарийвчлан судалсан. Монгол улсын газар тариалангийн дийлэнх хэсгийг үр тариа эзэлдэг бөгөөд хүн амын хоногийн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний 63 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байгаагаас харахад энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний хөгжил бусад дэд салбаруудтай харьцуулахад өрсөлдөхүйц давуу талтай болжээ. Харин төмс, хүнсний ногоо, нарийн ногоо, жимсний тариалалт нь улсын хэмжээнд 10 хүрэхгүй хувийг эзэлдэг ба тэдгээрийг боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, тариаланчдын чадавх хязгаарлагдмал, ижил төрлийн импортын бүтээгдэхүүний үнэ хямд байдаг зэргээс шалтгаалан өрсөлдөх чадвар нь сул байна. Төсөл хэрэгжих Сэлэнгэ аймгийн хувьд улсын газар тариалангийн хэмжээний 33 хувийг, харин Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймгууд маш бага хувийг эзэлдэг.

Салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал бэрхшээлийг үнэлүүлэх зорилгоор 742 бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, жижиглэнгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчидээс судалгаа авсан. Тэдний хувьд засгийн газрын дэмжлэг туслалцаа, санхүүжилтийн боломжууд хязгаарлагдмал байдаг, бага хүүтэй, урт хугацаатай зээлийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага өндөр байдаг зэргийг нэрлэж байна. Мөн салбарын хувьд тулгамдаж буй зайлшгүй анхаарлаа хандуулах зүйл бол мэргэшсэн хүний нөөцийн олдоц тааруу байгаа явдал бөгөөд, үүнтэй холбоотойгоор мэдлэг мэдээллээр хангах, сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ шаардлага өндөр байна.

³ <https://www.eea.europa.eu/media/infographics/wasting-food-1>

ХААХУУҮС-ын чадавх

Манай улс “Органик хүнсийг баталгаажуулах тэмдэг”, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн нөхцөл, аюулгүй байдлыг баталгаажуулах “Хөдөө аж ахуйн зохистой дадал” (ХААЗД) болон хүнсний аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдлын олон улсын стандартуудыг нэвтрүүлж эхлээд байна. Гэвч эдгээр стандартуудыг хангасан, баталгаажуулалт хийсэн байгууллагуудын тоо цөөн юм. Гэрчилгээ авах үйл явцыг МҮХАҮТ-аас олгодог Органик бүтээгдэхүүн эко тэмдэг, ХХААХҮЯ-аас олгодог Органик хүнсийг баталгаажуулах тэмдэг хоёрыг харьцуулан судлахад Органик бүтээгдэхүүн эко тэмдэг авах үйл явц нь цөөн үе шаттай, үргэлжлэх хугацаа болон зардлын хувьд бага байна. Харин Органик хүнсийг баталгаажуулах тэмдгийн хамтын баталгаажуулалтын үйл явц нь бэлтгэл үе шат, шаардлагуудыг хэрэгжүүлэх үйл явц нь тус бүрдээ 1, 1 жилийн хугацаа шаардлагатай, БЖДҮ эрхлэгч нараас оролцоо, тууштай байдлыг шаарддаг байна. Баталгаажуулалтад бага хамрагдаж байгаа нь үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, чадвартай холбоотой байгааг мэргэжилтнүүд мөн дүгнэж байна. Эко шошгожуулалтын тухай ойлголт, хандлагыг тодорхойлох судалгааны үр дүнгээс харахад БЖДҮ болон ЖХҮ эрхлэгчдийн дийлэнх нь эко шошгожуулалтын талаарх мэдлэг өнгөц, 18% нь огт сонсож байгаагүй хэдий ч эко шошгожуулалт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний найдвартай байдлыг нэмэгдүүлж, худалдан авалтад эерэг нөлөөтэй болохыг хүлээн зөвшөөрч байна.

Мөн энэ хэсэгт судалгаанд оролцогч байгууллагуудын сургалт, санхүүжилтийн хэрэгцээ болон байгууллагын чадавхыг үнэлсэн. Сургалтын хувьд зөгийн аж ахуй эрхлэгчдийн хог хаягдлыг цуглуулах, ангилах, дахин боловсруулах тогтолцооны талаархи тогтмол сургалт явуулж байдал болон сургалт зөвлөх үйлчилгээ авахдаа бусад аж ахуйн нэгжүүдтэй хамтардаг байдал нь хамгийн өндөр үнэлэгдсэн ба түүний дараа хүнс, ус ундаа үйлдвэрлэгчид эрэмбэлэгдэж байна.

Оролцогчдын дийлэнх нь 11-50 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хэрэгтэй гэж хариулсан ба санхүүжилтэд тулгамдаж буй гол асуудал нь нэг талаас санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал, барьцаа хөрөнгө, зээлийн хүү зэрэг санхүүжилт авахад тулгардаг хүндрэлүүд нь Монгол улсын санхүүгийн салбарын зохицуулалттай илүү холбоотой байдаг бол нөгөө талаас БЖДҮ-н хувьд төсөл бичих ур чадвараа нэмэгдүүлэх хэрэгцээ байна гэж харж байна.

Судалгаанд оролцогчдын өөрийн үнэлгээнээс харахад тэд өөрсдийн байгууллагынхаа дүр төрх, байгууллагын соёлыг хүчтэй, технологийг харин хамгийн сул тал гэж үзжээ. Мэдээллийн технологийн мэдлэг, чадвар, зайнаас ажиллах болон дижитал баримт бичгүүдтэй ажиллах чадвар маш багаар үнэлсэн байна. Тиймээс цаашид эко шошгожуулалтын үйл явцыг онлайн-аар зохион байгуулах бол оролцогчдын дижитал ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, чиглүүлэх үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно.

Тойрог эдийн засгийн туршлага

Судалгааны ажлын зорилгын нэг хэсэг нь Монголын БЖДҮ байгууллагуудын тойрог эдийн засгийн (ТЭЗ) тухай ойлголт болон өдөр тутмын үйл ажиллагааны туршлагыг судалж, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, зөрүүтэй байдлыг илрүүлэх юм. Үүний тулд хувь хүн, бизнесийн байгууллагууд стратеги зорилго, дотоод зохион байгуулалтандаа ТЭЗ-ийн ойлголтыг хэрхэн тусгасан эсэх, хэрэгжүүлж байгаа эсэх болон хүрээлэн буй орчиндоо ээлтэй байх хамгийн энгийн эко туршлагауудыг хэвшүүлсэн эсэхийг үнэлсэн.

ТЭЗ нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засаг гэсэн олон хэмжээст ойлголт бөгөөд нөөцийн хэрэглээг бууруулах, үндсэн үйл ажиллагааны дамжлагыг оновчлох, эцсийн бүтээгдэхүүний хэрэглээг уртасгах, дахин ашиглах, дахин боловсруулах зэрэг өргөн цар хүрээтэй зорилго агуулдаг. Энэ утгаараа, ТЭЗ-ийн хамгийн сайн туршлагыг хэрэгжүүлсэн байдал нь салбар тус бүрийн хувьд харилцан адилгүй байна. Үнэлгээг (1) ерөнхий стратеги төлөвлөгөө байгаа эсэх, үндэсний стандартууд болон төсөл хөтөлбөрт нэгдсэн байдал, ТЭЗ-ийн зорилтыг хэмжих үзүүлэлт ашиглах түвшин, (2) өдөр тутмын үйл ажиллагаанд тойрог эдийн засгийн туршлагауудыг хэвшүүлсэн түвшингээр нь тодорхойлох зорилгоор хийсэн. Энэ талаар дараах чухал үр дүнгүүдийг онцолж байна. Үүнд:

- БЖДҮ эрхлэгчид зөвхөн дэд салбарынхаа ерөнхий буюу шууд хамааралтай дүрэм журмыг бусад стандартуудаас илүү сайн мөрддөг, харин хүрээлэн буй орчин, хэмнэлттэй эдийн засгийн дүрэм журамд төдийлөн анхаарлаа хандуулдаггүй.
- Зөгийн аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн хувьд хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагааг хөгжүүлэх болон хэрэгжүүлэх төсөл төлөвлөгөөгөө санхүүгийн хэрэгцээ, салбарын өсөлт, чиг хандлагатай хөл нийлүүлэх зорилгоор боловсруулдаг.
- ХУУҮ, ЖХҮ үзүүлэгчид үндэсний хэмжээнд түгээмэл ашиглагддаг таван стандартыг дундаж түвшинд дагаж мөрддөг нь бусад дэд салбарын бизнесийн байгууллагуудаас илүү байна.
- ХУУҮ эрхлэгчдийн хувьд төсөл төлөвлөгөөтэй байх шаардлага хангалтгүй.
- ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлэх зорилтууд болон түүнийг хэмжих гол үзүүлэлт дээрх 4 дэд салбарт нэвтрээгүй.

ТЭЗ-ийн 7R зарчмын татгалзах, дахин загварчлах/бодох, бууруулах, дахин хэрэглэх, засах, дахин үйлдвэрлэх, дахин боловсруулах туршлагаууд бизнесийн байгууллагад хэрхэн хэрэгжиж байгааг тоймлон харуулсан. Байгууллагын худалдан авалтын үйл ажиллагаанд /орц, түүхий эд материал/ ихээхэн анхаарал хандуулж, бэлтгэн нийлүүлэгчдэд өндөр шаардлага тавьж, хэрэгцээгүй, эдийн засгийн хэмнэлтгүй зүйлсээс татгалзах тал дээр туршлага сайн. Мөн засвар үйлчилгээ, байнгын цэвэрлэгээг зохих түвшинд дотооддоо хэрэгжүүлдэг хандлага нь сайн. Нөөцийн ашиглалтыг үйлдвэрлэлийн явцад бууруулах туршлагыг зарим талаараа хэрэгжүүлдэг. Зах зээлд, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, нийгэмд учруулах сөрөг нөлөөг бууруулах технологийн чадвар сул ба бараа бүтээгдэхүүнээ дахин загварчлах, дахин эргэж бодох туршлага хангалтгүй. Мөн түүнчлэн, дахин хэрэглэх,

өөр зориулалтаар ашиглах болон үйлдвэрлэх туршлага салбаруудын хувьд мөн хангалтгүй түвшинд байна.

Нэмүү өртгийн сүлжээ

Газар тариалан, зөгийн аж ахуй, хүнс ус ундаа үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний дэд салбаруудын нэмүү өртгийн сүлжээний шинжилгээг орц, үйл ажиллагаа, гарцыг тодорхойлж, нэмүү өртгийн сүлжээний зураглал, газар зүйн байршил, НӨС-н дэх саад бэрхшээлийг тодорхойлох шинжилгээ (Bottle neck analysis) хийсэн. Салбарын өрсөлдөөний нөхцөл байдлыг харвал бүтээгдэхүүний нэр төрөл бага, дотоодын бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөөн бага, аж ахуйн нэгжүүд техник тоног төхөөрөмжийн хүчин чадал сул, стандарт мөрдөлт сул, хэрэглэгчийн хэрэгцээнд тааруулж өөрчлөлт хийх уян хатан чадвар бага, өөрсдийн тогтсон борлуулалтын суваггүй, бөөний борлуулагч нарт нийлүүлдэг, үйлдвэрлэлийн тоо хэмжээ бага, өртгийн хувьд давуу тал үүсээгүй, өргөжилтийн хэмнэлт хийх боломж бүрдээгүй зэргээс харвал өрсөлдөөний түвшин анхан шатанд байна. БЖДҮ-үүдийн өнөөгийн өрсөлдөх чадвар нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлээ тэлэх, цаашлаад ногоон эдийн засгийн туршлагауудыг нэвтрүүлэх боломжуудыг хязгаарлаж байна.

НӨС-ний бүх үе шатуудад саад бэрхшээлүүд илэрч байна. Үүнд: зах зээлд танигдаагүй, хэрэглэгчид дотоодын бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байдаг боловч бүтээгдэхүүн үйлчилгээ нь тавигдах шаардлагуудыг бүрэн хангадаггүй, бүтээгдэхүүний борлуулалтын суваг хязгаарлагдмал, үйл ажиллагаанд урт хугацааны үр ашигтай байх харилцаа холбоог бий болгож хараахан чадаагүй, логистикийн асуудлаас үүссэн хаягдал ихтэй, манай улс өргөн уудам нутаг дэвсгэртэй тул тээвэрлэлтийн боломжууд хязгаарлагдмал зэргийг нэрлэж байна.

Олон улсын тэргүүн туршлага

ТЭЗ-ийн туршлагаар дэлхийд тэргүүлэгч 10 улсын хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, засгийн газрын бодлого чиглэл, тэргүүн туршлагауд болон манай улсад хэрэгжүүлэхэд дөхөм туршлага болохуйц ТЭЗ-ийн зарчмуудыг Ази, Европын 15 улс орны, 55 ялгаатай жижиг, дунд хэмжээтэй байгууллагуудын жишээн дээр судалсан.

Олон улсын ТЭЗ-ийн хэрэгжүүлэлтийн стратегиудаас харахад тойрог эдийн засгийг бүхлээр нь олон нийтэд танилцуулахаасаа илүүтэй тусгайлсан хөтөлбөрүүд боловсруулах, урт хугацаанд нэг асуудалд төвлөрөхөд анхаардаг байна. Тухайлбал: Швед, Хятад, Япон, Солонгос улсууд бизнесийн байгууллагуудынхаа чадамжид суурилсан тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Бизнесийн байгууллагуудын сайн туршлага, жишээнүүдийн хамгийн түгээмэл хэлбэр нь хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах тал дээр анхаарлаа илүүтэй хандуулсан нь харагдаж байна.

ТЭЗ-ийн туршлага, бодлого хэрэгжилт, НӨС, эко шошгожуулалтын талаарх мэдлэг, байгууллагын чадавх, сургалтын хэрэгцээ, санхүүжилтийн боломжууд гэсэн долоон

шалгуур хүчин зүйлүүдээр ХААХУУҮС-ын өөрийн үнэлгээний үр дүнд дэд салбаруудыг үнэлсэн ба жигнэсэн дундаж үнэлгээгээр хамгийн өндөр үнэлгээг авсан хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн дэд салбарыг нэн тэргүүн хөгжүүлэх боломжтой дэд салбараар нэрлэж байна. Цаашлаад хоёрдугаарт ЖХҮ, гуравдугаарт ЗАА, эцэст нь газар тариалангийн дэд салбар эрэмбэлэгджээ.

Сургалт, зөвлөх үйлчилгээний санал зөвлөмжийг боловсруулахдаа ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлсэн байдлыг үнэлэх Тойрог эдийн засгийн төлөвшлийн загвар (Circular Maturity Model)-г ашиглан дээр дурдсан дэд салбаруудыг ангилсан. ЖХҮ-ний дэд салбар нь төлөвшлийн түвшин хамгийн бага буюу 0 түвшинд, газар тариалангийн салбар I түвшин, ХУУҮ болон ЗАА дэд салбарууд II түвшинд хэсэгчилсэн байдлаар хүрсэн нь тодорхойлогдсон ба эдгээр түвшингөөс хамаарч ялгаатай байдлаар төслийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Эцэст нь, хүлэмжийн хийг бууруулах, БЖДҮ эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт зөвлөх үйлчилгээг оновчтой хэрэгжүүлэх, ногоон гэрчилгээ олгох үйл ажиллагаа, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах ажлууд гэсэн таван чиглэлд санал зөвлөмжийг боловсрууллаа.


1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны хүрээ ба хүлээгдэж буй үр дүн

Судалгаа нь Улаанбаатар, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь аймгийн бүс нутаг дахь ХААХУУҮС-ын сонгогдсон дэд салбаруудын Бичил Жижиг Дунд Үйлдвэрлэл (БЖДҮ) эрхлэгчдийн нөхцөл байдал, чадавх, байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх хандлага, ТЭЗ-ийн хэрэгжилтийн иж бүрэн дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөхөд чиглэсэн.

Судалгаа шинжилгээний ажлыг (i) Хөдөө аж ахуй, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын (ХААХУУҮС) салбарын өнөөгийн байдал, (ii) Салбарын чадавх (iii) ТЭЗ-ийн туршлага, (iv) Нэмүү өртгийн сүлжээ (НӨС), (v) Олон улсын тэргүүн туршлага гэсэн үндсэн таван хэсэгт хувааж, үр дүнг тодорхойлсон ба доорх зурагт харууллаа. Монгол Улсын ХААХУУҮС-ыг тодорхойлсон судалгааны үр дүнгүүдийг олон улсын тэргүүн туршлагуудтай харьцуулж, нэн тэргүүнд хөгжүүлэх дэд салбар, хамгийн оновчтой НӨС, зөвлөмжүүдийг боловсруулсан.

График 1. Судалгааны хамрах хүрээ



Судлагдсан байдлын судалгаагаар *тойрог/ногоон эдийн засаг, эко шошгожуулалт* гэсэн түлхүүр үгсийг сонгон авч, хоёрдогч өгөгдөлд суурилан шинжлэх ухааны ололт амжилт, чиг хандлага, ТЭЗ-аар тэргүүлэгч улс орнуудын тэргүүн туршлага, судалгааны ажлуудыг тодорхойлсон. Олон улсын сайн туршлагуудыг анхдагч өгөгдөл цуглуулах судалгааны суурь ойлголтод ашиглахаас гадна олон улсын тэргүүн туршлага (бүлэг 6) хэсэгт дэлгэрүүлж харуулсан. Судлагдсан байдал хамгийн өндөртэй, ТЭЗ-ийн туршлагаар дэлхийд тэргүүлэгч 10 улс орнуудын хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, засгийн газрын бодлого чиглэл болон Ази, Европын 15 улс орны, 55 ялгаатай жижиг, дунд хэмжээтэй байгууллагуудын жишээг судалсан.

1.2. Өөрийн үнэлгээний асуулга

1.2.1. Судалгааны дизайн

ХААХУУҮС-ын БЖДҮ эрхлэгч нарын өөрийн үнэлгээний асуулга бүхий судалгааны үр дүнг (i) ХАА, хүнс, ус ундаа үйлдвэрлэгч нарын байгаль орчинд ээлтэй байх, эко шошгожуулалтын талаарх ойлголт, ТЭЗ-ийн зарчмуудын хэрэгжилтийн түвшин, туршлагауудын нэвтрүүлэх чадавхыг тодорхойлох; (ii) БЖДҮ эрхлэгч нарын санхүүгийн хэрэгцээг тооцож, тулгамдаж буй бэрхшээлүүдийг илрүүлэх; (iii) цаашид сайжруулах шаардлагатай асуудлуудыг илрүүлэх; (iv) сонгосон бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа БЖДҮ нарын газар зүйн байршлыг гаргах; (v) ХААХУУҮС-ын нэн тэргүүнд хөгжүүлэх дэд салбарыг тодорхойлох; (vi) нэмүү өртгийн сүлжээний зураглал гаргахад ашиглана. Мөн төслийн хүрээнд ТЭЗ, эко шошгын үзэл баримтлалыг БЖДҮ нарт танилцуулах, чадавхыг хөгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлох суурь болж өгнө.

Асуулгын загварыг монгол хэл дээр боловсруулж, тайлан бэлтгэх явцад англи хэл рүү орчуулсан. Анхны хувилбарын найруулга, үг үсгийн алдааг хянаж, ойлголтын зөрүү, үнэлгээний алдаа үүсэж байгаа эсэхийг шалгах зорилгоор туршилтаар бөглүүлж засваруудыг хийсэн. 2022 оны 5 дугаар сард бэлтгэгдсэн өгөгдөл цуглуулагч нар туршилтаар 40 ярилцлага хийсэн. Үр дүнд нь асуулгын дараалал, логик хамаарал, үг үсэг найруулгын алдаануудыг дахин засварлаж эцсийн хувилбарыг бэлэн болгосон.

Өөрийн үнэлгээний асуулга (ӨҮА)-г олон улсын байгууллагуудын зөвлөмж, судалгааны ажлуудад болон дотоодын дүрэм журам, зохицуулалт, судалгааны ажлуудад суурилан боловсруулсан. Асуулгад салбарын онцлогийг тусгах зорилгоор дөрвөн төрлийн 40-47 асуулттай, 130-135 хүчин зүйлс үнэлсэн өөрийн үнэлгээний асуулга боловсруулсан. ӨҮА-ыг бүрэн эхээр нь тус тайлангийн хавсралтаар хүргүүлсэн.

Хүснэгт 1. Асуулгын төрлүүд

| Асуулга | Дэд салбар |
|---|---|
| Газар тариалан эрхлэгчдийн өөрийн үнэлгээний асуулга | Газар тариалан |
| Зөгийн аж ахуйн эрхлэгчдийн өөрийн үнэлгээний асуулга | Зөгийн аж ахуй |
| Үйлдвэрлэгчдийн өөрийн үнэлгээний асуулга | Хүнс ус ундаа үйлдвэрлэл |
| Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн үнэлгээний асуулга | Хоолны үйлдвэрлэл Жижиглэн худалдаа үйлчилгээ Агуулах Тээвэр |

Хүснэгт 2. ӨҮА-н агуулга

| Хэсэг | Тайлбар |
|-------|--|
| Нүүр | Өөрийн үнэлгээг хийсэн газар зүйн байршил, огноо, хугацаа, үнэлгээний ажилтны дугаар зэрэг мэдээллийг багтаасан. |

| | |
|----------------------------------|---|
| I. Ерөнхий мэдээлэл | Үйл ажиллагааны чиглэл, өмчийн хэлбэр, зохион байгуулалтын хэлбэр, үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа, ажилтны тоо, жилийн дундаж орлого болон салбарын ерөнхий нөхцөл байдлыг үнэлсэн нийт 22 асуулт |
| II. ЭШ тухай ойлголт | Эко шошгожуулалтын талаар ойлголтыг тодруулах 11 асуулт |
| III. ТЭЗ-ийн туршлага | Стандартуудын хэрэгжилт, байгууллагын зорилго, зорилт, төлөвлөгөө, тойрог эдийн засгийн туршлагаудын хэрэгжилт, дижитал техник технологийн ашиглалт, байгууллагын чадавх зэргийг үнэлэх нийт 62-67 асуулт |
| IV. Сургалт, санхүүгийн хэрэгцээ | Сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ, төрлүүд, санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, санхүүжилтэд тулгардаг хүндрэл бэрхшээл, технологийн чадавх зэргийг тодруулах хаалттай болон нээлттэй 20 асуулт |
| V. Хувийн мэдээлэл | Оролцогчдын нас, хүйс, боловсрол, албан тушаал, ажилласан жил зэрэг хувийн мэдээлэл, өрхийн аж ахуйд оролцогч өрхийн гишүүдийн тоо, капиталын хэмжээ, хаяг байршил, капиталын эзэмшил, төслийн хүрээнд цаашид мэдээлэл, зөвлөгөө, сургалтад хамрах эсэхийг тодруулсан 15 асуулт |

1.2.2. Судалгааны арга

Өөрийн үнэлгээний асуулга нь оролцогчийн ажлын байран дээрээс нүүр тулсан ярилцлагын аргаар авсан болно. Сум орон нутгийн газар зүйн байршлын алслагдсан байдлаас шалтгаалан зарим ярилцлагыг утсаар хийсэн болно. Нийт түүврийн 5.7 хувийг онлайнаар, 14.7 хувийг утсаар, үлдсэн 79.6 хувийг биечилсэн ярилцлагын хэлбэрээр өгөгдөл цуглуулсан.

ХААХУУҮС-ын судалгааг хийх түүврийг бүрдүүлэх ажилд тулгарсан томоохон сорилт бол салбарын үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тоон мэдээлэл, хаяг байршлын нэгдсэн мэдээллийн сан байхгүй, ААН-ийн бүртгэлтэй хаяг зөрөх, хувь хүний гэрийн хаяг дээр бүртгэлтэй байх зэрэг хүндрэлүүд гарсан тул судалгаанд оролцогчдыг товлох боломж бүрдэхгүй байсан болно. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор судалгааны баг холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай холбогдож бүртгэлтэй ААН байгууллагуудын мэдээлэл авах хүсэлтүүдийг гаргаж утас, хаяг байршлын жагсаалтуудыг гаргуулж авсан. Үүнд НХХАА-н газраас 78, ХХААХҮЯ-с 427, Сэлэнгэ аймгийн ХХАА-н газраас 114, Орхон аймгийн ХХАА-н газраас 93, Зөгийчдийн холбооноос 40 байгууллага, хувь хүний жагсаалт ирсэн. Жагсаалтыг хүлээн авсны дараагаар өгөгдөл цуглуулагч нар жагсаалтад байгаа утсаар нэг бүрчлэн залгаж, төслийн танилцуулгыг хийж, судалгаанд оролцуулах хүсэлтээ илэрхийлсэн. Жагсаалтын дагуу нийт 763 утасны дуудлага хийснээс 519 буюу 68%, нь үнэлгээнд хамрагдахаас татгалзсан, эсвэл үйл ажиллагааг зогсоосон, сонгосон салбарт хамааралгүй, холбогдох мэдээлэл нь буруу, алдаатай зэрэг дуудлагууд байсан. Үлдсэн 106 буюу 14% нь судалгаанд оролцоход зөвшөөрсөн.

1.2.3. Түүврийн хэмжээ

ХААХУУҮС-т улсын хэмжээнд нийт 42,233 байгууллага болон хувь хүн үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээрт газар тариалан эрхлэгч 17,459 өрх ба 423 аж ахуйн нэгж, 58 гурилын үйлдвэр, 870 гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, 162 ус ундааны үйлдвэр, зөгийн аж ахуй эрхлэгч 680 өрх ба 36 байгууллага, 14,078 хүнсний ЖХҮ, 8,467 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага тус тус бүртгэлтэй байна.

ӨҮА-д Улаанбаатар хотын 9 дүүрэг, Өмнөговь, Орхон, Сэлэнгэ аймгийн ХААХУУҮС-ын 742 бичил, жижиг, дунд хэмжээтэй байгууллагууд оролцсон. Үүнээс 444 үйлдвэрлэл, 298 жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ, тээвэр, агуулахын үйлчилгээ эрхлэгчид болно. Түүврийн нийт хэмжээ нь эх олонлогийг бүрэн төлөөлж чадна гэж үзлээ. Сонгон авсан бүс нутгийн хэмжээнд түүврийн эх олонлогийг 18943, түүврийн итгэх түвшин 99% гэж үзээд тооцоолоход түүврийн хүлээн зөвшөөрөгдөх доод хэмжээ 644 байгаа тул тус судалгаанд оролцсон нийт 742 өгөгдөл түүврийн найдвартай байдлыг хангаж, үр дүнг хүлээн зөвшөөрч болохыг илтгэж байна. Өөрийн үнэлгээнд оролцсон байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг хоёрдугаар бүлгээс харах боломжтой.

Хүснэгт 3.Түүврийн хэмжээ

| Дэд салбар | Улаанбаатар хот | Сэлэнгэ аймаг | Орхон аймаг | Өмнөговь аймаг | Нийт |
|---------------------------------|-----------------|---------------|-------------|----------------|------------|
| Газар тариалан | 136 | 57 | 33 | 3 | 229 |
| Зөгийн аж ахуй | 3 | 42 | 10 | 0 | 55 |
| Хүнс, ус ундаа үйлдвэрлэл | 106 | 21 | 27 | 6 | 160 |
| Жижиглэнгийн худалдаа үйлчилгээ | 94 | 21 | 19 | 6 | 140 |
| Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ | 68 | 18 | 24 | 4 | 114 |
| Агуулах | 4 | 13 | 3 | 0 | 20 |
| Тээвэрлэлт | 7 | 8 | 9 | 0 | 24 |
| Нийт | 418 | 169 | 125 | 19 | 742 |

Улаанбаатар хот нийт түүврийн 56%, Сэлэнгэ аймаг 24%, Орхон аймаг 17%, Өмнөговь аймаг 3 хувийг тус тус бүрдүүлж байна. Тэдгээрийн дийлэнх нь (38%) нь 5 жил хүртэл хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа залуу компаниуд байгаа бол 14% нь 21 дээш жил байна. Нийт оролцогч байгууллагуудын 96% нь дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд ба зохион байгуулалтын хэлбэрийн хувьд хувиараа (61%), Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) (35%), ХК, хоршоо, нөхөрлөл (4%) гэсэн хэлбэртэй байгаа. Түүврийн дийлэнх хэсгийг 10 хүртэл ажилтантай бичил байгууллагууд (77%) бүрдүүлж байна. Байгууллагуудын жилийн дундаж орлогоор нь байгууллагын хэмжээг тодорхойлсон ба 299 сая төгрөг хүртэл орлоготой аж ахуйн нэгжийг (ААН) бичил (89%), 300 сая-1 тэрбум төгрөг хүртэл орлоготой бол жижиг байгууллага (8%), 1 тэрбум төгрөгөөс дээш орлоготой бол дунд байгууллага (үлдсэн 4%) болно. Түүврийн нэгтгэлийг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2. Үнэлгээнд оролцогч байгууллагуудын мэдээлэл

| | | | | | |
|-----------------------------------|------------------------------|-----------|--|--------------------------------|-----|
| Үйл ажиллагааны чиглэл | Тариалан | 31% | Байршил | Улаанбаатар хот | 56% |
| | Зөгийн аж ахуй | 7% | | Сэлэнгэ аймаг | 24% |
| | Хүнс, ус ундаа үйлдвэрлэл | 22% | | Орхон аймаг | 17% |
| | Жижиглэнгийн худалдаа | 19% | | Өмнөговь аймаг | 3% |
| | Хоол үйлдвэрлэл, Үйлчилгээ | 15% | Үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа | 1 жил хүртэл | 10% |
| | Агуулах | 3% | | 1-5 жил | 28% |
| | Тээвэрлэлт | 3% | | 6-10 жил | 19% |
| | | 11-15 жил | | 18% | |
| Өмчийн хэлбэр | Дотоодын хөрөнгө оруулалттай | 96% | | 16-20 жил | 11% |
| | Гадаадын хөрөнгө оруулалттай | 1% | | 21 болон түүнээс дээш жил | 14% |
| | Холимог | 3% | Ажилтны тоо | 1-10 ажилтан | 77% |
| Зохион байгуулалтын хэлбэр | Хувиараа | 61% | | 11-50 ажилтан | 20% |
| | ХХК | 35% | | 51-200 ажилтан | 2% |
| | Нөхөрлөл | 1% | | 201 болон түүнээс дээш ажилтан | 1% |
| | Хоршоо | 3% | Жилийн дундаж орлого | 99 сая төгрөг хүртэл | 75% |
| | Нээлттэй ХК | 1% | | 100-299 сая төгрөг | 14% |
| | | | | 300 сая - 1 тэрбум төгрөг | 8% |
| | | | | 1 тэрбум төгрөгөөс дээш | 4% |

1.2.4. Судалгааны хуваарь

Судалгааны асуулгыг 2022 оны 5 сард боловсруулж дууссан ба судалгааны өгөгдөл цуглуулах ажил 2022 оны 6 дугаар сарын 6 өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 6 өдөр хүртэл явагдсан. Түүврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн БЖДҮ эрхлэгч нарыг нэмж оруулсан тул өгөгдөл цуглуулах ажил долоо хоногоор хойшилсон болно.

1.2.5. Судалгааны хяналт

Судалгааны өгөгдөл цуглуулах ажилд 12 хүн оролцсон бөгөөд асуулга хариуцсан ажилтан явцын хяналтыг тогтмол хийж явсан. Өгөгдөл цуглуулах явцын хяналтыг тавьж, алдаа гарах магадлалыг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Асуулга

боловсруулж дууссаны дараагаар өгөгдөл цуглуулагч нарт судалгааны зорилго, асуулгын асуулт, ярилцах аргыг танилцуулах сургалтыг явуулсан. Сургалтаар асуулгын загвар, асуулт бүрийн үнэлгээний онцлогуудыг голчлон тайлбарласан. Мөн судалгаанд оролцогчийг хөтлөх, хариултад нөлөөлөхгүй байх зарчмуудыг танилцуулсны дараагаар өгөгдөл цуглуулагч нар туршилтаар ярилцлага хийж үзсэн.


Судалгаанд оролцох боломжит БЖДҮ эрхлэгч нарын нэр, утасны жагсаалтыг урьдчилан бэлдсэн ба өгөгдөл цуглуулагч нар тус жагсаалтын дагуу уулзах боломжтой цаг, газрыг товлох зорилгоор өмнөх өдөр нь болон тухайн өдрөө 2 цагийн өмнө утсаар ярьж баталгаажуулж байсан. Ярилцлага оролцогчийн болон салбарын онцлогоос шалтгаалан 15 минутаас 60 минут, дунджаар 30 минут үргэлжилсэн.

Өгөгдөл цуглуулах ажлын ахлагч өдөр бүр бөглөсөн асуулгын бүрэн хариулсан эсэх, алдаатай хариулт байгаа эсэх хяналтыг тавьж, шаардлагатай бол нэмэлт мэдээлэл авч залруулж байсан. Гүүгл хүснэгтийн тусламжтайгаар өгөгдөл цуглуулах үйл явцад хяналт тавьж ажилласан ба түүнийг зурагт харуулав.

Зураг 1. Өгөгдөл цуглуулах явцын хяналт


| | A | B | C | D | E | F | G | H |
|----|-------------------|------------------------------|-------------------------------------|---|--|--|--|---|
| 1 | | Судалгааны дугаарыг бичээрэй | Аж ахуйн этгээдийн нэрийг бичнэ үү? | Тухайн этгээдтэй холбогдох утасны дугаар байсан бол бичнэ үү? | Тухайн этгээдийн үйл ажиллагааны түвшинг сонгоно үү? | Тухайн этгээдийн үйл ажиллагааны төрлийг сонгоно үү? | Тухайн этгээдийн хамаарах бүсийг сонгоно үү? | Боломжтой бол тухайн этгээдийн байршлын аман хаягийг оруулаарай. (СЭЗМС-г "арслангай гүүрний хажууд байдаг цэнхэр сүргүүл" гэдэг шиг) |
| 2 | 6/6/2022 13:52:45 | r-016 | Хувиараа - Энхян | 80056989 Бичил - Micro | | Тариалан - ногоо | Хан-Уул | 19-р хороолол худалдааны төв |
| 3 | 6/6/2022 14:21:17 | R-123 | Мөнх-Эрдэнэ ногооны лангу | 88806792 Бичил - Micro | | Тариалан - ногоо | Хан-Уул | 19-н үйлчилгээний төв - зүүн хэсэг |
| 4 | 6/6/2022 14:35:00 | r-029 | М. Вүжинлхам | 80048900 Бичил - Micro | | Жижиглэн | Хан-Уул | 19-н үйлчилгээний төв - Голын жижиг |
| 5 | 6/6/2022 14:46: | r-010 | Хүслэнт нар сар | 99098870 Жижиг - Small | | Хоолны газар | Хан-Уул | 19-н үйлчилгээний төвийн баруу хэсэг |
| 6 | 6/6/2022 14:48:21 | r-030 | Однаа | 80788811 Бичил - Micro | | Жижиглэн | Хан-Уул | 19-н үйлчилгээний төвийн хойдох хэ |
| 7 | 6/6/2022 14:51:40 | R-019 | С.Алтанцагаг | 95751575 Жижиг - Small | | Агуулах | Чингэлтэй | Хүчит шонгор ногооны 11 павилон |
| 8 | 6/6/2022 14:52:29 | r-020 | Delgetsetsaeg | 86999442 Жижиг - Small | | Агуулах | Чингэлтэй | Huchit shonhor zas ногооны 1r pavilior |
| 9 | 6/6/2022 14:57: | r-008 | Саран бууз/ СХД15-р хор: | 80699669 Бичил - Micro | | Хоолны газар | Сонгинохайрхан | Хархорин |
| 10 | 6/6/2022 15:00: | p-029 | Мөнх-Эрдэнэ - Viva | 95728485 Жижиг - Small | | Хоолны газар | Хан-Уул | 19-н үйлчилгээний төвийн LOF п |
| 11 | 6/6/2022 15:01:34 | r-028 | Чулуундолгор | 99926774 Бичил - Micro | | Жижиглэн | Сонгинохайрхан | Хар хорин |
| 12 | 6/6/2022 15:17:33 | r-005 | Говь дэлгүүр/Хар хорин зүүн | 99690414 Бичил - Micro | | Жижиглэн | Сонгинохайрхан | |
| 13 | 6/6/2022 15:46:24 | r-019 | 7 Буудал CU | 99233484 Жижиг - Small | | Жижиглэн | Чингэлтэй | |
| 14 | 6/6/2022 16:06:01 | r-027 | Ц.Энхмаа | 99160303 Бичил - Micro | | Жижиглэн | Сонгинохайрхан | 5 shag |
| 15 | 6/6/2022 16:15:51 | R-021 | Tulpalag | 88082951 Бичил - Micro | | Жижиглэн | Чингэлтэй | 7 buudal |
| 16 | 6/6/2022 16:30:23 | r-025 | Нарийн ногоо жижиглэн | 86646490 Бичил - Micro | | Жижиглэн | Чингэлтэй | |
| 17 | 6/6/2022 16:31:49 | r-017 | Алтай толгой ХХК | 88121268 Бичил - Micro | | Жижиглэн | Чингэлтэй | |
| 18 | 6/6/2022 16:33:53 | r-024 | Анар хүнсний дэлгүүр | 88695799 Бичил - Micro | | Жижиглэн | Чингэлтэй | 7 buudal zamin esreg tal amar hunsnl delguur |
| 19 | 6/6/2022 16:36:55 | p-026 | Devshill Trade | 88115005, 88085016 Жижиг - Small | | Үйлдвэрлэгч | Баянгол | Сонголонгийн зан дагуу Дэвшил три |
| 20 | 6/6/2022 16:43:34 | r-011 | Сарантуяа - хувиараа тариа. | 99270352 Бичил - Micro | | Жижиглэн | Баянгол | Вокзальн 1000 машинны зогсоол |
| 21 | 6/6/2022 16:44:35 | r-012 | С. Болор - хувиараа борл | 95961339 Бичил - Micro | | Жижиглэн | Баянгол | Вокзальн 1000 машинны зогсоол |
| 22 | 6/6/2022 17:38:18 | r-022 | Тайван зурл ХХК | 99982249 Жижиг - Small | | Үйлдвэрлэгч | Чингэлтэй | ЧД Тр хороо |
| 23 | 6/6/2022 17:44: | r-018 | Нануун зоог | 95381184 Бичил - Micro | | Хоолны газар | Чингэлтэй | Наргал Дэнж ХТ |
| 24 | 6/6/2022 17:46: | r-026 | Гарийн хуушuur | 88942952 Бичил - Micro | | Хоолны газар | Чингэлтэй | 7 буудал Бүрэн плаза Б1 давхар |
| 25 | 6/6/2022 17:48: | r-023 | Арин зоог | 99933762 Бичил - Micro | | Хоолны газар | Чингэлтэй | |
| 26 | 6/6/2022 18:00:11 | R-001 | Л.Бааржаргал | 89801239 Бичил - Micro | | Жижиглэн | Баянгол | Хар хорин |
| 27 | 6/6/2022 18:13: | p-012 | Нарру хоолны газар | 94340070 Бичил - Micro | | Хоолны газар | Баянгол | Барс зах, Нарру хоолны газар |
| 28 | 6/6/2022 18:14:52 | r-014 | Жинс Трейд ХК | 88055810 Жижиг - Small | | Жижиглэн | Баянгол | Барс зах, жинсны лангуу |
| 29 | 6/6/2022 18:16:28 | r-013 | Энхтуяа | 99045673 Жижиг - Small | | Жижиглэн | Баянгол | Барс зах |

Зураг 2. Түүврийн хяналт



Урьдчилан бэлдсэн эксэл хүснэгтэд асуулгын өгөгдлийг шивж оруулсан. 2 хүн өгөгдлийн шивэлтийг шалгаж, хариулт үнэн эсэхэд хяналт тавьж, түүврийн тоог баталгаажуулж, судалгааны явцын талаар өдөр тутам тайлагнаж явсан. Өгөгдөл цуглуулах, шивэх ажилтай зэрэгцүүлэн ажлын даалгаварт өгөгдсөн оролцогчдын газар зүйн байршлыг оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгаанд оролцсон байгууллага, өрх бүрийн үйл ажиллагааны чиглэл ба байршлыг Гүүгл газрын зураг дээр оруулж явсан. Өгөгдөл цуглуулах болон эксэл хүснэгтэд өгөгдөл оруулах ажил дууссаны дараагаар нэгдсэн мэдээллийг SPSS23.0 программ рүү хөрвүүлж статистик шинжилгээг эхлүүлж, дэд салбар, байршил, БЖДҮ-ийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр харьцуулсан шинжилгээнүүд хийсэн.

Зураг 3. Газар зүйн байршлын зураглал



1.3. Ганцаарчилсан ярилцлага

ХААХУУҮС-ын төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүд, холбогдох бизнесийн холбоод, бизнесийн байгууллагуудын төлөөллүүдтэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Нийт 16 төлөөлөлтэй тус бүр нэг цаг орчим нээлттэй ярилцлага хийсэн ба асуулт хариултын хувьд салбарын онцлогоос хамааран харилцан адилгүй явагдсан боловч нийтлэг асуултуудад дурдвал:

- ХАА, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдал
- Үнэлгээнд хамрагдах боломжтой БЖДҮ нарын жагсаалт
- Засгийн газрын бодлого, зохицуулалт
- Эко шошгожуулалтын өнөөгийн нөхцөл байдал
- Ногоон гэрчилгээний үйл явц, хугацаа, зардал, тулгарч буй хүндрэл бэрхшээл
- Байгууллагын зорилго, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, байгууллагын чадамж
- Салбарын хувьд тулгарч бус хүндрэл бэрхшээл
- Санхүүжилтийн хэрэгцээ шаардлага

Хүснэгт 4. Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан хүмүүс


| № | Нэр | Байгууллага | Албан тушаал |
|----|--------------|-------------------------------------|----------------------------------|
| 1 | Мөнгөнцацрал | Мэргэжлийн хяналтын газар | Хэлтэсийн дарга |
| 2 | Мөнхтөр | Сэлэнгэ аймгийн ХХАА-н газар | Газрын дарга |
| 3 | Ундармаа | Нийслэлийн ХХАА-н газар | Газрын дарга |
| 4 | Бат-Өлзий | Орхон аймгийн ХХАА-н газар | Газрын дарга |
| 5 | Онон | ХХААХҮЯ | Газрын дарга |
| 6 | Гэрэлзаяа | ХХААХҮЯ | Хэлтэсийн дарга |
| 7 | Энхтөр | ХХААХҮЯ | Хэлтэсийн дарга |
| 8 | Энхцэцэг | Монголын хүнсчдийн холбоо | |
| 9 | Энхцэцэг | МҮХАҮТ | Гишүүнчлэл хариуцсан мэргэжилтэн |
| 10 | Оюунтуяа | Сэлэнгэ Органик ХББ | Гишүүн |
| 11 | Амарсайхан | Дарханы газар тариалангийн хүрээлэн | Агрономч |
| 12 | Хандаа | ХАА жижиглэнгийн худалдаа | Эзэн |
| 13 | Ундрал | Хаан жимс ЭС БИ ТИ ХХК | Санхүүгийн захирал |
| 14 | Шүрэнцэцэг | Зөгийчдийн холбоо | Тэргүүн |
| 15 | Шижиртуяа | Сэлэнгэ аймгийн зөгийчин | |
| 16 | Санчир | Голомт банк | Зээлийн эдийн засагч |

2. ХАА, ХҮНС, УС УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ҮНЭЛГЭЭ

2.1. ХАА, хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал

2021 онд ХАА салбар нь ДНБ-ийн 13.6 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 4.6 хувиар буурсан байна. ДНБ-д эзлэх хувиар уул уурхайн салбарын дараа ордог хэдий ч хүн амын хөдөлмөр эрхлэлтээр тэргүүлдэг эдийн засгийн хувьд чухал салбар юм. Салбарын суурь судалгааны зорилго нь ХААХУУҮС-ын өнөөгийн нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлох бөгөөд газар тариалан, зөгийн аж ахуй (ЗАА), хүнс, ус ундаа үйлдвэрлэл (ХУУҮ), жижиглэнгийн худалдаа үйлчилгээний (ЖХҮ) дэд салбаруудыг дэлгэрүүлэн авч үзсэн.

График 2. ДНБ, 2021-2022 он



Эх үүсвэр: 1212.mn

Газар тариалангийн салбар. Улсын хэмжээнд 2021 онд 675.0 мянган га талбайд тариалан бэлтгэсэн ба тариалсан талбайн хэмжээ жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Нийт тариалалтын 75 хувийг үр тариа, үлдэх хувийг буудай, төмс хүнсний ногоо, нарийн ногоо, таримал тэжээл эзэлж байна.


Хүснэгт 5. Тариалангийн талбайн хэмжээ

| Аймаг | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|-------------|------------|------------|------------|------------|------------|
| Улсын дүн | 527,019.71 | 511,830.48 | 526,049.77 | 591,157.71 | 675,108.40 |
| Орхон | 2,620.66 | 3,906.19 | 2,972.06 | 3,703.73 | 5,335.80 |
| Өмнөговь | 203.71 | 283.25 | 284.61 | 276.54 | 216.5 |
| Сэлэнгэ | 209,261.83 | 200,029.32 | 207,381.05 | 221,864.72 | 224,902.10 |
| Улаанбаатар | 1,076.07 | 1,051.32 | 1,139.84 | 1,866.04 | 1,493.80 |

Эх үүсвэр: 1212.mn

Улсын хэмжээнд нийт тариалангийн талбайн 34% нь Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудад ногдож байна. Тариалангийн талбай болон тариалалтын хэмжээгээрээ Сэлэнгэ аймаг тэргүүлж байгаа бол Өмнөговь аймагт төмс, хүнсний ногоо тариалалт түлхүү байна.

График 3. Газар тариалангийн бүтээгдэхүүний төрөл, 2021 он



Эх үүсвэр: 1212.mn

Газар тариалан эрхэлдэг байгууллагын тоо жил бүр өсөх хандлагатай ба улсын хэмжээнд 1,615, өрхийн тоо 5,380 байгаагаас Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотуудад түлхүү тархан байршдаг байна.

Хүснэгт 6. Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо

| Аймаг | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|-------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| Орхон | 11 | 14 | 13 | 11 | 14 |
| Өмнөговь | 24 | 25 | 22 | 14 | 17 |
| Сэлэнгэ | 334 | 318 | 322 | 322 | 336 |
| Улаанбаатар | 35 | 57 | 48 | 58 | 56 |
| Нийт | 404 | 414 | 405 | 405 | 423 |
| Улсын дүн | 1,447 | 1,422 | 1,401 | 1,498 | 1,615 |

Хүснэгт 7. Тариалан эрхэлдэг өрхийн тоо

| Аймаг | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|-------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Орхон | 487 | 688 | 402 | 884 | 462 |
| Өмнөговь | 379 | 382 | 101 | 322 | 219 |
| Сэлэнгэ | 3,703 | 3,386 | 87 | 3,698 | 3,397 |
| Улаанбаатар | 1,456 | 1,456 | 1,389 | 1,251 | 1,302 |
| Нийт | 6025 | 5912 | 1979 | 6155 | 5380 |
| Улсын дүн | 15,985 | 15,862 | 14,728 | 16,292 | 17,459 |

Эх үүсвэр: 1212.mn

Зөгийн аж ахуй. 2021 оны байдлаар 36 байгууллага, 680 өрх энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба 13,708 зөгийн бүл тоологдсон байна. Сүүлийн жилүүдийн статистик тооноос харахад зөгийн бүлийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 8. Зөгийн аж ахуйн тоо

| Он | Байгууллага | Аж ахуй | Зөгийн бүлийн тоо |
|------|-------------|---------|-------------------|
| 2010 | 68 | - | 2,255 |
| 2015 | 161 | - | 6,309 |
| 2016 | 60 | 445 | 9,276 |
| 2017 | 31 | 397 | 11,492 |
| 2018 | 75 | 344 | 8,848 |
| 2019 | 56 | 877 | 12,250 |
| 2020 | 31 | 577 | 13,500 |
| 2021 | 36 | 680 | 13,708 |

Эх үүсвэр: ХХААХҮЯ

Гурил, гурилан бүтээгдэхүүн. ХААХУУҮС-ыг гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, даршилсан ногоо жимсний үйлдвэрлэл, ус ундаа шүүсний үйлдвэрлэл бүрдүүлж байна. Гурил, гурилан бүтээгдэхүүн нь хүн амын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний голлох бүтээгдэхүүн ба судалгаагаар хүн амын хоногийн хэрэглээний бүтээгдэхүүний 63 хувийг эзэлж байна. 2020 оны тоолоогоор улсын хэмжээнд 940.0 мян.тн үр тариа тээрэмдэх суурилагдсан хүчин чадал бүхий 58 гурилын үйлдвэр, цех байгаагаас 10 гурилын үйлдвэр цех тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт хүчин чадлын 30 хувийг ашиглаж байна. Нийт 235.1 мян.тн хүчин чадалтай гурил, гурилан бүтээгдэхүүний 870 гаруй үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байгаа ба 57.0 мян.тн гурилан бүтээгдэхүүн 34.4 тн чихэр үйлдвэрлэсэн байна.⁴

Хүснэгт 9. Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, улсын дүнгээр, жилээр

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---------------------------------|-------|------|-------|-------|-------|
| 1 Гурил /мян.тн/ | 209.7 | 209 | 211.1 | 211.6 | 235.1 |
| 2 Гурилан бүтээгдэхүүн /мян.тн/ | 38.7 | 41.9 | 47.2 | 51.1 | 57 |
| 3 Чихэр /тн/ | 34.4 | 51.2 | 53.6 | 45.5 | 34.4 |

Эх үүсвэр: ХХААХҮЯ

Ус ундаа. Монгол Улсын хэмжээнд ундааны 30, савласан усны 90, шүүсний 44 үйлдвэр, давхардсан тоогоор нийт 162 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.⁵

Хүснэгт 10. Төрөл бүрийн ундааны үйлдвэрлэл, мян.л

| | 2016 | 2017 | 2018* | 2019 | 2020 |
|-------------------|----------|----------|----------|----------|----------|
| 1 Цэвэр ус | 59104.7 | 60682 | 73740.3 | 98640.5 | 75568.5 |
| 2 Амтат ус, ундаа | 128887.6 | 148073.4 | 166182.9 | 174894.6 | 204988.4 |
| 3 Шүүс | 55762 | 67003.3 | 64933.7 | 64417.4 | 62602.4 |

⁴ <https://mofa.gov.mn/exp/blog/10/82>

⁵ <https://mofa.gov.mn/exp/blog/10/83>

Үйлчилгээний салбар. Судалгаанд жижиглэнгийн худалдаа үйлчилгээ, хоолны үйлдвэрлэл, тээвэрлэлт, агуулахын газруудыг хамруулсан. Улаанбаатар хотын хэмжээнд хүнсний жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний нийт 6,266 газар байна.

Хүснэгт 11. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээний газруудын тоо, ангилалаар

| № | Ангилал | Дэлгүүрийн төрөл | Хүчин чадлын хэмжээ м.кв | | Нийт |
|-------------|----------|---------------------------|--------------------------|-------------|--------------|
| | | | Нийслэлд | Аймагт | |
| 1 | Том | Хайпермаркет + | 33 | 10 | 43 |
| 2 | Дунд | Супермаркет + | 142 | 175 | 317 |
| 3 | Багавтар | Минимаркет + | 670 | 574 | 1244 |
| 4 | | Ая тухтай дэлгүүр | 84 | 70 | 154 |
| 5 | Бага | Хүнсний дэлгүүр | 3638 | 6332 | 9970 |
| 6 | | ШТС-ын дэргэдэх дэлгүүр | 30 | 69 | 99 |
| 7 | | Мухлаг | 1669 | 582 | 2251 |
| 8 | Хүнсний | Төрөлжсөн барааны дэлгүүр | 520 | 1048 | 1568 |
| 9 | бус бус | Аутлет + | 30 | 3 | 63 |
| 10 | худалдаа | Бутик + | 53 | 1 | 54 |
| Нийт | | | 6899 | 8864 | 15763 |

Эх үүсвэр: ХХААХҮЯ

Мөн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нийтдээ 8,500 орчим ААН үйл ажиллагаа явуулж байгаагийн 47% нь аймаг орон нутагт, 53% нь нийслэл хотод ажиллаж байна. Үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл ресторан зочид буудлын хоолны үйлдвэрлэл (1,570), баар караоке (1,331), цэцэрлэг сургууль (1,600) болон төрийн үйлчилгээний байгууллагуудын хоолны газрууд дийлэнх хувийг эзэлж байна. 31% нь нийгмийн салбарт, 68% нь бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бол, 3200 гаруй нь архи согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй байна. Салбарт нийт 40,000 гаруй ажилтан ажилладаг. Хоолны газрын нийт суудлын тоо 600-650 мянга байна.⁶

Хүснэгт 12. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын байгууллагуудын тоо, ангилалаар

| № | Үйлчилгээний төрлөөр | Аймаг | Нийслэл* | Нийт |
|---|---|-------|----------|------|
| 1 | Ресторан | 256 | | |
| 2 | Зочид буудлын дэргэдэх ресторан | 160 | 1021 | 1570 |
| 3 | Амралтын газрын дэргэдэх ресторан | 133 | | |
| 4 | Кафе | 121 | | |
| 5 | Кофе шоп | 54 | 225 | 400 |
| 6 | Баар /караоке, пиво/ | 386 | 945 | 1331 |
| 7 | Түргэн хоолны газар | 85 | - | 85 |
| 8 | Эмнэлэг, сувилал | 444 | 100 | 544 |
| 9 | Цэцэрлэг, сургуулийн /хувийн болон төсвийн/ | 915 | 685 | 1600 |

⁶ <https://mofa.gov.mn/exp/blog/10/85>

| | | | | |
|-------------|-----------------------------|-------------|-------------|-------------|
| 10 | Дотуур байрны | 273 | 10 | 283 |
| 11 | МСҮТ, их дээд сургуулийн | 51 | 35 | 86 |
| 12 | Үйлдвэр, албан байгууллагын | 119 | | |
| 13 | Цэргийн ангийн | 35 | | |
| 14 | Хорих ангийн | 18 | | |
| 15 | Амралтын газрын | 109 | | |
| 16 | Замын дагуух /гэр,бусад/ | 243 | 1297 | 2369 |
| 17 | Бие даасан | 558 | | |
| 18 | Буфет | 4 | | |
| 19 | Бэйкери, кулиари | 38 | | |
| Нийт | | 4002 | 4465 | 8467 |


Эх үүсвэр: ХХААХҮЯ

2.2. Дэд салбаруудын ерөнхий мэдээлэл

ХААХУУҮС-ын дэд салбаруудын ерөнхий нөхцөл байдлыг үйл ажиллагааны чиглэл, эзэмшил, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаа явуулж буй хугацаа, ажилчдын тоо, жилийн дундаж орлого гэсэн 6 хүчин зүйлээр тодорхойлсон. БЖДҮ, ЖХҮ эрхлэгч 742 байгууллага өөрийн үнэлгээний асуулгад оролцсон.

Газар тариалан эрхлэгчдийн 8% нь үр тариа, 62% нь төмс, хүнсний ногоо, 9% нь нарийн ногоо, үлдсэн 8% нь жимс жимсгэнэ тариалагчид бүрдүүлж байна. Тэдгээрийн дийлэнх нь дотоодын хөрөнгө оруулалттай, зохион байгуулалтын хувьд 76% нь хувиараа бизнес эрхлэгч, 20% нь ХХК хэлбэртэй болно. Үйл ажиллагаа явуулж буй хугацааны тархалт нь жигд бөгөөд боловч дийлэнх нь 1-10 ажилтантай, жилийн дундаж орлого нь 99 сая төгрөг хүртэл байна.


График 4. Газар тариалан эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Зөгийн аж ахуй эрхлэгчдийн 36% нь зөгий үржүүлэг, 64% нь зөгийн бал үйлдвэрлэдэг дотоодын хөрөнгө оруулалттай хувиараа хөдөлмөр эрлэгчид (67%) мөн ХХК (25%) байна. Үйл ажиллагаа явуулж буй хугацааны тархалт мөн жигд бөгөөд 1-10 ажилтантай, жилийн дундаж орлого нь 99 сая төгрөг хүртэл байна.


График 5. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Хүнс, ус, ундаа үйлдвэрлэгчдийн 61% нь хоол, хүнсний үйлдвэрлэл, 25% нь ус ундааны үйлдвэрлэл, 7% нийтийн хоолны үйлдвэрлэл эзэлж байгаа ба 95% нь дотоодын хөрөнгө оруулалттай болно. Уг дэд салбарын ялгаатай нь 70% нь зохион байгуулалтын хувьд ХХК хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг юм. Үйл ажиллагаа явуулж буй хугацааны тархалт мөн хэвийн боловч бичил бизнесээс гадна 11-50 ажилтантай жижиг (36%), дунд (9%) байгууллагууд тал хувийг бүрдүүлдэг юм. Хэмжээний хувьд томорч байгаа тул мөн жилийн дундаж орлогын хувьд 54% нь 99 сая, 18% нь 100-299 сая, 15% нь 1 тэрбум хүртэл, 9% нь 2.5 хүртэл тэрбум төгрөгийн орлоготой байна.


График 6. Хүнс, ус, ундаа үйлдвэрлэгчдийн ерөнхий мэдээлэл



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн 47% нь жижиглэнгийн худалдаа, 37% нь хоол үйлдвэрлэл үйлчилгээ, 7% нь агуулах, 8% нь тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч бүрдүүлж байгаа болно. ЖХҮ эрхлэгчид ихэвчлэн дотоодын хөрөнгө оруулалттай, 67% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 29% нь ХХК бөгөөд үйл ажиллагаа явуулж буй хугацааны тархалт жигд, дийлэнх нь 1-10 ажилтантай, 99 сая төгрөгийн орлоготой байна.

График 7. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл




Эх үүсвэр: Судалгааны үр дүн

2.3. Салбарын ерөнхий нөхцөл байдлын үнэлгээ

Өөрийн үнэлгээний асуулгад оролцогчдоор салбарын өнөөгийн нөхцөл байдлыг 1-4 оноогоор үнэлүүлсэн ба үнэлгээний дундаж утга (mean) 4 онооноос 2.28 байгаа нь салбарын нөхцөл байдлыг хангалтгүй гэж үзжээ. Бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэгчийн мэдлэг чадвар (2.9) хамгийн өндөр үнэлгээ авсан бол салбарын өрсөлдөх чадвар (2.68), дүрэм

журам стандартууд (2.48), борлуулалтын тогтолцоо (2.45), мэдээллийн олдоц хүртээмж (2.42), хамтын ажиллагаа түншлэл (2.35), техник, технологийн инновац (2.27) гэсэн үзүүлэлтүүд дундаж утгатай байна. Харин тоног төхөөрөмжийн хангамж (2.19), салбарын маркетинг, сурталчилгаа (2.14), агуулахын тогтолцоо (2.06), үйлдвэрлэлийн зөвлөгөө өгөх байгууллага төслүүдийн үйл ажиллагаа (2.03) багаар үнэлэгдсэн бол мэргэжлийн хүний нөөцийн олдоц (1.95), санхүүгийн боломжууд (1.91), засгийн газрын дэмжлэг тусалцаа (1.53) маш муу үнэлгээтэй байна. Нэмэлт хүчин зүйлсэд сав баглаа боодлын нийлүүлэлттэй холбоотой саналууд голчилж байсан.

График 8. Салбарын нөхцөл байдлын дундаж үнэлгээ



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

2.4. Салбарын хувьд тулгамдаж буй асуудал

Давхардсан тоогоор нийт оролцогчдын 64% нь хөрөнгө оруулалт дутагдалтай, 58% нь эдийн засаг санхүүгийн нөөц дутагдалтай, 54% нь урсгал зардал өндөртэй гэж хариулсан нь салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлын нэр тэргүүн нэрлэгдсэн байна.

Бусад тулгамдаж буй асуудал, бэрхшээлд байгаль цаг уурын хүчин зүйл, улирлын нөлөө, борлуулалтын сувгийн тоо хязгаарлагдмал, газар тариалан мал аж ахуйг бүсчлэх зааглах, засгийн газрын дарамт шахалт их, олон шат дамжлагатай, том компаниудын хүч нөлөө их,

тоног төхөөрөмжийн олдоц бага, үнэ өндөр, үйлчлүүлэгчдийн мэдлэг ойлголт бага, мэргэжлийн хүний нөөцийн хомсдолтой зэрэг асуудлуудыг нэрлэж байна.

График 9. Салбарын хувьд тулгамдаж буй асуудлууд



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

“Байгаль орчинд ээлтэй байх” зармыг хөгжүүлэхийн тулд байгууллагын хувьд нэн тэргүүнд хэрэгжүүлэх зүйлсийг тодруулах нээлттэй асуултад нийт 543 оролцогчид (нийт оролцогчдын 73.1%) санал ирүүлсэн. Чанарын судалгааны үр дүнд шинжилгээ хийдэг NVIVO программ ашиглан шинжилгээ хийхэд БЖДҮ-н хувьд санхүүжилтийн хэрэгцээ шаардлага, сургалт, зөвлөх үйлчилгээ, засгийн газрын дэмжлэг нэн тэргүүнд шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Зураг 4. Нэн тэргүүн хэрэгжүүлэх ажлын саналууд



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

3. ХАА, ХҮНС, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЧАДАВХ

3.1. Эко шошгожуулалт

3.1.1. Ногоон гэрчилгээ

ХААХУУҮС-т байгаль орчин, экологитой холбоотой MNS 6737:2018 Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД), ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо гэсэн стандартууд мөрдөгдөж ажилладаг ба Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын (МҮХАҮТ) "Органик бүтээгдэхүүн / Certified organic" эко шошго, ХХААХҮЯ-ын “Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг” гэсэн ногоон гэрчилгээнүүд нэвтэрсэн байдаг. Гэхдээ байгууллагууд эдгээр стандартуудыг хэрэгжүүлсэн, дагаж мөрдөж буй байдал харьцангуй сул байдаг нь үнэлгээний үр дүнгээс харагдсан.


Хүснэгт 13. Стандартуудын хэрэгжилтийн үнэлгээ




| Стандартууд | | Ийм ойлголтын талаар мэдэхгүй, сонсож байгаагүй | Үгүй, ямар нэг төлөвлөгөө байхгүй | Үгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа | Тийм, хэрэгжүүлж байгаа | Тийм, хэрэгжүүлдэг | Нийт |
|---|----------|---|-----------------------------------|--------------------------------------|-------------------------|--------------------|-------------|
| МҮХАҮТ - "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго | Тоо % | 90 12% | 228 31% | 287 39% | 46 6% | 91 12% | 742 100% |
| ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг | Тоо % | 89 12% | 248 33% | 275 37% | 52 7% | 78 11% | 742 100% |
| MNS 6737:2018 Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) | Тоо % | 139 19% | 226 30% | 232 31% | 61 8% | 84 11% | 742 100% |
| ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо | Тоо % | 94 13% | 183 25% | 251 34% | 85 11% | 129 17% | 742 100% |
| ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо | Тоо % | 126 17% | 228 31% | 241 32% | 72 10% | 75 10% | 742 100% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Дээр дурдсан олон улсын стандарт, дотоодын органик бүтээгдэхүүн, ХАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавигддаг шаардлагуудаас заримыг сонгож, хэрэгжилтийн үйл явц, тулгамдаж буй асуудлын талаар дэлгэрүүлж судалсан.


Хүснэгт 14. ХАА-н ногоон гэрчилгээнүүд

| № | Гэрчилгээний нэр | Байгууллага | Товч тайлбар | Шошго |
|---|---|-------------|--|---|
| 1 | “Органик бүтээгдэхүүн/ Certified organic” эко шошго | МҮХАҮТ | МҮХАҮТ нь 2016 оноос үндэсний, байгалийн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд сайн дурын үндсэн дээр "Органик бүтээгдэхүүн/Certified organic" шошго олгож эхэлсэн ба одоогийн байдлаар 60 байгууллага гэрчилгээ авсан байна. |  |

| | | | | |
|---|---|-------------|---|---|
| 2 | Органик хүнсийг баталгаажуулах тэмдэг | ХХААХҮ Я | Органик ХАА-н үйлдвэрлэгч, импортлогчдод олгогддог. 2021 оны 10-р сарын байдлаар 417 органик болон шилжилтийн үеийн органик хүнсний бүтээгдэхүүн бүртгэгдсэн байна. |   |
| 3 | MNS 6737:2018 Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) | ХХААХҮ Я | ХААЗД нь мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл, тэдгээрийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах нөхцөл, үйл ажиллагааг хэлдэг. 2021 оны байдлаар 40 байгууллага гэрчилгээ авсан байна. |  |

МҮХАҮТ-ийн гишүүнчлэлийн газрын мэргэжилтэнтэй МҮХАҮТ-с хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус бүтээгдэхүүнд олгогддог “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошгыг авах үйл явцын талаар ярилцсан. Гэрчилгээ олгох баталгаажуулалтын үйл явц нь 8 алхмаас бүрддэг ба доорх зурагт харууллаа. Үүнд МҮХАҮТ-ийн мэргэжилтнүүд болон тухайн салбарын мэргэжилтнүүдийн баг бичиг баримтын үнэлгээ, газар дээрх үнэлгээ ордог бөгөөд баталгаажуулалтын үйл явц нь бүхэлдээ хүндрэл бэрхшээл багатай, үйлдвэрлэгчдэд ойлгомжтой байдлаар зохион байгуулагддаг байна.

Зураг 5. МҮХАҮТ-н “Органик бүтээгдэхүүн” эко тэмдэг авах үйл явц



Эх үүсвэр: Ярилцлагын үр дүн


Онлайнаар хүсэлтийг хүлээн авах боломжтой байдаг боловч үйлдвэрлэгчид хүсэлт болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг ихэвчлэн биечлэн өгөх хүсэлтэй байдаг байна. Газар дээрх үнэлгээ, шийдвэр гаргах үйл явц нь нийт 14 хоног үргэлжилдэг ба органик бүтээгдэхүүнд тавигдах 10 шаардлагыг 80 хувиас дээш хангасан бол хүлээн зөвшөөрч,

гэрчилгээ олгодог байна. Нэг төрлийн бүтээгдэхүүний гэрчилгээ авах хураамж 500,000 төгрөг болно. Манай улсын хувьд Органик бүтээгдэхүүний гэрчилгээ авсан 60 үйлдвэр байдаг нь мэргэжилтний хувьд хангалтгүй гэж үзэж байна. Уг гэрчилгээг авснаар үйлдвэрлэгчдийн хувьд экспортын боломжууд нэмэгдэх, олон улсын болон дотоодын томоохон байгууллагуудын нийлүүлэгч болох боломжтой байдаг хэдий ч хамрагдалт багатай байгаа нь үйлдвэрлэгчдийн хувьд мэдлэг, мэдээлэл дутмаг, гэрчилгээний ач холбогдлыг ойлгоогүй эсвэл хараахан гэрчилгээг авах хэрэгцээ шаардлага үүсээгүй байж болно гэж үзэж байна.

Сэлэнгэ Органик Хамтын Баталгаажуулалтын Байгууллагын (ХББ) тэргүүнтэй хийсэн ярилцлагаар ХХААХҮЯ-н Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг, тэмдэглэгээ авах үе шат, өнөөгийн нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийг тодрууллаа. Сэлэнгэ Органик ХББ нь нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг ба 16 салбар бүхий хамтын баталгаажуулалтын байгууллага юм. Хамтын баталгаажуулалт нь МУ-ын Органик хүнсний тухай хууль, дүрэм журмыг хамтдаа хэрэгжүүлж, хамтын хяналт тавих үүрэгтэй болно. АДРА Монгол олон улсын байгууллагын “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөл нь органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг МУ-д хөгжүүлэх эхлэлийг Сэлэнгэ аймагт тавьж, хамтын баталгаажуулалтын тогтолцоог бий болгон, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахаар 4 жилийн турш хэрэгжиж 2022 оны 12 сард дууна.

ХББ-н органик хүнсийг баталгаажуулах үйл явц нь 2 үндсэн хэсгээс бүрдэх ба доорх зурагт алхмуудыг дэлгэрэнгүй харууллаа. Органик ХАА түншлэлийн хүрээнд 928 үйлдвэрлэгчид хамрагдаж, Сэлэнгэ Органик ХББ болон түүний бусад 15 салбар байгууллагын хүрээнд 378 үйлдвэр тангараг өргөснөөс 320 үйлдвэр нь 100% органик бүтээгдэхүүний шаардлагыг хангасан хэмээн баталгаажуулалтад бэлэн болсон байна. Өнөөгийн байдлаар Органик хүнсний бүтээгдэхүүний хамтын баталгаажуулалт зөгийн аж ахуй, бордоо үйлдвэрлэл, газар тариалангийн чиглэлд хэрэгжиж байна. Шилжилтийн үеийн органик, 100% органик шаардлагуудыг хангасан гэсэн үе шатууд нь тус бүрдээ нэг жил үргэлжилж хамгийн багадаа 1-2 сая төгрөгийг ХББ-ын гишүүдийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг хэрэгжүүлэхэд зарцуулдаг болно. Нэг ХББ хамгийн багадаа 5 үйлдвэрлэгч, 3 хэрэглэгчээс бүрддэг ба ХББ-н бүх гишүүдийн хурлаар гэрчилгээ олгох эсэх шийдвэр гарснаар тэмдэг тэмдэглэгээг ашиглах эрх үүснэ. Сэлэнгэ Органик ХББ нь одоогийн байдлаар 1 нэрийн барааны дэлгүүр, 5 томоохон байгууллагатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан ба тогтмол хэрэглэгчидтэй болж чадсан юм. Органик бүтээгдэхүүний тэмдэг авах үйл явц нь харьцангуй төвөгтэй, цаг хугацаа болон тууштай байдлыг шаарддаг болно. Манай улсын хүнсний үйлдвэрлэгчдийн хувьд мэдлэг чадвар хангалтгүй байдаг байна. Тухайлбал: Дээр дурдсан 928 үйлдвэрлэгчдийн 300 үйлдвэрлэгчид нь мэдээллийн технологийн мэдлэг чадвар хангалтгүйн улмаас баримт бичгийн бүрдүүлэлт, органик хүнсний бүтээгдэхүүний мэдээллийн сан (organic.gov.mn)-д хандаж чаддаггүй байна.

Зураг 6. ХХААХҮЯ- Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг- ХББ-н гэрчилгээ авах үйл явц




Эх үүсвэр: Ярилцлагын үр дүн

3.1.2. Эко шошгожуулалтын тухай ойлголт

Өөрийн үнэлгээний асуулгаар 11 хүчин зүйлс бүхий 2 асуултаар БЖДҮ эрхлэгчдийн эко шошгожуулалтын тухай мэдлэг, ойлголт, хандлагыг тодрууллаа. Үнэлгээнд оролцсон 742 оролцогчдын 20% нь эко шошгожуулалтын тухай сайн мэднэ, 62% нь сонсож байсан, үлдсэн 18% нь огт сонсож байгаагүй гэж хариулсан байна. Эко шошгожуулалтын талаар огт сонсож байгаагүй оролцогчдын дийлэнх нь буюу 49.3% нь газар тариалан эрхлэгчид байна. Харин сайн мэднэ гэж хариулсан оролцогчдын 30.8% нь хүнс, ус, ундаа үйлдвэрлэгчид, тодорхой хэмжээнд сонсож байсан оролцогчдын 29.7% нь тариалан эрхлэгчид бүрдүүлж байна. Үнэлгээг 5 онооны Likert scale ашигласан ба үр дүнг доор харууллаа.

График 10. Тойрог эдийн засгийн тухай мэдлэг



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Эко шошгожуулалтын тухай ойлголт, хандах хандлагыг тодорхойлох 10 хүчин зүйлстэй оролцогчид ихэнхдээ санал нийлж байгаа бөгөөд дундаж (mean) утгуудыг дараах графикт харууллаа. Үзүүлэлтүүд дундаас ногоон үйлдвэрлэл явуулах нь борлуулалтыг нэмэгдүүлж, ажилтнуудын цалин болон амьжиргааны түвшинд сайнаар нөлөөлнө гэдэг хүчин зүйл хамгийн бага үнэлгээтэй байгаа нь ач холбогдлыг бүрэн ойлгоогүй байгааг илтгэж болно. Газар зүйн бүсээр ялгаатай үр дүн ажиглагдаагүй. Өгөгдөлд хийсэн хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд оролцогч байгууллагуудын төлөөллүүд бүтээгдэхүүнээ эко шошгоор баталгаажуулах нь үр ашигтай, оновчтой байх ба найдвартай байдлыг илтгэнэ хэмээн санал нэгдсэн бол хэрэглэгч шошгыг уншиж таньж, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн худалдан авах нь зөв хэмээн үзсэн байна.

График 11. Эко шошгожуулалтын тухай хандлага



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

3.2. Сургалт, санхүүгийн хэрэгцээ

3.2.1. Сургалтын хэрэгцээ

Судалгаагаар сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээг тодорхойлсон. Оролцогчид хог хаягдлыг цуглуулах, ангилах, боломжтой бол дахин ашиглах талаар сургалт явуулдаг эсэх талаар тодруулахад 58% нь албан ёсны сургалт явуулдаг гэж хариулсан бөгөөд дэд салбар дундаа ЗАА өндөр хувьтай гарсан. Харин зөгийн аж ахуй эрхлэгчдийн 80% нь сургалт,

зөвлөгөө өгөх чиглэлээр бусад ААН, хувь хүмүүстэй хамтран ажилладаг бол газар тариалан болон ЖХҮ-ийн 70% нь огт хамтран ажилладаггүй байна.


Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн сургалт

| Асуулт | Газар тариалан | Зөгийн аж ахуй | Үйлдвэрлэл | Жижиглэн худалдаа |
|--|----------------|----------------|------------|-------------------|
| Хог хаягдлыг цуглуулах, ангилах, дахин боловсруулах тогтолцооны талаар сургалт явуулж буй хувь | 45% | 78% | 65% | 45% |
| Сургалт зөвлөх үйлчилгээ авахдаа бусад ААН хувь хүмүүстэй хамтардаг хувь | 25% | 80% | n/a | 30% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Сургалтын үйл ажиллагаа явуулдаг эсэхээс үл хамааран оролцогчдыг байгаль орчинд ээлтэй байх, ногоон шошгожуулалтын талаар сургалт зохион байгуулах өөрсдийн байгууллагын чадавх, бэлэн байдлыг үнэлүүлэхэд дундаж үнэлгээ 2.62 гарсан. ЗАА илүүтэй сургалт явуулах хүсэл эрмэлзэл өндөр байдаг бол ЖХҮ эрхлэгчид сургалтын чиглэлээр бэлэн байдал багатай байгаа нь доорх хүснэгтээс харагдаж байна. Байгууллагын чадавхыг нэгдсэн үнэлгээг тайлангийн 3.3 дугаар хэсгээс үзнэ үү.

График 12. Сургалтын чадавхын өөрийн үнэлгээ



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын чиглэлийг тодорхойлох зорилгоор судалгаанд оролцогчдоос цаашид шаардлагатай байгаа сургалтуудыг тодорхойлох асуулт асуусан. Нийт 11 төрлийн сургалтын чиглэл асууснаас бүх чиглэлүүд хэрэгцээтэй байгаа боловч хог хаягдлыг удирдах тогтолцоо, эко стандартыг хэрэгжүүлэх мөн гэрчилгээ авах сургалт нэн тэргүүнд байна.

График 13. Сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ




Эх үүсвэр: Судалгааны үр дүн

3.2.2. Санхүүгийн хэрэгцээ


Санхүүгийн хэрэгцээ, санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай санхүүжилтийн хэмжээ зэргийг тодорхойлох 5 асуултыг тодруулсан. МУ-ын ХАА салбарын өнөөгийн байдлын үнэлгээнд санхүүжилт авах боломжийг нийт оролцогчид хангалтгүй хэмээн үнэлсэн (тайлангийн 2.3 хэсэг). Орхон болон Өмнөговь аймгийн санхүүгийн салбар боломжийн хэмээн үнэлэгдсэн боловч нийтдээ дунджаас доогуур гэж үнэлгээ авсан байна.

График 14. Санхүүгийн салбарын үнэлгээ



Эх үүсвэр: Судалгааны үр дүн


График 15. Санхүүжилт авахад тулгардаг бэрхшээл



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэхэд тулгарч буй бэрхшээлүүд дундаас хөрөнгө оруулалт дутагдалтай (давхардсан тоогоор нийт оролцогчдын 64%), эдийн засаг санхүүгийн нөөц дутагдалтай (58%) гэсэн хариултууд хамгийн өндөр хувийн жин эзэлж байна (тайлангийн 2.4 хэсгээс харна уу). Байгаль орчинд ээлтэй туршлага нэвтрүүлэх өөрсдийн санхүүгийн чадавхыг газар тариалан эрхлэгчдийн 40% нь учир дутагдалтай, 50% нь зайлшгүй сайжруулах гэж үнэлсэн юм. Харин ЖХҮ нарын 21% нь санхүүгийн чадавхтай гэж үнэлжээ.

График 16.. Санхүүгийн чадавхын өөрийн үнэлгээ, дунджаар



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс харахад БЖДҮ нар Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, ОУ-ын буцалтгүй тусламжаас санхүүжилт авах сонирхолтой байгааг дараах зургаас харж болно.


График 17. Санхүүжилтийн эх үүсвэр



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад бизнес эрхлэгч нарын 17% нь 10 сая төгрөг хүртэл, 38% нь 11-50 сая төгрөг, 18% нь 51-100 сая төгрөг хүртэл нэмэлт санхүүжилт шаардлагатай байна гэж хариулсан байна. Гэвч нийт оролцогчдын дөнгөж 25% нь ногоон үйл ажиллагааг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл, тооцоо шинжилгээтэй төслийн бичиг баримт байгаа болно. Иймд, төсөл бичих, санхүүжилтэд шаардлагатай баримт бичиг бүрдүүлэхэд зөвлөх, туслах үйлчилгээний хэрэгцээ өндөр байна. Нийт оролцогчдын 80% нь мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ авахад бэлэн байна гэдгээ илэрхийлсэн. Ялангуяа, зөгийн аж ахуй болон тариалан эрхлэгчдэд нэн тэргүүнд шаардлагатай гэж дүгнэж байна. Барьцаа хөрөнгө, зээлийн хүү зэрэг санхүүжилт авахад тулгардаг хүндрэлүүд нь Монгол улсын санхүүгийн салбарын зохицуулалттай илүү холбоотой байдаг бол БЖДҮ-н хувьд төсөл бичих үр чадвараа нэмэгдүүлэх хэрэгцээ байна гэж харж байна.

График18. Шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

3.3. Байгууллагын чадавх


Өөрийн үнэлгээний асуулгаар БЖДҮ-ийн ТЭЗ-ийн туршлагауудыг нэвтрүүлэхэд дижитал болон технологийн чадавх, зохион байгуулалтын чадавх, зорилтын тохируулга, төлөвлөлт, бодлого, хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг 5 онооны Likert scale-р үнэлүүлэв.

Дижитал чадавх. Дижитал болон технологийн чадавхыг 5 хүчин зүйлээр үнэлэхэд дийлэнх нь дижитал технологийг хараахан ашиглаагүй, судалгаанд оролцогчдын 36% нь цахим технологийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа, 13% нь ирээдүйд ашиглахаар

төлөвлөж байгаа бол үлдсэн 50% нь ашиглахаар төлөвлөөгүй байна. Өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг гэж хариулсан оролцогчид дижитал технологи нь бүтээмжийг нэмэгдүүлж, цаг хугацаа хэмнэх боломжтойг ойлгосон төдийгүй цахимаар хадгалах, онлайн уулзалтыг үйл ажиллагаандаа өргөнөөр нэвтрүүлэх болно гэж хариулсан байна. Харамсалтай нь судалгаанд оролцогчдын тал хувь нь эдгээр давуу талуудыг мэддэггүй ба гэрээсээ онлайнаар огт ажилладаггүй байна. Эдгээр үр дүнгүүдээс харвал бизнес эрхлэгчдийн дижитал чадавх хангалтгүй, ашиглалт багатай байгаа нь харагдаж байна. Газарзүйн байршлын хувьд ялгаатай тал ажиглагдаагүй боловч үйлдвэрлэл, ЖХҮ эрхлэгчид бусад дэд салбаруудтай харьцуулахад илүү цахимжсан байна.

Байгууллагын чадавх. Байгууллагын чадавхыг 1 асуулт, 14 шалгуур үзүүлэлтээр үнэлж, санал болгож буй үзүүлэлт бүрийг *бэлэн биш* түвшнөөс *бүрэн чадавхтай* гэсэн дээд түвшний сонголтуудыг өгсөн. Доорх графикт байгууллагын чадавхад өгсөн үнэлгээний дундаж утгын нэгтгэлийг харууллаа. БЖДҮ-ийн өгсөн өөрийн үнэлгээнээс харахад тэд өөрсдийн байгууллагын дүр төрх, байгууллагын соёлыг хүчтэй, технологийг харин хамгийн сул тал гэж үзжээ. Газарзүйн байршил болон дэд салбаруудын хооронд мэдэгдэхүйц ялгаа байгаагүй болно.

График 19. Байгууллагын чадавх



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

4. ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ТУРШЛАГА


4.1. Тойрог эдийн засгийн ойлголт

ТЭЗ нь үйлдвэрлэл, хуваарилалт болон эцсийн хэрэглээний явцад түүхий эд материалын хэрэглээг багасгах (түүхий эдийн хамгийн бага ашиглалт), дахин хэрэглэх (бүтээгдэхүүн, эд ангиудыг олон дахин ашиглах), дахин боловсруулах зэрэг бүх л үйл ажиллагааг хамарсан ерөнхий нэр томъёо юм⁷. ТЭЗ-ийн зөрүүтэй байдлын тайланд хүн төрөлхтний хэрэгцээг хангахын тулд байгаль орчинд ээлтэй байж, дэлхийн биофизикийн хил хязгаарын хүрээнд байх шалгуураас улс орнууд хэр хол байгааг харуулсан байна. Экологийн тэнцвэрт байдал⁸, аюулгүй, шударга байдалд хүрэх зай⁹, нийгмийн хүчин зүйл¹⁰ гэсэн гурван үзүүлэлтээс харахад Монгол Улс хамгийн сул байр суурьтай буюу эко үзүүлэлтээс маш хол зайтай байна.

4.1.1. Тойрог эдийн засгийн зөрүүтэй байдал

Шугаман эдийн засаг нь ашиглалтын дараа шууд хаягдал болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд суурилсан "авах-ашиглах-хаях" загварыг баримталдаг. Харин ТЭЗ нь бүтээгдэхүүн, түүхий эдийг дахин ашиглах, хог хаягдлыг бууруулах, хөрс, ус, агаарт бий болох хорт хийн ялгаруулалтаас аль болох урьдчилан сэргийлэхэд төвлөрдөг.

Зураг 7. Тойрог эдийн засгийн зөрүүтэй байдал



Эх үүсвэр: Хог хаягдлыг багасгах, дахин сэргээх, нөөцийн хомсдолоос сэргийлэх шинжилгээ 2011

Тойрог эдийн засагт техникийн болон биологийн цикл гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэг байдаг.

⁷ Jouni Korhonen. Circular economy as an essentially contested concept


⁸ Jouni Korhonen. Circular economy as an essentially contested concept

⁹ Each orbit clusters countries that share a similar distance to the safety, closer to center is preferable

¹⁰ measured by the United Nations' Human Development Index (HDI), blue is preferable

1. Техникийн цикл нь хязгаарлагдмал нөөцийг удирдахад чиглэдэг.
2. Биологийн цикл нь сэргээгдэх боломжтой түүхий эд материалын урсгалыг багтаасан ойлголт юм. Хэрэглээ зөвхөн биологийн циклд бий болдог. Иймээс сэргээгдэх шим тэжээл нь (биологийн) мөн биологийн циклд нөхөн сэргээгддэг.

Зураг 8. Тойрог эдийн засгийн зураглал



Эх үүсвэр: Ellen MacArthur Foundation and McKinsey Center for Business and Environment; Adapted from Braungart & McDonough, Cradle to Cradle (C2C).

Тойрог эдийн засаг гурван зарчим дээр суурилдаг.

1-р зарчим: Хязгаарлагдмал нөөцийг удирдаж, сэргээгдэх нөөцийн урсгалыг тэнцвэржүүлэх замаар байгалийн капиталыг хадгалж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой.

2-р зарчим: Техникийн болон биологийн циклийн аль алинд нь бүтээгдэхүүн, эд анги, түүхий эд материалыг хамгийн үр ашигтайгаар эргэлтэд оруулах замаар гарцыг нэмэгдүүлэх зорилготой. Энэ нь техникийн эд анги, түүхий эд материалыг эргэлтэд оруулж, эдийн засагт хувь нэмэр оруулахын тулд дахин боловсруулах, сэргээн засварлах, дахин боловсруулалт хийх загвар бий болгоно гэсэн үг. Биологийн мөчлөгт бүтээгдэхүүн нь эхлээд хэрэглээнд орж, дараа нь дахин шинэ нөөцийг бий болгох замаар нөөцийн үнэ цэнийг нэмэгдүүлж нөхөн сэргээх зорилгоор бүтээгддэг.


3-р зарчим: Гадны сөрөг хүчин зүйлсийг илрүүлсний үндсэн дээр төлөвлөж, системийн үр ашгийг дээшлүүлэх зорилготой. Үүнд хоол хүнс, орон байр, боловсрол, эрүүл мэнд, үзвэр

үйлчилгээ гэх мэт хэрэглээний системд учирч буй хохирлыг бууруулахын зэрэгцээ газар, агаар, усны бохирдол, хорт бодис ялгаралт зэрэг гадны нөлөөллийг зохицуулахад анхаарлаа хандуулдаг.

4.1.2. Тойрог эдийн засгийн элементүүд

ТЭЗ-ийн зөрүүтэй байдлыг нөхөхийн тулд чухал элементүүдийг тодорхойлох нь зүйтэй. Тухайлбал: үйлдвэрлэгчид бизнестээ өндөр үр ашигтай орлогын шинэ эх үүсвэр бий болгох, бүтээгдэхүүний загвар дизайныг өөрчлөх, хамгийн чухал нь нийлүүлэлтийн сүлжээний үед хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд сэргээгдэх эрчим хүч болон байгалийн нөөцийг ухаалгаар хэрэглэх шаардлагатай тулгарч байна¹¹.

Зураг 9. Тойрог эдийн засгийн элементүүд




Эх үүсвэр: Нидерландын хүрээлэн буй орчны үнэлгээний агентлаг²⁰

ТЭЗ нь зөвхөн дахин боловсруулах тухай ойлголт биш юм¹². Нидерландын хүрээлэн буй орчны үнэлгээний агентлаг нь тойрог эдийн засгийг "R" зарчмын дагуу дахин бодох, дахин төлөвлөх, дахин ашиглах, засах, дахин үйлдвэрлэх, дахин боловсруулах, сэргээх үйл явц гэж тодорхойлсон байна.

Зураг 10. Тойрог эдийн засгийн стратеги

¹¹ [Opportunities for a circular economy - PBL Netherlands Environmental Assessment Agency](#)

¹² [Opportunities for a circular economy - PBL Netherlands Environmental Assessment Agency](#)



Эх үүсвэр: Нидерландын хүрээлэн буй орчны үнэлгээний агентлаг

4.2. Тойрог эдийн засгийн туршлагын өнөөгийн нөхцөл байдал

Бичил, жижиг, дунд бизнесийн байгууллагуудын ТЭЗ-ийн туршлагын өнөөгийн нөхцөл байдал, дутагдалтай орон зайг тодорхойлох зорилгоор судалгааны үр дүнг энэ хэсэгт нэгтгэлээ.

4.2.1. Тойрог эдийн засаг дахь стратеги ба менежментийн туршлагууд

Судалгаанд нийт 742 оролцогч хамрагдсан. Үүнд хоол хүнс үйлдвэрлэл, зөгийн аж ахуй, газар тариалангийн 444, ЖХҮ, тээвэрлэлт, хадгалалт, агуулахын үйлчилгээ үзүүлэгч 298 байгууллага багтсан.

Монгол улсын хувьд хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй байх таван стандартыг түгээмэл ашигладаг. Үүнээс МҮХАҮТ-ын органик бүтээгдэхүүний эко шошгожуулалтын стандартыг 12.3% нь хэрэгжүүлдэг. ХХААХҮЯ-ны органик хүнсний баталгаажуулах тэмдгийг 10.5%, Харин MNS 6737:2018 буюу хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД)-г нийт оролцогчдын 11.3% нь дагаж мөрддөг. Харин ISO 22000 буюу хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог хэрэгжүүлдэг оролцогчид 17.4% байна. Дээрх үр дүнгээс харахад стандарт баримтлан ажиллах үзүүлэлт маш доогуур байгаа нь эдгээр стандартуудын тухай мэдээлэл дутмаг, сургалт сурталчилгаа хангалтгүй, өдөр тутмын ажлыг нь дэмждэг байгууллагын оролцоо хангалтгүй байгаатай холбоотой. Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт, ногоон хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба олон улсын бусад төслүүдийн талаар мөн хангалтгүй мэдээлэлтэй байгаа учраас эдгээр хөтөлбөрүүдийн тухай олон нийтэд түгээх хэрэгцээ өндөр байгаа юм. Үүнийг хүснэгтэд харуулбал:


Хүснэгт 16. МУ-н хүрээлэн буй орчиндоо хариуцлагатай байх зорилго, зорилт хөтөлбөрүүдийг баримталдаг байдал

| № | Зорилго, хөтөлбөрүүд | Тоо | Хувь |
|---|--|-----|------|
| 1 | Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтыг баримталдаг | 275 | 38% |
| 2 | Монгол улсын ногоон хөгжлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлдэг | 242 | 33% |
| 3 | Олон улсын төсөл хөтөлбөрт нэгдсэн | 51 | 7% |
| 4 | Орон нутгийн төсөл хөтөлбөрт нэгдсэн | 99 | 14% |
| 5 | Баримталдаггүй, нэгдээгүй | 302 | 42% |
| | Нийт | | 100% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Хүрээлэн буй орчиндоо ээлтэй үйл ажиллагааг хөгжүүлэх болон хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл төлөвлөгөөтэй байгууллага 24 хувийг эзэлж байгаа боловч энэ нь зөвхөн санхүүгийн дэмжлэг авах зорилготой байдаг нь бичил, жижиг, дунд бизнесийн байгууллагуудын санхүүгийн чадавх сул, санхүүгийн хэрэгцээ өндөр байгааг илтгэж байна.


График 20. Эко төсөл боловсруулсан байдал



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Үүний зэрэгцээ төлөвлөгөөний биелэлт болон тойрог эдийн засгийн туршлагуудыг хэмжих гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлт ашиглахгүй байгаа нь сул тал болж байна.

График 21. Эко зорилгыг хэмжих үзүүлэлтүүд ашигладаг эсэх



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Тодруулбал: Нийт судалгаанд оролцогчдын зөвхөн эко зорилгыг хэмжих үзүүлэлт ашигладаг буюу 18% нь тийм гэж хариулсан байна. Харин гүйцэтгэлийн хэмжүүр байхгүй болон мэдэхгүй гэж 82% нь хариулсан бөгөөд байгууллагын стратеги төлөвлөгөөнд тойрог эдийн засгийн ойлголт болон түүний зорилтыг тусгаагүй байна.

Газар тариалангийн дэд салбар. Тойрог эдийн засгийн туршлагын өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээнд 229 тариалан эрхлэгчид хамрагдсан. Тариаланчдын хувьд “хөдөө аж ахуйн зохистой дадал”-ыг хэрэгжүүлэх байдал нь бусад стандартаас өндөр үзүүлэлттэй буюу 22.6хувьтай байгааг салбарын онцлогтой холбон тайлбарлаж болно. Энэ нь хөрсний менежменттэй холбоотой органик дадлуудыг бий болгосон бөгөөд цаашид сайн туршлага болгох, хэвшүүлэх бүрэн боломжтой байна гэсэн үг юм. Гэвч хүрээлэн буй орчинд аюулгүй байх, эко туршлагуудыг дэмжих олон улсын төсөлд хамрагдах, үндэсний хөтөлбөрт нэгдэх үзүүлэлт хангалтгүй байна. Мөн тойрог эдийн засгийн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх төлөвлөгөөгүй бөгөөд гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлтгүй /индикатор/ байгаа нь тойрог эдийн засгийн дадлыг бий болгох зорилт дэвшүүлээгүй байгааг харуулж байна.

Зөгийн аж ахуйн дэд салбар. Нийт 55 зөгийн аж ахуй эрхлэгчдийн МҮХАҮТ-ын органик бүтээгдэхүүн эко шошго, ХХААХҮЯ-ны органик хүнсийг баталгаажуулах тэмдгийн талаарх ойлголт сайн байгаа боловч МҮХАҮТ-ын органик бүтээгдэхүүн эко шошгыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн зөгийчид зөвхөн 11%, ХХААХҮЯ-ны органик хүнсийг баталгаажуулах тэмдгийг авсан байгууллага 9 хувийг эзэлж байна. Энэ нь тухайн эко шошго авах үйл явцтай шууд хамааралтай байна. Тухайн гэрчилгээг авах үе шатууд ойлгомжгүй, төвөгтэй, мэдээлэл дутмаг, цаг хугацаа их зарцуулдаг, тодорхойгүй байдаг нь бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулж байгаа юм. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн хувьд стандарт дагаж ажиллах чадвар их сул байгаа нь тухайн салбарын хөгжил сул байгааг мөн харуулж байна. Байгальд ээлтэй үйл ажиллагааг хөгжүүлэх болон хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл төлөвлөгөөтэй байх үзүүлэлт харьцангуй өндөр буюу 40 хувийг эзэлж байна.

| | |
|----------------|--------------------------------|
| Зөгийн аж ахуй | Төлөвлөгөө Байдаг 22 40% |
|----------------|--------------------------------|

Энэ нь сүүлийн 5 жилд зөгийн аж ахуйг хөгжүүлэх бичил хөтөлбөр болон орон нутгийн зохион байгуулж байгаа ажлууд ихэссэнтэй холбоотой. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн хүрээлэн буй орчиндоо аюулгүй үйл ажиллагаа явуулах оролдлого бусад дэд салбарын бизнесийн байгууллагуудаас сайн байна.

Үйлдвэрлэлийн дэд салбар. Судалгаанд 160 хүнс, ус, ундаа үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдсан байна. Үндэсний стандартуудыг хэрэгжүүлэх туршлагын хувьд үйлдвэрлэгчид бусад дэд салбаруудтай харьцуулахад сайн байна. Гэвч энэ нь хангалттай үзүүлэлт биш юм. Учир нь МҮХАҮТ-ын органик бүтээгдэхүүн эко шошго, ХХААХҮЯ-ны органик хүнсийг баталгаажуулах тэмдгийн талаарх ойлголт сайн байгаа боловч МҮХАҮТ-ын органик

бүтээгдэхүүн эко шошгыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн үйлдвэрлэгчид зөвхөн 23.1%, ХХААХҮЯ-ны органик хүнсийг баталгаажуулах тэмдгийг авсан байгууллага 26,9% эзэлж байна. Хөдөө аж ахуйн зохистой дадлын хувьд судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн 29.8% нь тухайн дадлыг баримтлан ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог дагаж мөрдөн, ажиллаж байгаа байгууллага 24.8 хувийг эзэлж байна. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, байгаль орчны менежментийн тогтолцоог дагаж мөрддөг байгууллагууд 29.3 хувийг эзэлж байна. Үйлдвэрлэгчдийн хувьд стандартыг дагаж, хэрэгжүүлэх түвшин бусдаасаа арай илүү байгаа нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн чанарын удирдлагын тогтолцоо, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт сайн байгааг харуулж байна.

Байгальд ээлтэй үйл ажиллагааг хөгжүүлэх болон хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө байгаа эсэхийг тодруулахад 30.6% нь байдаг, 63.1% нь байхгүй, үлдсэн 6.3% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

| | |
|------------|-------------------|
| Үйлдвэрлэл | Төлөвлөгөө Байдаг |
| | 49 |
| | 30,6% |


Жижиглэн худалдаа үйлчилгээний дэд салбар. Судалгаанд хамрагдсан 298 жижиглэнгийн худалдаа болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага, хувиараа бизнес эрхлэгчдийн 140 жижиглэнгийн худалдаа, 110 хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, 21 агуулах, 23 тээврийн үйлчилгээ үзүүлэгчид байна. Эдгээр байгууллагуудын хувьд Монгол улсад хэрэгжүүлж байгаа стандартыг дагаж мөрдөх туршлага нь хамгийн сул бөгөөд 31.5% ямар ч ойлголтгүй байна. Энэ нь хүрээлэн буй орчин, эко шошгожуулалт түүний ач холбогдлыг төдийлөн сонирхож байгаагүй болон энэ талаар мэдээлэл дутмаг байдгаар илтгэж байна. Агуулах, тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудад хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагааг хөгжүүлэх болон хэрэгжүүлэх төлөвлөгөө байдаггүй, эко төсөл, төлөвлөгөө байгаа эсэхийг хэлж мэдэхгүй байгаа нь тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, стратеги төлөвлөлт ойлгомжгүй, мэдээлэлгүй байдагтай холбоотой юм.

4.2.2. Тойрог эдийн засаг дахь олон нийтийн ба дотоод үйл ажиллагааны туршлагууд

Газар тариалангийн дэд салбар. Дэд салбар тус бүрийн давуу болон сул талууд, онцлогийг тодорхойлох зорилгоор тойрог эдийн засгийн туршлагын 7R зарчмыг ашиглаж, тариалангийн дэд салбарын БЖДҮ-ийг 54 шалгуур үзүүлэлт бүхий 9 асуултаар үнэлсэн. Судалгааны үр дүнд тариаланчид байгалийн гаралтай бордоо, малын өтөг бууцыг хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор ашигладаг. Хөрсийг биологийн хувьд идэвхтэй, үржилт шимтэй байлгахад чиглэсэн хөрсний менежментийг хэрэгжүүлэх үзүүлэлт сайн байна. Тариалангийн бүсэд ойр мод ургамлыг нөхөн сэргээдэг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийдэг. Саарал ус ашиглах, сэргээгдэх эрчим хүч ашиглах байдлыг огт хэвшүүлээгүй. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, эко үйлдвэрлэл, хог хаягдлын менежментийн сургалтыг ажилтнуудад тогтмол зохион байгуулдаггүй. Харин

агуулахын тэмдэг тэмдэглэгээ, бүтээгдэхүүний бүртгэл, түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгсэл, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж ашиглах, хортон шавьж, хогийн ургамлын эсрэг физик арга технологийг үйл ажиллагаандаа тусгасан. Дахин боловсруулах боломжтой, олон дахин ашиглах боломжтой, дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол ашиглалт, хөрсөнд задрах боломжтой бортого ашиглалт зэргийг маш бага хэрэгжүүлж байна.

График 22. Газар тариалан эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршилага




Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Үүнээс харахад байгалийн болон капитал нөөцөд анхаарлаа хандуулж, тариалалт, ургац хураалтын үйл явцад техник технологийн шийдэл бага ашиглаж байгаа нь сул тал болж байна. Тариаланчид ургац хураалтын явцад бий болсон хог хаягдлыг бордоо болгон ашиглах, малын тэжээл болгож, үлдсэн хувийг газар дүүргэлтэд ашиглаж байгаа нь нэг давуу тал юм. Харамсалтай нь хамтын эдийн засгийг хөгжүүлэх, дундаа нөөцөө ашиглах, эсвэл техникийн тусламж үйлчилгээ авах, сургалт зөвлөгөөнд хамрагдах үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь тойрог эдийн засгийн талаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Зөгийн аж ахуйн дэд салбар. Зөгийн аж ахуйн салбарын тойрог эдийн засгийн туршлагыг 9 асуулттай 51 үзүүлэлтүүдээр үнэлсэн. Тухайн салбар сүүлийн 5 жилийн дотор эрчимтэй хөгжиж, зөгийн аж ахуй эрхлэгчдийн тоо өссөн үзүүлэлт нь эко бүтээгдэхүүн, эко туршлагын тухай ойлголт нийт хүн амын дунд бий болоход хувь нэмрээ оруулж байна. Гэвч зөгийчид мөн л түлхүү орц буюу нөөцөд анхаарлаа хандуулж, үйлдвэрлэлийн үйл явц, хэрэглээний үе шатууд дээр эко туршлага дутуу байсаар байна. Үүнийг дараах үзүүлэлтүүдээс харж болно. Тухайлбал: Зөгийн аж ахуй эрхлэгчдийн ихэнх нь тэсвэр хатуужилтай зөгийн үүлдэртэй, өвчин, халдвараас урьдчилсан сэргийлэх тохиромжтой арга хэрэгсэлтэй, ургамлын гаралтай эмчилгээний бүтээгдэхүүн ашигладаг, зөгийн үүр хийхдээ байгалийн гаралтай материал ашигладаг, малын бууцыг утаа гаргахад ашигладаг, тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийх, тогтмол засвар үйлчилгээ хийх дадлуудыг бий болгосон.

График 23. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага



Эх үүсвэр: Судалгааны үр дүн


Зарим хэсэг нь зөгийн аж ахуйн тогтмол бүртгэл хөтлөн явуулдаг, дахин боловсруулах боломжтой сав, баглаа боодол ашигладаг. Харин дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол, бүтээгдэхүүний сав баглаа боодлыг буцаан авах тогтолцоо, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж ашиглах, цахилгаан машин, борооны ус саарал усны ашиглалт, химийн болон органик бүтээгдэхүүнийг тусад нь хадгалах, химийн бодис байгаа тухай анхааруулга тэмдэглэгээг байршуулах зэрэг туршлагууд муу байна.

Үйлдвэрлэлийн дэд салбар. Хүнс, ус ундаа үйлдвэрлэгчдийн тойрог эдийн засгийн туршлагуудыг нийт 20 асуултаар үнэлүүллээ. Хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй үйл ажиллагаа явуулснаар байгууллагын үйл ажиллагаа сайжирч, гадаад орчноос боломж нээгддэг гэдэгт итгэл муу байна. Харин бүтээгдэхүүний орц, найрлагын

гарал, үүсэл, баталгаажуулалт, тээвэрлэлтийг байнга шалгаж, хадгалалт, тээвэрлэлтийн бүртгэлийг хөтөлж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа нь бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоо сайн гэсэн үг юм. Хэрэглээний усаа байнга хэмнэж, хэвшсэн гэдэг нь хамгийн өндөр буюу 96 хувьтай байна. Мөн эрчим хүч бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаг, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах сургалтыг байнга явуулдаг гэсэн туршлагууд хангалттай сайн үзүүлэлттэй. Гэвч тусгай зориулалтын тоног төхөөрөмж болон технологийг бусад байгууллагуудтай дундаа хэрэглэдэггүй, цахилгаан эсвэл түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгсэл ашигладаггүй. Мөн дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол ашиглах, сав баглаа боодлыг эргүүлэн авах тогтолцоогүй, сэргээгдэх эрчим хүч ашигладаггүй. Түүхий эд материалын худалдан авалтын явцад лабораторийн чанарын баталгааны бичигтэй байх, багцалсан эсвэл сав баглаа нь материалын хэмнэлттэй байх шаардлагыг бэлтгэн нийлүүлэгчээс шаарддаг боловч худалдан авч буй тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигладаг байх, бүтээгдэхүүнээс гарах хог хаягдал, сав баглааг буцааж авах тогтолцоотой байх, олон удаа хэрэглэгддэг байх зэрэг шаардлагуудыг чухалчилдаггүй. Эдийн засгийн хэмнэлттэй байх зарчмын хүрээнд үйлдвэрлэгчдийн хэрэгжүүлж буй хамгийн түгээмэл туршлагаас дурдвал шөнийн хөнгөлөлттэй цагаар ажиллах, усны хэрэглээнд хяналт тавих хандлага сайн байна.

График 24. Хүнс, ус ундаа үйлдвэрлэгч нарын тойрог эдийн засгийн туршлага


ТЭЗ-ийн туршлага, хүнс ус ундаа үйлдвэрлэл



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Жижиглэн худалдаа үйлчилгээний дэд салбар. Жижиглэн худалдаа, агуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тойрог эдийн засгийн туршлагуудыг тодорхойлох зорилгоор 7R зарчмын хүрээнд нийт 17 асуултыг үнэлүүллээ. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийдэг, цэвэрлэгээг тогтмол хийдэг, хэрэглээний усаа байнга хэмнэж, хэвшсэн гэдэг нь хамгийн өндөр үзүүлэлтүүдтэй туршлага байсан.

График 25. Жижиглэн худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Мөн агуулахын шал, хана, тааз нь галд тэсвэртэй материалаар хийгдсэн, тоног төхөөрөмжүүд цахилгаан бага зарцуулдаг, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах сургалтыг байнга явуулдаг гэсэн туршлагауд дундаж үзүүлэлттэй байна. Гэвч тусгай зориулалтын тоног төхөөрөмж болон технологийг бусад байгууллагуудтай дундаа хэрэглэх, цахилгаан эсвэл түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгсэл ашиглах, дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол ашиглах, сав баглаа боодлыг эргүүлэн авах, сэргээгдэх эрчим хүч ашиглах гэсэн туршлагауд хангалтгүй байна.

4.2.3. Тойрог эдийн засгийн туршлагын зөрүүтэй байдал

Судалгааны үр дүнд үндэслэн дэд салбаруудын тойрог эдийн засгийн туршлагыг бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид хэрхэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байгааг дараах үзүүлэлтүүдээр үнэлж, нэгтгэн харууллаа. Үүнд:

1. Монгол улсад хэрэгжиж буй стандартууд
2. Хүрээлэн буй орчиндоо хариуцлагатай байдал
3. Тойрог эдийн засгийн бодлогын бичиг баримт
4. Тойрог эдийн засгийн хэмжих үзүүлэлт / индикатор
5. Хамтын ажиллагаа

Хүснэгт 17. ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

| № | Тойрог эдийн засгийн туршлагын элементүүд | Газар тариалан | Зөгийн аж ахуй | Хоол, ус ундаа үйлдвэрлэгч | Жижиглэн худалдаа |
|----|---|----------------|----------------|----------------------------|-------------------|
| 1. | Үндэсний стандартууд, засгийн газрын бодлогын хэрэгжилт | + | - | + | + |
| 2. | Хүрээлэн буй орчны хариуцлагатай байдал | - | - | + | + |
| 3. | Байгууллагын тойрог эдийн засгийн бодлогын бичиг баримт | + | + | - | - |
| 4. | Тойрог эдийн засгийн туршлагын хэмжих үзүүлэлтүүд | - | - | - | - |
| 5. | Хамтын ажиллагаа | - | + | n/a | + |

Эх үүсвэр: Судалгааны баг

Үүнээс харахад газар тариалангийн салбарын байгууллагууд байгаль орчинд ээлтэй тариаланг хөгжүүлэх болон хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бодлогын бичиг баримт болох төсөл төлөвлөгөө сайтай байгаа нь газар тариалангийн салбарт санхүүжилт болон хөнгөлөлттэй зээлийн боломжууд харьцангуй илүү байгааг харуулж байна. Мөн үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа стандартуудыг боломжийн түвшинд дагаж мөрддөг. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн хувьд бусад зөгийн аж ахуй эрхлэгчидтэй хамтран ажилладаг туршлага бусад дэд салбаруудаас илүү байна. Харин хоол, ус, ундаа үйлдвэрлэгч болон жижиглэнгийн худалдааны байгууллагууд үндэсний хэмжээний стандартуудыг дагаж мөрддөг, хүрээлэн буй орчиндоо ээлтэй байх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Гэвч дээрх 4 дэд салбарын аль нь ч тойрог эдийн засгийн туршлагыг хэвшүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг ашигладаггүй.

Аливаа байгууллагын үндсэн үйл ажиллагаанд 1) түүхий эд материалын ухаалаг сонголт, эко худалдан авалт, 2) үйлдвэрлэлийн явцын үр ашигтай байдал, 3) эцэст нь хэрэглээнд оруулах 3 алхам / орц, хувиргалт, гарц / бүрд бий болох тойрог эдийн засгийг бий болгох шаардлагатай байгаа юм. Иймээс 7R зарчмын хүрээнд бизнесийн байгууллагуудын

хэрэгжүүлж буй өнөөгийн туршлагыг үнэлж, хүснэгтэд нэгтгэн дүгнэлээ. Тойрог эдийн засаг, эко үйлдвэрлэлийн туршлагыг судалснаар Монгол улсад эдийн засгийн хэмнэлттэй, хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж ямар түвшинд байгаа болон аль хэсэгт туршлага хангалтгүй, зөрүү ихтэй байгааг харах боломж бүрдэж байна.

Газар тариалангийн дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Газар тариалан эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага зөвхөн нөөцөд түлхүү анхаарлаа хандуулсан хэв маяг давамгайлж байна.

Хүснэгт 18. Газар тариалангийн салбарын ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

| ТЭЗ-ийн элемент | Туршлагууд | | | | | | |
|-----------------|------------|-------------------------|-----------|----------------|-------|------------------|---|
| | Татгалзах | Дахин болох /загварчлах | Бууруулах | Дахин хэрэглэх | Засах | Дахин үйлдвэрлэх | Дахин боловсруулах |
| Орц | + | | | | | | Байгалийн органик ба био бордоо ашигладаг /14.1/ |
| Орц | + | | | | | | Байгалийн органик ба био үр тариа ашигладаг /14.2/ |
| Орц | + | | | | | | Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх органик бордоо ашигладаг /14.3/ |
| Орц | + | | | | | | Амьтны өтөг бууц хөрсөнд ашигладаг /14.4/ |
| Орц | + | | | | | | Хортон шавж ургамал, өвчний эсрэг байгалийн гаралтай бэлдмэл ашигладаг /14.5/ |
| Орц | + | | | | | | Хөрсөнд задрах боломжтой бортого ашигладаг/14.6/ |
| Хувиргалт | | | | | + | | Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийдэг/14.15/ |
| Хувиргалт | | | | | + | | Тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ хийдэг |
| Гарц/хэрэглээ | | | + | | | | Борооны ус, саарал ус ашигладаг/14.18 / |

Эх үүсвэр: Судалгааны баг

Сайн талууд:

- Газар тариалан эрхлэгчдийн хамгийн ихээр анхаарлаа хандуулж байгаа тойрог эдийн засгийн элемент нь байгалийн нөөц ашиглалт болон түүний нөхөн сэргээлт бөгөөд органик түүхий эд материалаар хөрсийг бордож, байгаль орчинд хор хөнөөлтэй сонголтуудаас татгалздаг.

Дутагдалтай талууд:

- Тариалалт болон хураах үйл явцад ашиглагдаж буй нөөцийг үр ашигтай хэрэглэх, ургац хураах үйл явц болон тариалах үйл явцаа ухаалаг болгох, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажиллах бизнесийн загвар, хэв маягаа өөрчилж чаддаггүй.
- Дахин загварчлах зорилгоор нөөцийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлдэггүй.
- Дахин хэрэглэгдэх болон дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодлын туршлага муу.
- Цахилгаан эрчим хүч болон түлш бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаггүй.

Зөгийн аж ахуйн дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Зөгийн аж ахуй мөн адил нөөцөд түлхүү анхаарлаа хандуулдаг, үйл ажиллагааны явцад эко туршлагауудыг хэвшүүлж эхэлж байгаа хэв маягтай байна.

Хүснэгт 19. ЗАА эрхлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

| ТЭЗ-ийн элемент | Туршлагаууд | | | | | | | |
|-----------------|-------------|-------------------------|-----------|----------------|-------|------------------|--------------------|---|
| | Татгалзах | Дахин бодох /загварчлах | Бууруулах | Дахин хэрэглэх | Засах | Дахин үйлдвэрлэх | Дахин боловсруулах | |
| Орц | + | | | | | | | Тэсвэр хатуужилтай зөгийн үүлдэртэй /15.1/ |
| Орц | + | + | | | | | | Өвчин эсэргүүцэх, халдвараас урьдчилан сэргийлэх тохиромжтой арга хэрэгсэлтэй /15.2/ |
| Орц | + | | | | | | | Органик зөгийн бал, чихрийн сироп зэрэг органик тэжээл ашигладаг /15.3/ |
| Орц | + | | | | | | | Органик газар тариалантай 3км-н радиуст ойр байрладаг /15.4/ |
| Орц | + | | | | | | | Ургамлын гаралтай эмчилгээний бүтээгдэхүүн ашигладаг /15.6/ |
| Орц | + | | | | | | | Зөгийн үүрийг хийхдээ байгалийн гаралтай материал ашигладаг 15.7/ |
| Орц | + | | | | | | | Малын бууц зэрэг байгалийн гаралтай утааны материал ашигладаг /15.8/ |
| Орц | + | | | | | | | ЗАА эрхлэх, боловсруулах, хадгалах үйл ажиллагаанд тогтмол бүртгэл, хяналтын оновчтой системтэй 15.10 |
| Орц | | | | + | | | | Дахин боловсруулсан материалаар хийгдсэн сав, баглаа боодол ашигладаг 15.9 |
| Орц | | | | + | | | | Дахин боловсруулах боломжтой сав, баглаа боодол ашигладаг 15.11 |
| Үйлдвэрлэл | | | | | + | | | Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийдэг 15.15 |
| Үйлдвэрлэл | | | | | + | | | Тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ хийдэг 15.16 |

| | | | |
|---------------|---|---|--|
| Гарц/хэрэглээ | + | + | Ажилтнуудад бүтээгдэхүүнийг ангилах, хадгалах, ашиглах талаар сургалт тогтмол хийдэг /15.17/ |
|---------------|---|---|--|

Эх үүсвэр: Судалгааны баг

Сайн талууд:

- Зөгийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай түүхий эд материалын ухаалаг сонголтыг хийж, аль болох химийн гаралтай бодис оролцсон түүхий эдээс татгалздаг.
- Тоног төхөөрөмжийн урсгал засвар, цэвэрлэгээ болон эвдрэл гэмтлийг дотооддоо засварлах туршлагыг хэвшүүлсэн.

Дутагдалтай талууд:

- Саарал ус болон гадаргын ус ашигладаггүй.
- Дахин загварчлах зорилгоор нөөцийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлдэггүй.
- Цахилгаан эрчим хүч болон түлш бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаггүй.
- Сав баглаа боодлоо буцаан авах тогтолцоо байхгүй.
- Дахин үйлдвэрлэх болон өөр зорилгоор бүтээгдэхүүний хэрэглээг уртасгадаггүй.

Үйлдвэрлэлийн дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Үйлдвэрлэгчдийн хувьд бүтээгдэхүүний үндсэн түүхий эд материалын худалдан авалтад өндөр шаардлага тавьдаг боловч үйл ажиллагаандаа эко туршлага хэвшүүлсэн байдал хангалтгүй байна.

Хүснэгт 20. ХУУҮ-н ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

| ТЭЗ-ийн элемент | Туршлагауд | | | | | | |
|-----------------|------------|-------------------------|-----------|----------------|-------|------------------|--|
| | Татгалзах | Дахин бодох /загварчлах | Бууруулах | Дахин хэрэглэх | Засах | Дахин үйлдвэрлэх | Дахин боловсруулах |
| Орц | | | + | | | | Манай компани хэрэглээний усаа хэмнэдэг /15.1/ |
| Орц | + | | | | | | Манай байгууллага бүтээгдэхүүнийхээ орц найрлагын гарал үүсэл, баталгаажилт, тээвэрлэлтийг байнга шалгаж, үйлдвэрлэлд оруулдаг /15.15/ |
| Орц | + | | + | | | | Багцалсан эсвэл сав баглаа нь материалын хэмнэлттэй байх /16.3/ |
| Орц | + | | | | | | Боловсруулах тоног төхөөрөмж, технологи нь эрчим хүч бага зарцуулдаг байх /16.5/ |
| Орц | + | | | | | | Хэрэглээний явцад гарах нэмэлт зардал гардаггүй байх /16.7/ |
| Орц | + | | | | | | Түүхий эд материалын лабораторийн чанарын баталгааны бичигтэй байх /16.8/ |

| | | | | |
|------------|---|---|---|--|
| Үйлдвэрлэл | + | | | Манай компани эрчим хүч бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаг /15.2/ |
| Үйлдвэрлэл | + | | | Шөнийн хөнгөлөлттэй цагаар ашигладаг /22/ |
| Үйлдвэрлэл | | + | | Бид тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээгээ өөрсдөө хийдэг /15.8/ |
| Үйлдвэрлэл | | | + | Манай компани хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, дахин боловсруулах систем нэвтрүүлсэн /15.12/ |
| Үйлдвэрлэл | + | | | Манай компани хадгалалт, тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүний зохих бүртгэлийг хийж, зориулалтын тээврийн хэрэгсэл ашигладаг /15.16/ |

Эх үүсвэр: Судалгааны баг

Сайн талууд:

- Ус болон цахилгааны зохистой хэрэглээг хянах, хэмнэх тогтолцоо бий болсон.
- Тоног төхөөрөмжийн урсгал засвар, цэвэрлэгээ болон эвдрэл гэмтлийг дотооддоо засварлах туршлагыг хэвшүүлсэн.

Дутагдалтай талууд:

- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигладаггүй, саарал ус ашигладаггүй.
- Хөрсөнд шингэх болон дахин боловсруулсан материалаар хийсэн баглаа боодол ашигладаггүй.
- Сав баглаа боодлоо буцаан авах тогтолцоо байхгүй.
- Дахин үйлдвэрлэх болон өөр зорилгоор бүтээгдэхүүний хэрэглээг уртасгадаггүй.
- Дахин загварчлах зорилгоор нөөцийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлдэггүй.
- Эдийн засгийн хэмнэлттэй хэрэглээг дэмжсэн самбар болон танилцуулах хуудас ажлын байранд байршуулдаггүй.
- Хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхэлснээр байгууллагад ирэх өгөөжийг бүрэн ойлгоогүй.

Жижиглэн худалдаа үйлчилгээний дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Жижиглэнгийн худалдаа, тээвэрлэлт, хадгалах агуулах үйлчилгээний хувьд үйл ажиллагаандаа эко туршлага хэвшүүлсэн байдал хангалтгүй байна.

Хүснэгт 21. ЖХҮ эрхлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

| ТЭЗ-ийн элемент | Туршлагууд | | | | | | |
|-----------------|------------|-------------------------|-----------|----------------|-------|------------------|---|
| | Таггалзах | Дахин бодох /загварчлах | Бууруулах | Дахин хэрэглэх | Засах | Дахин үйлдвэрлэх | Дахин боловсруулах |
| Үйл ажиллагаа | | | + | | | | Манай компани хэрэглээний усаа хэмнэдэг/14.1/ |
| | | | | | + | | Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийдэг/14.6/ |
| | | | | | + | | Тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ хийдэг /14.7/ |

Эх үүсвэр: Судалгааны баг

Сайн талууд:

- Усны зохистой хэрэглээг хянах, хэмнэх тогтолцоо бий болсон.
- Тоног төхөөрөмжийн урсгал засвар, цэвэрлэгээ болон эвдрэл гэмтлийг дотооддоо засварлах туршлагыг хэвшүүлсэн.

Дутагдалтай талууд:

- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигладаггүй, саарал ус ашигладаггүй.
- Бага түлш зарцуулдаг эсвэл цахилгаан тээврийн хэрэгсэл ашигладаггүй.
- Агуулах болон үйлчилгээний талбай нь дахин боловсруулсан материалаар хийсэн тохижилт байхгүй.
- Галд тэсвэртэй, байгальд хор хөнөөлгүй байх шаардлагыг хангаагүй.
- Сав баглаа боодлыг эргүүлэх авах тогтолцоо байхгүй.

Хүнс хөдөө аж ахуйн салбарын хүнс, ундаа усны үйлдвэрлэлийн бичил, жижиг, дунд бизнесийн байгууллагуудын тойрог эдийн засгийн туршлагын өнөөгийн нөхцөл байдлын болон өдөр тутмын үйл ажиллагааны дадлуудад хийсэн шинжилгээгээр түүхий эд материалын худалдан авалтын үед бэлтгэн нийлүүлэгчид тавих шаардлага өндөр байдаг нь байгаль орчинд хор хөнөөлтэй, эдийн засгийн хэмнэлтгүй зүйлсээс татгалзах хандлага маш өндөр бөгөөд 7R-ийн татгалзах /refuse/ дадал сайн байна. Дэд салбар тус бүрийн үйлдвэрлэлийн явцад дахин бодож эргэцүүлэх, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэх, нийгэм хүрээлэн буй орчинд дасан зохицох, бүтээгдэхүүнээ дахин загварчлах чадвар /rethink, redesign/ хангалтгүй түвшинд байна. Харин бууруулах дадал /reduce/ байгууллагуудын хэмжээнд зөвхөн өөрсдийн чадах түвшинд усаа хэмнэх, оройн цагаар цахилгаан их хэрэглэх зэргээр ажиллаж байна. Өөрөөр хэлбэл гадны үйл ажиллагаа, байгууллага, оролцогч талуудын дэмжлэгтэй хэмнэх процесс байхгүй байна. Дахин хэрэглэх /reuse/ сэтгэлгээ тогтоогүй, дахин хэрэглэх, хэрэглээг өөрчлөх зэргээр тухайн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгахгүй байна. Дотоод үйл ажиллагааны явцад гарсан эвдрэл гэмтлийг засах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмолжуулах тал

дээр байгууллагуудын туршлага сайн байдаг. Дахин үйлдвэрлэх туршлага дэд салбаруудын хувьд байхгүй гэж хэлж болно. Дахин боловсруулах туршлага нь нийгэмд хамгийн ихээр яригддаг сэдэв болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа боловч хэрэгжүүлэх үйл явц дутмаг бөгөөд зөвхөн сургалт, судалгааны түвшинд байна.

5. НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭ


5.1. Нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ

НӨС-ний шинжилгээг газар тариалан, зөгийн аж ахуй, үйлдвэрлэгч, жижиглэнгийн худалдаа үйлчилгээ гэсэн дэд салбараар хийж, нэмүү өртгийн сүлжээний зураглал гаргалаа.

5.1.1. Газар тариалангийн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ

Үнэлгээний үр дүнгээс газар тариалангийн эрхлэгчдийн НӨС нь орц, боловсруулалт, гарц буюу түгээх гэсэн үе шатуудаас бүрдэж байна. Газар тариалангийн бүтээгдэхүүнийг 8% нь үр тариа, 62% нь төмс, хүнсний ногоо, 9% нь нарийн ногоо, үлдсэн 8% нь жимс жимсгэнэ тариалагчид бүрдүүлж байна. Газар тариалан эрхлэгчдийг ажилчдын тоог шалгуур үзүүлэлт болгон БЖДҮ гэж ангилсан ба 80% нь бичил, 19% нь жижиг, 1% нь дунд үйлдвэрлэгч нар байна. Тэдгээрийн 41% нь 1 хүртэл, 42% нь 1-5 га, 8% нь 5-10 га, 4% нь 10-50 га, үлдсэн 5% нь 50 га-с дээш талбайд газар тариалан эрхэлдэг ба газрын эзэмшил 89% нь өөрийн, 10% нь түрээсэлдэг байна. Тойрог эдийн засгийн туршлагын хэсэгт (Бүлэг 4) хийгдсэн шинжилгээний зарим үр дүнгээс харахад борооны ус саарал усны ашиглалт 53%, байгалийн гаралтай органик үр ашиглалт 79%, байгалийн гаралтай органик бордоо ашиглалт 76%, хортон шавж, хогийн ургамал, өвчлөлөөс сэргийлэх байгалийн гаралтай органик бодис ашиглалт 58%, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн ашиглалт 20%, олон дахин ашиглах боломжтой материал ашиглалт 38%, дахин боловсруулах боломжтой материал ашиглалт 34%, дахин боловсруулагдсан материал ашиглалт 27%, тариалан эрхлэгчдийн 80% нь 1-10 ажилтантай, 18% нь 11-30 ажилтантай байна. Органик бордоо, үр, тэжээл, бодисыг 33% нь өөрсдөө боловсруулдаг, 25% нь дотоодын аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авдаг, 24% нь бөөний болон жижиглэнгийн худалдаачдаас худалдан авдаг, 15% нь импортлогч байгууллагуудаас худалдан авдаг байна.


График 26. Газар тариалан эрхлэгчдийн орц



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Газар тариалан эрхлэгчдийн 49% нь ил талбайд, 46% нь зуны хүлэмжид, 4% нь өвлийн хүлэмжид тариалан эрхэлдэг. Тойрог эдийн засгийн туршлагын хэсэгт (Бүлэг 3.6) хийгдсэн шинжилгээний зарим үр дүнгээс харахад тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ 68% хийдэг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ 67% хийдэг, хүнсний ногоо, жимсийг зооринд, үр тариаг энгийн энгийн агуулахад хадгалдаг.

График 27. Тариалангийн хэлбэр



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Газар тариалан эрхлэгчдийн 7.8% нь МҮХАҮТ - "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго, 8.3% нь Хөдөө аж ахуйн зохистой дадал, 6.5% нь ХХААХҮЯ - Органик хүнснийг баталгаажуулсан тэмдэг, 9.6% нь ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, 6.5% нь ISO14001 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлдэг.


Хүснэгт 22. Газар тариалан ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал

| | | Ийм ойлголтын талаар мэдэхгүй, сонсож байгаагүй | Үгүй, ямар нэг төлөвлөгөө байхгүй | Үгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа | Тийм, хэрэгжүүлж эхэлж байгаа | Тийм, хэрэгжүүлдэг | Нийт |
|---|-----|--|--|---|--|-----------------------|---------|
| МҮХАҮТ - "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго | Тоо | 27 | 75 | 99 | 10 | 18 | 229 |
| | % | 11.79% | 32.75% | 43.23% | 4.37% | 7.86% | 100.00% |
| ХХААХҮЯ - Органик хүнийг баталгаажуулсан тэмдэг | Тоо | 28 | 81 | 95 | 10 | 15 | 229 |
| | % | 12.23% | 35.37% | 41.48% | 4.37% | 6.55% | 100.00% |
| Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) | Тоо | 35 | 68 | 97 | 10 | 19 | 229 |
| | % | 15.28% | 29.69% | 42.36% | 4.37% | 8.30% | 100.00% |
| ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо | Тоо | 30 | 64 | 100 | 13 | 22 | 229 |
| | % | 13.10% | 27.95% | 43.67% | 5.68% | 9.61% | 100.00% |
| ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо | Тоо | 33 | 73 | 97 | 11 | 15 | 229 |
| | % | 14.41% | 31.88% | 42.36% | 4.80% | 6.55% | 100.00% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Бүтээгдэхүүний 60% нь Улаанбаатар хотод, 40% нь орон нутагтаа борлуулдаг ба жижиглэнгийн худалдаачдад 27%, бөөний худалдаачдад 29%, 24% нь шууд эцсийн хэрэглэгчдэд, 6% нь хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд, 6% нь зуучлагчдад, 4% нь боловсруулах үйлдвэрт, 4% нь хоршоо нөхөрлөлд борлуулдаг байна. Экспорт огт хийдэггүй байна. Тариалангийн хог хаягдлаа 41% нь бордоо хийдэг, 27% нь малын тэжээл болгодог, 11% нь шатааж утгадаг, 3% газар дүүргэлтэд ашигладаг үлдсэн 16% нь хаядаг байна.


График 28. Газар тариалангийн гарц



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Дээр дурдсан шинжилгээнд үндэслэн өртгийн сүлжээг зураглан харуулбал дараах байдалтай байна. Зургаас харахад газар тариалан эрхлэгчдийн хувьд ХАА, органик гэрчилгээ авсан байдал хангалтгүй, судалгаа шинжилгээ огт хийдэггүй, борлуулалтын сүлжээн тоо хязгаарлагдмал буюу ихэвчлэн бөөний худалдаачдад борлуулдаг. Экспорт огт хийдэггүй гэсэн дутагдалтай талуудтай байна.

Зураг 11. Газар тариалангийн өртгийн сүлжээний зураглал



Эх үүсвэр: Судалгааны баг

5.1.2. Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ

Зөгийн аж ахуй эрхлэгчдийн 36% нь зөгий үржүүлэг, 64% нь зөгийн бал боловсруулдаг байна. Нэмүү өртгийн сүлжээний орцод 85% нь бичил, 13% нь жижиг, 2% нь дунд


үйлдвэрлэгч бүрдүүлж байна. ЗАА эрхлэгчдийн 51% нь 10 хүртэл, 33% нь 10-49 га, 16% нь 50 га-с дээш талбай ашигладаг.

Тойрог эдийн засгийн туршлагын хэсэгт (Бүлэг 4) хийгдсэн шинжилгээний зарим үр дүнгээс харахад борооны ус саарал усны ашиглалт 36%, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн ашиглалт 33%, байгалийн гаралтай материал ашиглалт 95%, олон дахин ашиглах боломжтой материал ашиглалт 93%, дахин боловсруулах боломжтой материал ашиглалт 62%, дахин боловсруулагдсан материал ашиглалт 40% байна.

Зөгийн аж ахуй эрхлэгчдийн 85% нь 1-10 ажилтантай, 9% нь 11-30 ажилтантай, 6% нь 31-с дээш ажилтантай байна.

Байгалийн гаралтай материалаа 35% дотоодын зөгий аж ахуй эрхлэгч, байгууллагуудаас, 26% нь бөөний болон жижиглэнгийн худалдаачдаас, 17% нь өөрсдөө импортлодог, 18% нь импортлогч байгууллагуудаас худалдан авдаг байна. Судалгаа шинжилгээ бага хийдэг боловч байгууллагуудын ажилтнуудын сургалтыг тогтмол хийдэг байна.


График 29. Зөгийн аж ахуйн орц



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Зөгийн аж ахуй нь үржүүлэх, хураах, хадгалах, боловсруулах, савлах үйл ажиллагаанаас бүрдэх ба тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ 87% хийдэг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ 84% хийдэг. Зөгийн балаа 49% нь модон торхонд, 31% нь шилэн саванд хадгалдаг.

График 30. Зөгийн балаа хадгалдаг аргууд



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Зөгийчдийн 12.7% нь ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг, 18% нь Хөдөө аж ахуйн зохистой дадал, 10.9% нь ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, 10.9% нь ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлдэг.

Хүснэгт 23. Зөгийн аж ахуйн ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал


| | Ийм ойлголтын талаар мэдэхгүй, сонсож байгаагүй | Үгүй, ямар нэг төлөвлөгөө байхгүй | Үгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа | Тийм, хэрэгжүүлж эхэлж байгаа | Тийм, хэрэгжүүлдэг | Нийт | |
|---|---|-----------------------------------|--------------------------------------|-------------------------------|--------------------|--------|---------|
| МУХАҮТ - "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго | Тоо | 2 | 12 | 30 | 1 | 10 | 55 |
| | % | 3.64% | 21.82% | 54.55% | 1.82% | 18.18% | 100.00% |
| ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг | Тоо | 2 | 12 | 32 | 2 | 7 | 55 |
| | % | 3.64% | 21.82% | 58.18% | 3.64% | 12.73% | 100.00% |
| Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) | Тоо | 8 | 8 | 25 | 4 | 10 | 55 |
| | % | 14.55% | 14.55% | 45.45% | 7.27% | 18.18% | 100.00% |
| ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо | Тоо | 7 | 9 | 26 | 7 | 6 | 55 |
| | % | 12.73% | 16.36% | 47.27% | 12.73% | 10.91% | 100.00% |
| ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо | Тоо | 7 | 12 | 25 | 5 | 6 | 55 |
| | % | 12.73% | 21.82% | 45.45% | 9.09% | 10.91% | 100.00% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Бүтээгдэхүүний 51% нь Улаанбаатар хотод, 49% нь орон нутагтаа борлуулдаг ба жижиглэнгийн худалдаачдад 27%, бөөний худалдаачдад 17%, 45% нь шууд эцсийн хэрэглэгчдэд, 2% нь хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд, 3% нь зуучлагчдад 3% нь

боловсруулах үйлдвэрт, 3% нь хоршоо нөхөрлөлд борлуулдаг байна. Экспорт огт хийдэггүй байна, хог хаягдал бараг байдаггүй үйлдвэрлэл юм.


График 31. Зөгийн аж ахуйн гарц



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн шинжилгээнд үндэслэн зураглал гаргахад ногоон гэрчилгээнд авсан байдал маш бага, судалгаа шинжилгээ хангалтгүй байгаа нь харагдаж байна. Зөгийн аж ахуйн онцлог нь хаягдал багатай байдаг ба бэлэн бүтээгдэхүүнээ борлуулах сувгууд газар тариалантай мөн адил жижиглэнгийн худалдаа, бөөний худалдаа, эцсийн хэрэглэгчдэд шууд борлуулах гэсэн сувгуудыг голчлон ашигладаг дутагдалтай талуудтай байна. Экспорт огт хийдэггүй байна.

Зураг 12. Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний зураглал




Эх үүсвэр: Судалгааны баг

5.1.3. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ

Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн 61% нь хүнсний үйлдвэрлэл, 25% нь ус ундааны үйлдвэрлэл, 7% нь нийтийн хоолны үйлдвэрлэл гэсэн бүтэцтэй байна.

График 32. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаа



Эх үүсвэр: Судалгааны үр дүн


Хүнс, ус ундаа үйлдвэрлэгчдийн 55% нь бичил, 36% нь жижиг, 6% нь дунд үйлдвэрлэгч бүрдүүлж байна. Тэдгээрийн 37% нь 100 мкв хүртэл, 23% нь 101-200 мкв, 16% нь 201-500 мкв, 10% нь 501-1000 мкв, 15% нь 1001-с дээш мкв талбайд үйлдвэрлэл явуулдаг.

Тойрог эдийн засгийн туршлагын хэсэгт (Бүлэг 4) хийгдсэн шинжилгээний зарим үр дүнгээс харахад 96% нь усаа хэмнэдэг, сэргээгдэх эрчим хүч ашиглалт 10%, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн ашиглалт 61%, хөрсөнд хурдан задрах түүхий эд материал ашиглалт 47%, олон дахин ашиглах боломжтой материал ашиглалт 41%, дахин боловсруулагдсан материал ашиглалт 44% байна.

Үндсэн ТЭМ нь 74% боловсруулаагүй жимс, хүнсний ногоо, ургамал байдаг бол 26% нь бэлэн бэлдэц, сироп, химийн аргаар гарган авсан орлуулагч ашигладаг. Үйлдвэрлэгчдийн 55% нь 1-10 ажилтантай, 28% нь 11-30 ажилтантай, 8% нь 31-50 ажилтантай, 9% нь 51-с дээш ажилтантай.

Түүхий эд материалаа 38% дотоодын үйлдвэрлэгч, байгууллагуудаас, 24% нь бөөний болон жижиглэнгийн худалдаачдаас, 18% нь импортлогч байгууллагуудаас, 12% өөрсдөө импортлож оруулж ирдэг, үлдсэн 8% нь өөрсдөө боловсруулдаг.

График 33. ХУУУ-н орц




Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн процесс харилцан адилгүй байдаг ба тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийдэг. Бэлэн бүтээгдэхүүнээс 38% нь гялгар уут,

18% дахин боловсруулсан хуванцар сав, 18% дахин боловсруулсан цаасан материал, 10% нь шил, 6% даавуун уутанд хадгалдаг.

График 34. Хүнс, ус ундааны хадгалалт



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Үйлдвэрлэгчдийн 13.1% нь ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг, 15.6% нь Хөдөө аж ахуйн зохистой дадал, 20% нь ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, 13.7% нь ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлдэг.

Хүснэгт 24. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал

| | Ийм ойлголтын талаар мэдэхгүй, сонсож байгаагүй | Үгүй, ямар нэг төлөвлөгөө байхгүй | Үгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа | Тийм, хэрэгжүүлж эхэлж байгаа | Тийм, хэрэгжүүлдэг | Нийт |
|--|---|-----------------------------------|--------------------------------------|-------------------------------|--------------------|----------------|
| МҮХАҮТ - "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго | Тоо 15 % 9.38% | 37 23.13% | 76 47.50% | 11 6.88% | 21 13.13% | 160 100.00% |
| ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг | Тоо 11 % 6.88% | 47 29.38% | 75 46.88% | 6 3.75% | 21 13.13% | 160 100.00% |
| Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) | Тоо 23 % 14.38% | 46 28.75% | 50 31.25% | 16 10.00% | 25 15.63% | 160 100.00% |
| ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо | Тоо 11 % 6.88% | 39 24.38% | 56 35.00% | 22 13.75% | 32 20.00% | 160 100.00% |
| ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо | Тоо 20 % 12.50% | 45 28.13% | 55 34.38% | 18 11.25% | 22 13.75% | 160 100.00% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Бүтээгдэхүүний 50% нь Улаанбаатар хотод, 49% нь орон нутагтаа борлуулдаг, 1% нь экспортолдог ба жижиглэнгийн худалдаачдад 33%, бөөний худалдаачдад 24%, 26% нь шууд эцсийн хэрэглэгчдэд, 8% нь хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд, 5% нь зуучлагчдад, 2% нь боловсруулах үйлдвэрт, 2% нь хоршоо нөхөрлөлд борлуулдаг байна. Үйлдвэрлэлийн хог хаягдлаа 10% бордоо хийдэг, 9% шатааж устгадаг, 2% газар дүүргэлтэд ашигладаг, 19% малын тэжээл болгодог, 16% борлуулдаг, боловсруулахгүй хаядаг 37% байна.


График 35. ХУУҮ-н гарц



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн хувьд судалгаа шинжилгээ бага, ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал бусад дэд салбаруудтай харьцуулахад харьцангуй өндөр, багахан хэмжээний экспорт хийдэг. Мөн үйлдвэрлэлийн хог хаягдлаа дахин борлуулдаг туршлага байдаг байна. Гурил, гурилан бүтээгдэхүүний хувьд эцсийн бүтээгдэхүүн хүртэл нэмүү өртгийн сүлжээ хөгжсөн байдаг бол төмс, хүнсний ногоо, нарийн ногоо, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн сүлжээ хөгжил тааруу байна.

Зураг 13. Хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний зураглал




Эх үүсвэр: Судалгааны баг

5.1.4. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ

Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн 47% нь жижиглэнгийн худалдаа, 37% хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ, 7% нь агуулах, 8% нь тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байна. Тэдгээрийн 85% нь бичил, 11% нь жижиг, 4% нь дунд болон том байгууллага бүрдүүлж байна. Тэдгээрийн 11% нь 10 мкв хүртэл, 30% нь 10-30 мкв, 16% нь 31-50 мкв, 21% нь 51-100 мкв, 12% нь 101-200 мкв, 6% нь 201-500 мкв, 4% нь 501-с дээш мкв талбайд үйл ажиллагаа явуулдаг.

Тойрог эдийн засгийн туршлагын хэсэгт (Бүлэг 4) хийгдсэн шинжилгээний зарим үр дүнгээс харахад хэрэглээний усны хэмнэлт 85%, борооны ус, саарал ус ашиглалт 17%, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн ашиглалт 39%, олон дахин ашиглах боломжтой материал ашиглалт 35%, дахин боловсруулагдсан материал ашиглалт 38% байна. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн 85% нь 1-10 ажилтантай, 11% нь 11-30 ажилтантай, 4% нь 31-с дээш ажилтантай.


График 36. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний орц



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ 82%, тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ 83%. Бэлэн бүтээгдэхүүнээ 34% нь зориулалтын агуулахад, 46% нь хөргөгч, хөлдөөгчид, 14% нь хөргүүртэй машинд хадгалдаг.

График 37. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээний бүтээгдэхүүний хадгалалт



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн 12% нь ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг, 10% нь Хөдөө аж ахуйн зохистой дадал, 23% нь ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, 10.8% нь ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлдэг.


Хүснэгт 25. Жижиглэнгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчид ногоон гэрчилгээнд хамрагдсан байдал

| | | Ийм ойлголтын талаар мэдэхгүй, сонсож байгаагүй | Үгүй, ямар нэг төлөвлөгөө байхгүй | Үгүй, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа | Тийм, хэрэгжүүлж эхэлж байгаа | Тийм, хэрэгжүүлдэг | Нийт |
|---|-----|---|-----------------------------------|--------------------------------------|-------------------------------|--------------------|---------|
| МҮХАҮТ - "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго | Тоо | 46 | 104 | 82 | 24 | 42 | 298 |
| | % | 15.44% | 34.90% | 27.52% | 8.05% | 14.09% | 100.00% |
| ХХААХҮЯ - Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг | Тоо | 48 | 108 | 73 | 34 | 35 | 298 |
| | % | 16.11% | 36.24% | 24.50% | 11.41% | 11.74% | 100.00% |
| Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) | Тоо | 73 | 104 | 60 | 31 | 30 | 298 |
| | % | 24.50% | 34.90% | 20.13% | 10.40% | 10.07% | 100.00% |
| ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо | Тоо | 46 | 71 | 69 | 43 | 69 | 298 |
| | % | 15.44% | 23.83% | 23.15% | 14.43% | 23.15% | 100.00% |
| ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоо | Тоо | 66 | 98 | 64 | 38 | 32 | 298 |
| | % | 22.15% | 32.89% | 21.48% | 12.75% | 10.74% | 100.00% |

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Хэрэглэгчдийн 69% шууд эцсийн хэрэглэгчдэд, 21% байгууллагын хэрэглэгчдэд, 8% нь төрийн байгууллага бүрдүүлж байна.


График 38. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний хэрэглэгчид



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний өртгийн сүлжээний шинжилгээнд үндэслэн өртгийн сүлжээний зураглал хийхэд бусад дэд салбаруудтай харьцуулахад харьцангуй энгийн загвартай байна. Засгийн газар, төрийн байгууллагуудад багахан хэмжээний борлуулалт хийдэг байна.

Зураг 14. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний өртгийн сүлжээний зураглал



Эх үүсвэр: Судалгааны баг

5.2. Нэмүү өртгийн сүлжээний саад бэрхшээл (bottleneck)

ХААХУУҮС-ын нэмүү өртгийн сүлжээний нарийвчилсан шинжилгээнд суурилан нэмүү өртгийн сүлжээнд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж БЖДБЭ-ийн өрсөлдөх чадварыг хэрхэн нэмэгдүүлэх боломжуудын санал гаргасан.

Салбарын өрсөлдөөний нөхцөл байдлыг харвал бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, дотоодын бүтээгдэхүүн хоорондын өрсөлдөөн бага, аж ахуйн нэгжүүд техник тоног төхөөрөмжийн хүчин чадал сул, стандарт мөрдөлт сул, хэрэглэгчийн хэрэгцээнд тааруулж өөрчлөлт хийх уян хатан чадвар бага, өөрсдийн тогтсон борлуулалтын суваггүй, бөөний борлуулагч нарт нийлүүлдэг, үйлдвэрлэлийн тоо хэмжээ бага, өртгийг давуу тал үүсээгүй, өргөжилтийн хэмнэлт хийх боломж бүрдээгүй зэргээс харвал өрсөлдөх чадварын түвшин анхан шатанд байна. БЖДҮ-ийн өнөөгийн өрсөлдөх чадвар нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлээ

тэлэх, цаашлаад ногоон эдийн засгийн туршлагауудыг нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал байна.

НӨС-ний бүхий л үе шатуудад саад бэрхшээлүүд тулгарч байна. Үүнд:

Борлуулалт маркетинг. БЖДҮ-үүд өөрсдийн брэндийг бий болгох, таниулах анхдагч оролдлогуудыг хийж борлуулалтаа нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байгаа боловч зар сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааны бүх боломжуудыг ашиглаж чадахгүй байна. Зах зээлд танигдах, хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлийг бүрдүүлэх сорилт тулгараад байна.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт. БЖДБЭ нар техник тоног төхөөрөмжийн чадавхаас улбаалан зах зээл дээрх өөрчлөлт, хэрэглэгчийн тавьж буй шаардлагуудад нийлцүүлэн өөрчлөлт хийх, хурдан хувьсан уян хатан чадвар бага байна. Монгол хэрэглэгчдийн хувьд дотоодын бүтээгдэхүүн худалдан авах сонирхол байгаа хэдий ч бүтээгдэхүүн үйлчилгээнд тавих шаардлагууд нь нэмэгдсээр байна. Иймд бизнес эрхлэгч нарт бүтээгдэхүүнээ шинэчлэх, үнэ цэнэ нэмэгдүүлэх үйлчилгээнүүдийг давхар санал болгох шаардлага үүсэж байна.

Борлуулалтын суваг. Үйлдвэрлэлийн хэмжээ бага байгаа тул бүтээгдэхүүнээ бөөний худалдааны сүлжээгээр дамжуулж борлуулдаг ба томоохон худалдан авагч нарт, хүнсний болон хоолны үйлдвэрүүдтэй хамтран ажилладаг хувь маш бага гэсэн судалгааны үр дүн гарсан.

Үйл ажиллагааны үр ашигт. Цөөн чухал түншүүдтэйгээ урт хугацааны харилцаа тогтоосон байгууллагууд маш бага байгаа ба эргэлтийн хөрөнгө, авлага, бараа материалын хадгалалт, нөөцийн удирдлага, борлуулалтыг дэмжих зэрэг асуудлууд голлон нөлөөлдөг байна. Бизнес эрхлэгчид зөвхөн борлуулалтаа нэмэгдүүлэхэд анхаарахаас гадна өртгөө бууруулахын тулд түүхий эд материалын татан авалт, бараа материалын нөөцөө удирдах, хянах чадавхаа нэмэгдүүлэх боломж байгаа гэж харж байна. Цаашид бүтээгдэхүүн нийлүүлэлтийн сүлжээний тогтолцоог ойлгох, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг илрүүлэх нарийвчилсан судалгааг цаашид хийх хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Хаягдал, хорогдол. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ нь хурдан мууддаг, улирлын чанартай бүтээгдэхүүн бөгөөд хадгалалтын хугацаа богино, бага температурт хадгалах шаардлагатай, температурын хяналт шаарддаг онцлогтой. Тиймээс эдгээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний логистик нь тариалалтаас эхлээд ургац хураах, боловсруулах, савлах, лаазлах, тээвэрлэх, түгээх хүртэлх нэмүү өртгийн бүх үйл явцад хамаардаг. Олон улсын судалгааны байгууллагуудаас хүнсний бүтээгдэхүүний хаягдлын хувийг тооцоолж гаргасан байдаг.¹³

Хүснэгт 26. Хүнсний хаягдлын хувь бодох коэффициент

¹³ C.Caldeira, V.De Laurentiis, S.Corrado. 2019. Quantification of food waste per product group along the food supply chain in the European Union: a mass flow analysis

| Бүтээгдэхүүн | Тээвэрлэлт, түгээлтийн хаягдал | Өрхийн хаягдал | Хоолны үйлдвэрлэлийн хаягдал |
|----------------------|--------------------------------------|-------------------|------------------------------------|
| Будаа | 0.3% | 6.0% | 18.0% |
| Гурил | 0.5% | 6.0% | 6.0% |
| Талх | 4.8% | 29.0% | 20.0% |
| Гурилан бүтээгдэхүүн | 4.8% | 15.0% | 20.0% |
| Ногоо | 0.2% | 12.0% | 9.3% |
| Төмс | 0.0% | 30.3% | 30.6% |

Эх сурвалж: Caldeira et al 2019.

Тээвэрлэлт. Судалгааны үр дүнгээс харахад хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалангийн бүс нутгуудад ургац хураах, цуглуулах нэгдсэн үйл явц байдаггүйтэй холбоотой. Тариалан эрхэлдэг өрхүүд хүнсний ногоо, жимс жимсгэнээ тус тусдаа, ялгаатай арга барилаар тарьж, хурааж, бөөний болон жижиглэнгийн захуудад борлуулдаг тул тээвэрлэхээс өмнөх савлагаа, боловсруулалт жигд ижил хийгддэггүй. Энэ нь бүтээгдэхүүнийг ачиж буулгах, дахин савлах үед нийлүүлэлтийн сүлжээний өөр өөр цэгүүдэд тээвэрлэлтийн процессыг тасалдуулж, цаг хугацаа, зардал их зарцуулж, тээврийн хэрэгслийг өөрчлөх үед зохих температурт хадгалаагүйгээс бүтээгдэхүүн мууддаг байна.

ХАА салбарт төрөөс баримталж буй бодлого, хэрэглэгчдийн байгаль орчинд ээлтэй худалдан авах хандлага, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавьж буй шаардлага зэрэг нь нэмэгдэж байгаа тул ХААХУУҮС-ын БЖДҮ эрхлэгчдэд өргөжин тэлэх боломжууд бий болж байгаа төдийгүй бүтээгдэхүүн үйлчилгээгээ эко болгох сорилт тулгарч байна. Үүний тулд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх анхны алхмуудыг хэрэгжүүлэх бодит хэрэгцээ үүсэж байна.

Дотоодын үйлдвэрлэгч нарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд нэмүү өртгийн сүлжээнд чиглэсэн дараах үйл ажиллагаанууд чухал байна.¹⁴


- Бүтээгдэхүүн үйлчилгээ: Зах зээлийн суурь судалгаа, бүтээгдэхүүний багц бүрдүүлэлт, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх;
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт: Технологийн шинэчлэлт, бүтээгдэхүүний дизайн загвар;
- Нийлүүлэлтийн сүлжээ: ТЭМ-н найдвартай бэлтгэн нийлүүлэгч, бараа материалын нөөц, татан авалт ба түгээлт;
- Үйлдвэрлэл: Бараа бүтээгдэхүүний чанарын хяналт, сав баглаа боодол;
- Хуваарилалт түгээлт: бүс нутгийн түгээлтийн сүлжээ, худалдан авалтын нөхцөл, төлбөрийн нөхцөл;
- Борлуулалт ба нэмэлт үйлчилгээ: бүтээгдэхүүн, сав баглаа боодлыг хэрэглэгчид таниулах, найдвартай тогтмол хэрэглэгч.

¹⁴ J.Kim. 2007. Value Chain Bottleneck in China: Emerging Challenges and Managerial Framework

5.3. Газар зүйн байршил

Газар зүйн байршилыг үнэлгээний өгөгдөл цуглуулахад Google My Maps ашиглан БЖДБЭ-ийн газар зүйн байршил болон холбоо барих мэдээллийг тэмдэглэсэн. Түүнээс гадна судалгааны өгөгдлийн найдвартай байдлыг баталгаажуулах хэмжүүр болсон. Дижитал газрын зургийг газар зүйн бүс (Улаанбаатар хот, Сэлэнгэ аймаг, Орхон аймаг), дэд салбаруудаар ангилан харах боломжтой.


Зураг 15. БЖДУ-ийн газар зүйн байршил



Эх үүсвэр: Google map

Дижитал газрын зургаас оролцогчдын газар зүйн байршил, хувийн мэдээллийг хялбархан ялган харах боломжтой.

Зураг 16. Оролцогчдын холбоо барих мэдээлэл



Мөн оролцогчдын нэр, холбоо барих мэдээлэл, тайлбаруудыг хүснэгтээр нэгтгэн харах боломжтой.

Зураг 17. Оролцогчдын холбоо барих мэдээллийн хүснэгт

| name | description |
|---|---|
| Алтанцэцэг 94806178 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Шаамар, 1р баг 5н толгой |
| Бүтээл сан/эрдэнэжаргал/ 99741616 Жижиг - Small | Зөгийн аж ахуй |
| Эрдэнээул 95357505 Бичил - Micro | Тээвэрлэгч Орхон аймаг Баян-Өндөр сум Эрдэнэ баг 23 Б-2 Горьдлого зах |
| Энхмандах 99172280 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Баян-Өндөр сум Окуут баг 2-р микр 7р байр |
| Цэрэнханд 95767438 Жижиг - Small | Зөгийн аж ахуй |
| Наранбаатар 95348690 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Баян-Өндөр сум Урт булаг баг 5-1-27 |
| Цэцэгмаа 95341054 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Эрдэнэт хот Бугат нутаг КООРДИНАТ БАРИМЖААЛСАН |
| enhtaivan 99176972 Бичил - Micro | Зөгийн аж ахуй боини толгой |
| Мөнхжаргал 95343431 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Баян-Өндөр сум Бүрэнбулаг баг 11-р хороолол В-80 |
| Гэндэнпил 95341081 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Баян-Өндөр сум 3-р микр 23-р байр |
| Батсүх 99351633 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг 11-р хороолол Малчин баг |
| Delgetmaa 99499701 Бичил - Micro | Зөгийн аж ахуй |
| Далгэрэх хур-Наргүй 99806159 Жижиг - Small | Зөгийн аж ахуй |
| С. Ариунаа Орхон аймаг Зөгий Нийгэмлэг 94352377 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Баян-Өндөр сум Уурхайчин 3-р микр 22-14 |
| Наранцэцэг 99359661 Бичил - Micro | Зөгийн аж ахуй Орхон аймаг Баян-Өндөр сум Уртбулаг баг |

6. ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Энэ хэсэгт гадаад улс орнуудын тойрог эдийн засгийн судлагдсан байдлын тойм мэдээллийг харж болох бөгөөд олон улсын бичил, жижиг, дунд бизнесийн байгууллагуудын тойрог эдийн засгийн туршлагыг хэрэгжүүлж буй стратеги болон арга хэрэгслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл багтаасан.

6.1. Тойрог эдийн засгийн хэрэгжүүлэлт ба түүний сайн туршлагууд

Тогтвортой хөгжлийн ирээдүй нь хог хаягдлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулахын зэрэгцээ бүтээгдэхүүн, түүхийн эд материалыг дахин боловсруулж, дахин ашиглах замаар 3R зарчимд суурилсан "авах-хийх-хэрэглэх-дахин боловсруулах" гэсэн шугаман логигоос тойрог системд шилжсэн (EMF, 2013).¹⁵ Тойрог эдийн засгийн талаар бодлого боловсруулагчид, төрийн бус байгууллага, эрдэмтэд анхаарлаа улам бүр нэмэгдүүлж байгаа нь хөдөө аж ахуйн компаниудын тогтвортой хөгжлийн бодлогоо компаниуд стратегидаа тусгахад сайн түлхэц болж байна (Sica, Malandrino, & Supino, 2018).¹⁶

Онолын хувьд тойрог эдийн засгийн хүрээнд ихээр судлагдсан судалгааны ажлуудаас онцолж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт хэрэглэгдэж буй чиг хандлага, шилдэг туршлагыг ойлгох нь чухал юм. Европын орнууд дундаас Итали улс олон тооны судалгааны ажил хийж, энэ чиглэлд багагүй хувь нэмрээ оруулсан. Энэ нь Итали улс тойрог эдийн засгийн талаар стратегийн байр суурь, дүрэм журам, зохицуулалтын хувьд анхаарлаа улам бүр нэмэгдүүлж байгаатай холбоотой юм. Азийн орнууд, тэр дундаа Хятад улс анхдагч бөгөөд тогтвортой хөгжлийн шинэ загвар боловсруулан ажиллаж байна (Geng & Doberstein, 2008). Хятад улс дүрэм журам, зохицуулалтын талаас тойрог эдийн засгийн асуудалд онцгой анхаарал хандуулж ирсэн (Yuan, Bi, & Moriguchi, 2006). Хойд Америк, Өмнөд Америк, Африк ба далайн орнууд бусад бүс нутгууд цөөн тооны судалгааны ажил хийж гүйцэтгэсэн байна.

Практик туршлагын хувьд Герман, Итали, Швед болон Европын бусад орнууд, Хятад, Япон, Солонгос, Индонез, Вьетнам, Казахстан, Турк зэрэг улсууд тойрог эдийн засгийн туршлагаараа тэргүүлэгч орнууд бөгөөд 3R зарчмыг бий болгох шилдэг туршлага, хууль тогтоомжийг амжилттай хэрэгжүүлсэн байдаг.

Герман улс 1996 оноос эхлэн тойрог эдийн засгийн стандартыг хэрэгжүүлж эхэлснээр энэ талаар тэргүүлэгч улс болсон. Швед улс урт хугацааны туршид төрөл бүрийн урамшууллын хөтөлбөрүүдийг нэвтрүүлсэн. Тэд олон нийтийн боловсролоор дамжуулан дахин боловсруулалтын тухай мэдлэгийг аажмаар үр дүнтэй нэмэгдүүлэх нөхцөлийг

¹⁵ EMF, E. M. (2013). *Ellen MaTowards the circular economy. Economic and business rationale for an accelerated transition*. Cowes, UK: Ellen MacArthur Foundation

¹⁶ Sica, D., Malandrino, O., & Supino, S. (2018). The Corporate Social Responsibility in the Italian Agro-food Sector. *Sustainability*. 2018, 358-364.

бүрдүүлэхийг хичээсэн. Швед, Герман болон Европын бусад хэд хэдэн улс орнууд улс төрийн тогтолцоондоо ногоон улс төрийн намуудыг нэгтгэж чадсан туршлагатай.

Харин Японы засгийн газар дахин боловсруулалтад суурилсан нийгэм рүү шилжих хууль эрх зүйн иж бүрэн тогтолцоог боловсруулсан байна.

Хятад бол тойрог эдийн засгийн үзэл баримтлалыг хөгжүүлж, түүнийгээ өргөн цар хүрээтэй хөгжлийн стратеги болгон хэрэгжүүлсэн цорын ганц орон юм. Тойрог эдийн засгийн бодлогыг микро, месо, макро гэсэн гурван түвшинд нэгдмэл байдлаар хэрэгжүүлсэн нь амжилтын гол түлхүүр байсан. Анхан шатны түвшинд, аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрлэгчдийг илүү эко үйлдвэрлэл, дизайн бий болгохыг шаарддаг мөн дэмждэг байна. Месо буюу дунд түвшинд тойрог эдийн засгийн хүрээнд эко аж үйлдвэрийн парк, эко хөдөө аж ахуйн системийг хөгжүүлэх зэрэг орно. Эцэст нь, макро түвшний тойрог эдийн засгийн практик нь цогц, өргөн хүрээтэй хамтын ажиллагааны сүлжээ, идэвхтэй хамтын ажиллагааг бий болгохыг шаарддаг. Өөр нэг амжилттай хэрэгжүүлэх стратеги нь БНХАУ-д туршилтын хот /PILOT CITY/ хөгжүүлэх явдал байв. Тойрог эдийн засгийн стратегийн нэг хэсэг бол Далиан хотын захиргаа эрчим хүчний хэрэглээ өндөртэй жижиг байгууламжуудыг хааж, оронд нь эрчим хүч хэмнэх технологиор үйлдвэрлэлийн цар хүрээ сайтай үйлдвэрлэлийг дэмжих шийдвэр гаргасан. Далиан, Бээжин, Шанхай, Тяньжин хотууд тойрог эдийн засгийн туршлагад үнэлгээний шалгуур үзүүлэлт ашигласан. Гэсэн хэдий ч хотуудын гүйцэтгэлийн үзүүлэлт хоорондоо ялгаатай бөгөөд шилдэг туршлагын технологи, бодлогын өөрчлөлтийн талаарх байр суурь нь өөр өөр байдаг.

Шведийн үндэсний түвшний тогтвортой хөгжлийн стратеги нь урт хугацаанд алсын хараагаа тодорхойлж, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлын гурван хэмжигдэхүүнийг бүгдийг нь багтаахаар төлөвлөсөн юм. Шведийн засгийн газар найман үндсэн чиглэлийг чухалчилсан. Үүнд: ирээдүйн хүрээлэн буй орчин; уур амьсгалын өөрчлөлтийн хязгаарлалт; хүн амын эрүүл мэнд; нийгмийн сайн сайхан байдал; хөдөлмөр эрхлэлт ба боловсрол; эдийн засгийн өсөлт ба өрсөлдөх чадвар; бүс нутгийн хөгжил ба нэгдэл; олон нийтийн хөгжил багтсан (GO-ME, 2002).¹⁷

Тойрог эдийн засгийн хэрэгжилт, цаашдын хөгжлийн талаар амжилттай хэрэгжүүлсэн цөөн хэдэн жишээнүүдийн тоонд Герман, Япон орно. Хоёр улсын амжилт нь олон нийтийн ухамсар, тэдний оролцоог идэвхжүүлсэнтэй холбоотой. Олон жилийн хүчин чармайлтын үр дүнд Японд хүнсний хаягдлыг багасгах нь жишиг болжээ. Япон улс хог хаягдлын менежментийг оновчтой болгож, нөөцийг үр дүнтэй ашиглах замаар хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ дахин боловсруулах чиглэлээр ихээхэн амжилтад хүрсэн (Shokuhin, 2020).¹⁸ Жишээ нь: “Үлдэгдэлгүй аян”-д 420 гаруй хотын захиргаа идэвхтэй оролцсон. Ийнхүү үндэсний хэмжээнд хүнсний хаягдлыг бууруулахын тулд төр, засгийн

¹⁷ GO-ME. (2002). *Sweden's National Strategy for Sustainable Development*.

¹⁸ Shokuhin, M. (2020). *The current status of food loss in Japan*. Retrieved from <https://bit.ly/36ci4QU>

хамтын ажиллагаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэгтгэсэн. Бизнесийн салбар дахь хүнсний хаягдлыг бууруулахын тулд хотын захиргаа ресторан, зочид буудлуудыг “Үлдэгдэлгүй байгууллага” болгон бүртгүүлэхийг уриалсан. Ресторан, зочид буудлуудад бага порцтой цэс зохиож, үйлчлүүлэгчид хоолны үлдэгдлээ авч явах хүсэлтийг дэмжин ажилласан ба хэрэглэгчид бага хэмжээний хоол хүнс худалдан авч, шинэ хүнсийг зөв хадгалах зөвлөмжийг сурах боломжтой болсон. 2020 оны байдлаар 155 хүнсний жижиглэн худалдаа эрхлэгчид хамтран ажиллахаар бүртгүүлсэн байна (Kimura, 2008).¹⁹ Энгийн үг хэллэгтэй бичвэр, гэрэл зураг бүхий ойлгомжтой мэдээлэл агуулсан “Инээмсэглээрэй! Хирошима” болон “Хог хаягдлыг бууруулах өдөр” аяны үйл ажиллагаа нь олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчлахад хамгийн их нөлөө үзүүлсэн байна.

Солонгос улсад Сөүл хотын захиргаа хэд хэдэн санаачилга, төслийг хэрэгжүүлсээр ирсэн. Сөүл хотын 2030 он хүртэлх хөдөө аж ахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 2012 онд анхны Хот орчмын хөдөө аж ахуйн мастер төлөвлөгөөг танилцуулж, 2019 онд тариаланчид болон дадлагажигчдад техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Хотын фермерүүдийн портал вэбсайтыг нээсэн. Энэ вэб сайт нь хотын тариаланчдын тухай амжилтын түүх, хот орчмын хөдөө аж ахуйд хэрхэн бэлтгэж байгааг харуулдаг. Сөүл хотын хөдөө аж ахуйн технологийн төв нь хотын тариалангийн хөгжилд техникийн тусламж болон мэдлэг олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус төв нь ургамлын төрөл зүйлийн талаарх мэдлэг, ургахад хамгийн тохиромжтой орчин, ургамлын өвчний эмчилгээний талаар хэрэгтэй зөвлөгөө өгдөг. Тус төв нь “мэргэжилтнүүдийн нийгэмлэг”-ийг байгуулж, хөдөө аж ахуй сонирхдог иргэдэд сургалт явуулж, лекц уншдаг. Сургалт дууссаны дараа оролцогчдод сертификат олгож, дадлагажигчдыг мэргэжилтэн болж, хотын хөдөө аж ахуйг хөгжүүлэх төвд үргэлжлүүлэн хувь нэмэр оруулахыг хүлээн зөвшөөрдөг (Government, 2019).²⁰

6.2. Тойрог эдийн засгийн практик туршлагауд ба сайн жишээнүүд

Хөдөө аж ахуйн хүнсний салбар нь дэлхийн ХХЯ-ын бараг дөрөвний нэгийг бий болгодог (McArthur, 2019).²¹ Одоогийн байдлаар хүнсний хог хаягдлын 56% нь өндөр хөгжилтэй орнуудад гарч байна (Koehring, 2019).²² Хүнсний үйлдвэрлэлээс бий болсон хог хаягдлыг бууруулах асар их боломж бий. Хүнсний компаниуд хүнсний хог хаягдлыг багасгах тойрог эргэлтийн шийдлийг судалж, хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн ба хүнсний үйлдвэрлэлийн явцад бий болох хог хаягдал болон бүтээгдэхүүн нөөцийн аль алиныг нь багасгахад ашиглаж болох олон туршлага, арга хэрэгслийг ашиглаж байна.

¹⁹ Kimura, A. H. (2008). The chisan-chisho movement: Japanese local food movement and its challenges. *Agriculture and Human Values*, 49-64.

²⁰ Government, S. M. (2019). Rainwater and food waste use. *Korea Journal of Population and Development*.

²¹ McArthur, E. f. (2019). *Cities and Circular Economy for Food*. Retrieved from <https://web.archive.org/web/20201207132248/https://www.ellenmacarthurfoundation.org/publications/cities-and-circular-economy-for-food>

²² Koehring, M. (2019). *How fixing broken food systems can help us meet all the SDGs*. Retrieved from World Economic Forum: <https://web.archive.org/web/20201209132611/https://www.weforum.org/agenda/2019/07/food-waste-loss-malnutrition-sustainable-development-goals/>

Агри-хүнсний салбар дахь тойрог эдийн засгийн шилдэг туршлагыг олон улсын хэмжээнд судалж үзэхэд тойрог эдийн засгийн зорилго, стратегийг дэмжих өргөн хүрээний туршлагыг аль хэдийн хэрэгжүүлж эхэлснийг харуулж байна. Иймд стратеги, практикийг хэрэгжүүлэх нь хүнсний алдагдал, хог хаягдлын өнөөгийн түвшинг бууруулахын зэрэгцээ хүнсний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах гол түлхүүр болно.

Япон: Хирошима хотод хэрэгжүүлж буй “хоол хүнсний дэмжлэг” хөтөлбөр. Хирошима хотын захиргаа нь спортын үйл ажиллагаа болон их дээд сургуулиудтай хамтран “хоол хүнсний дэмжлэг” арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Хотын захиргаа тусгай талбай засаж, идэж болох бүх хоол хүнсээ хандивлахыг иргэдэд уриалдаг. Лаазалсан хоол, чихэр, жигнэмэг, гоймон зэрэг нь хамгийн түгээмэл байдаг. Нэг өдрийн арга хэмжээний дараа Хирошима хотын захиргаа цуглуулсан хоолоо орон нутгийн хүнсний банк болох байгууллага Aiai Net-д гардуулдаг. 2008 онд үүсгэн байгуулагдсан Aiai Net нь Хирошима мужид эмзэг бүлгийнхэн, тэр дундаа өрх толгойлсон болон орон гэргүй хүмүүст хүнсний дэмжлэг үзүүлдэг гол байгууллагын нэг юм.

Япон: Саппоро хотын “хоол хүнсийг аврах” хөтөлбөр. Энэ нь айл өрх, иргэдэд хүнсний хаягдлаа бууруулахыг уриалж хоол хүнсээ аврах үйл ажиллагаа юм. Тус сургалтад хуучин хүнсний ногоо, гамшгийн үед зориулан бэлтгэсэн лаазалсан хоол, гадаадад үйлдвэрлэсэн лаазалсан хүнсний бүтээгдэхүүн гээд идэх боломжтой ч гэсэн хаях гэж байсан хоолоо айл өрхүүд авчирдаг.

Солонгос: Жугон цогцолбор. Барилгын бүтцэд сөрөг нөлөө үзүүлэхгүй хэрэглээг дэмжиж, оршин суугчид байшингийнхаа хажуугийн ашиглагдаагүй газрыг (ойролцоогоор 330 м.кв) тариалангийн ферм болгохоор тохиролцож, дээврийн борооны ус цуглуулах зориулалттай шугам хоолой байрлуулсан байдаг. Борооны ус хоолойгоор дамжин шинээр баригдсан 20 тонны багтаамжтай газар доорх саванд хуримтлагддаг.

Солонгос: Сангдо метроны буудал. Сөүл хотод метроны буудлуудын талбайг жижиг дунд бизнес эрхлэгчдэд түрээслүүлдэг. Сангдо метроны буудал дахь төр, хувийн хэвшлийн ухаалаг ферм нь хотын төвийн эдгээр орон зайд хотын хөдөө аж ахуйг нэвтрүүлэх туршилтын арга юм. Ферм нь зорчигчдод гэртээ харих замдаа хүнсний ногоонууд худалдан авах боломжийг санал болгож байна. Ингэснээр хөдөө орон нутгаас хот руу хүнсний ногоо зөөвөрлөхөд зарцуулах эрчим хүчийг хэмнэх юм. Тус ферм нь метроны буудлын бий болгож байгаа CO₂-ыг шингээж, хүчилтөрөгч ялгаруулдаг.

Агрипротеин: Хүнсний хог хаягдлыг арилгахын тулд шавжийн тариаланг ашиглах. Agriprotein бол хүнсний хог хаягдлыг арилгахын тулд шавжийн тариалан эрхэлдэг Өмнөд Африкийн компани юм. Хар цэрэг ялаа арав хоногийн дотор жингээ 200 дахин нэмэгдүүлэх чадвартай. Ялааны авгалдайг хамгийн дээд хэмжээндээ хүрсний дараа тэдгээрийг хатааж, тээрэмдэж өөх тосыг нь салгаж, MagMeal хэмээх амьтны органик тэжээл болгон хувиргадаг. Дараа нь тэдний өөх тосыг амьтны эрүүл мэндэд зориулж нэмэлт тэжээл болгон эсвэл био

түлш болгон хувиргадаг. Үлдсэн органик материалыг шим тэжээлээр баялаг бордоо болгон хувиргаж, орон нутгийн фермүүдэд зардаг.²³

Loblaw: жижиглэнгийн худалдааны хүнсний хог хаягдлыг бууруулах. Канадын хүнсний жижиглэнгийн худалдааны компани Лоблав 2025 оноос өмнө дэлгүүрээс бий болох хүнсний хог хаягдлаа 50 хувиар бууруулах эсвэл өөр тийш нь шилжүүлэхээр амлан ажиллаж байна. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон төрлийн аргыг боловсруулсан²⁴. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүнийг оновчтой хэмжээгээр захиалж, худалдан аваагүй барааг багасгахын тулд бараа материалын удирдлагын системд хөрөнгө оруулах;
- Хүнсний банкны сүлжээгээ өргөжүүлэх;
- Хуучирсан эсвэл хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүнийг үр тарианы гаралтай малын тэжээлд ашиглахад чиглүүлэх;
- Хэрэглэсэн тосыг биодизель түлш болгон хувиргах.

Дээрх жишээнүүдээс харахад агри-хүнсний салбарын тойрог эдийн засгийн зорилтуудын гол чиглэл бол НӨӨЦИЙГ БУУРУУЛАХ хэрэглээ болсон. Үүнийг хийх нэг арга бол эко дизайны элементүүдийг компанийн бүрэн стратегид нэгтгэх явдал юм. Тухайлбал: “Арла сүүн үйлдвэр” /Дэлхийн уур амьсгалд өөрчлөлтийн эсрэг хамгийн хэмнэлттэй Дани-Шведийн сүүний ферм/ тариаланчид эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх замаар нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулж, тогтвортой байдлыг сайжруулах фермийн загвараар ажиллаж эхэлжээ. Нөөцийн хэрэглээг багасгах нэг арга бол үйл явцыг оновчтой болгож үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх явдал юм. Үйл явцын ОНОВЧЛОЛ нь нийлүүлэлтийн сүлжээг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн богиносгож, улмаар хүсээгүй хоол хүнсийг бага хэмжээгээр бий болгож, тээврийн хэрэглээг багасгахад оршино. Жишээлбэл: Финландын Ultima ресторан нь хог хаягдлыг савлах, тээврийн хэрэглээг арилгахын тулд ресторанахаа байранд хэрэгцээт орц найрлагыг нь ургуулдаг.

Үүнд хүрэх үр дүнтэй стратегийн нэг бол хамтын хэрэглээнд суурилсан эдийн засгийг бий болгох явдал юм. Жишээлбэл: Оттава дахь Олон нийтийн хөргөгч, хоол хүнс хуваалцах төслүүд нь айл өрх, бизнес эрхлэгчдэд илүүдэл хоол хүнсээ үрэхийн оронд бусадтай хуваалцах боломжийг олгодог.

Хүнсний бүтээгдэхүүн хурдан мууддаг тул тэдгээрийн ашиглалтын хугацааг уртасгах боломж хязгаарлагдмал байдаг. Гэсэн хэдий ч илүүдэл хүнсийг хандивлаж, дахин зарах замаар хогийн цэгээс хоол хүнсээ өөр тийш нь чиглүүлж болно. Жишээлбэл: Канадын хүнсний сүлжээ Метро нь хүнсний нөхөн сэргээх хөтөлбөрөөр дамжуулан 2018 онд олон нийтийн байгууллагуудад 6 сая хоол хандивлаж, илүүдэл хоол хүнсийг нөхөн сэргээх туршлагыг хэрэгжүүлж байна.

²³ [Case studies \(archive.org\)](#)

²⁴ [Wayback Machine \(archive.org\)](#)

HelloFresh бол долоо хоног бүр шинэхэн, урьдчилан бэлтгэсэн орц найрлага, жорыг хэрэглэгчдэд хүргэдэг захиалгат хоолны үйлчилгээний нэг жишээ юм. Хөдөө аж ахуйн хүнсний салбар нь ДАХИН БОЛОВСРУУЛАХ, бордоо боловсруулах зорилгоор нөөцөд шинэ тойрог амьдрал өгөх практикт удаан хугацааны турш тэргүүлэгч байсаар ирсэн.

Хүнсний хаягдал, илүүдлийг дахин өөр зориулалтаар ашиглах нь их үр дүнтэй аргын нэг юм. Үүнийг жүржийн хальсаар даавуу хийх, эсвэл хүний хэрэглээнд тохиромжгүй хоолыг малын тэжээл болгон хувиргах гэх мэт хэд хэдэн аргаар хийж болно. Maple Leaf Foods компани 2017 онд 5,486 метр тонн савласан махны хаягдлыг био задлах төхөөрөмж рүү шилжүүлж, 2,1 сая кВт.цаг ногоон эрчим хүч үйлдвэрлэж, Онтариогийн цахилгаан сүлжээнд нийлүүлж, 1,473 тонн CO₂ ялгарахаас сэргийлсэн. Францын McDonalds компани зоогийн газраасаа хэрэглэсэн тосыг цуглуулж, био түлш үйлдвэрлэхийн тулд дахин боловсруулах үйлдвэр рүү зөөдөг байна.

Хүснэгт 27. Тойрог эдийн засгийн стратеги, зорилго, практикууд

| Зорилго | Стратеги | Практикууд | |
|---|--|--|---|
| 1. Нөөцийн хэрэглээг бууруулах /REDUCE/ | 1.1 Эко дизайн | Экологийн тэнцвэрт байдал | Хүнсний хаягдалгүй хүргэлтийн үйлчилгээ |
| | 1.2 Үйл явцын оновчлол | Хүнсний бүтээгдэхүүний хаягдалгүй дэлгүүрүүд | Эрчим хүчний хэмнэлт |
| | | Богино циклтэй нийлүүлэлтийн сүлжээ | Хүнсний хаягдлын дижитал бүртгэл |
| 1.3 Хариуцлагатай хэрэглээ ба худалдан авалт | Хариуцлагатай хэрэглээ ба худалдан авалт | Хэрэглэгчдийн ойлголтыг нэмэгдүүлэх | Удахгүй хугацаа дуусах бүтээгдэхүүний хямдрал |
| | | Ухаалаг хоол хүнсний худалдан авалт | Тогтвортой хөгжилд суурилсан худалдан авалт |
| 2. Бүтээгдэхүүний дахин хэрэглээг эрчимжүүлэх /REUSE/ | 2.1 Хамтын хэрэглээний эдийн засаг | Хамтын супермаркетууд | Хоол хүнс хуваалцах |
| 3. Бүтээгдэхүүн ба эд ангийн амьдралын мөчлөгийг сунгах | 3.2 Хандивлах ба дахин худалдах | Илүүдэл хоолны менежмент | Илүүдэл хоолыг өөр зориулалтаар ашиглах |
| | 3.4 Хоол хүнсний нарийвчилсан хэмжилт/порц | Хоол урьдчилан захиалах | |
| 4. Нөөцөд шинээр тойрог амьдрал бий болгох /RECYCLE/ | 4.1 Аж үйлдвэрийн эко байдал | Аж үйлдвэрийн эко-парк | |
| | 4.2 Дахин боловсруулах ба бордоо гаргах | Ногоон хогийн сав | Шим тэжээлийг дахин сэргээх |
| | | Илүүдэл хоолыг дахин ашиглах | |
| | Эрчим хүч сэргээх | Био хий ба цахилгаан | Био түлш |

6.2.1. Нөөцийн хэрэглээг бууруулах туршлага /REDUCE/

1. Эрчим хүчний хэмнэлт

Дани улсын Arla²⁵ Foods сүүний ферм нь халуун сүүний дулаанаар фермийн байшингийн шалыг халаадаг. Үнээний шинэ сүүг 37 хэмээс 4 хэм хүртэл хөргөхөд дулаан агаар үүсдэг. Дулаан агаарыг сүүний агуулах савнаас фермийн байшин руу шахдаг.

Nu Grocery²⁶ нь Оттава хотод байрладаг хүнсний дэлгүүр бөгөөд сав баглаа боодлын хог хаягдлыг арилгахыг эрмэлздэг. Үйлчлүүлэгчид дэлгүүрт дахин ашиглах боломжтой сав авчирч, худалдан авахыг хүссэн барааныхаа тоо хэмжээгээр хөнгөлөлттэй үнээр дүүргэж болно.

2. Хүнсний хаягдалгүй хүргэлтийн үйлчилгээ

Loblaw Companies Limited болон Loop²⁷ компани нь 2021 онд туршилтын хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд энэ нь сонгогдсон бүтээгдэхүүнийг дахин ашиглах боломжтой саванд хийж, шууд хэрэглэгчдийн гэрийн үүдэнд хүргэх болно.

3. Нийлүүлэлтийн сүлжээг богиносгох

Lufa Farms²⁸ нь Монреальд төвтэй хотын тариалангийн компани бөгөөд дээвэр дээрээ гурван төрлийн гидропоник хүлэмж ажиллуулдаг. Тэд бүтээгдэхүүнээ шууд дээвэр дээрээс түнш байгууллагууд болон хэрэглэгчдийн гэрт нь шууд хүргэж өгдөг.

4. Хүнсний хаягдлын дижитал бүртгэл

Winnow²⁹ нь томоохон гал тогоонуудад хүнсний хог хаягдлаа хянах боломжийг олгодог олон улсын программ хангамжийн компани юм. Энэ нь хог хаягдал хаана, яагаад гарч байгааг тодорхойлоход тусалдаг бөгөөд ингэснээр үүнийг багасгахын тулд шийдвэр гаргах боломжийг олгодог байна. IKEA компани гал тогооныхоо 35хувьд Winnow-ийг суулгаж, хэдхэн сарын дотор ойролцоогоор 1 сая хоол хэмнэсэн байна.

5. Чанарын хяналт

The Calgary Italian Bakery³⁰ Баруун Канадын хамгийн том бие даасан нарийн боовны үйлдвэрлэгч юм. Тэд талхны үйлдвэрлэлийн шугамын гурил зуурах хэсэг болон англи маффины чанарыг сайжруулахаар ажиллаж байна (Англи маффины хаягдлын 50 орчим хувь

²⁵ [Hans Clausen | Arla \(archive.org\)](#)

²⁶ [our story - NU Grocery \(archive.org\)](#)

²⁷ [Loop And Loblaw To Bring Circular Shopping Platform To Canada \(newswire.ca\)](#)

²⁸ [How it works \(archive.org\)](#)

²⁹ [Winnow | Cutting Food Waste Within Hospitality \(archive.org\)](#)

³⁰ [Wayback Machine \(archive.org\)](#)

нь гологдолтой эсвэл буруу хэлбэртэй байдаг). Бүрэн хэрэгжүүлбэл тэд жилдээ 50 мянган кг талхны зуурмаг хэмнэх болно.

6. Хэрэглэгчийн ойлголтыг нэмэгдүүлэх

The 'Re-Imagine Food' Campaign³¹ нь Гуэлф хотын оршин суугчдад хүнсний хог хаягдлын бодит зардлын талаар мэдлэг олгох, тойрог эдийн засгийн үйлдвэрлэлийн эрэлтийг нэмэгдүүлэх зэргээр хүнсний үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдийн хооронд илүү ойрхон харилцаа тогтоохыг зорин ажилладаг.

Metro Vancouver³² WRAP UK-тэй хамтран "Хоолыг хайрлаж, хаягдлыг үзэн ядах" кампанит ажлыг Канад дахь анхны салбарт эхлүүлсэн. Энэхүү аян нь хүмүүст гэр ахуйн хүнсний хог хаягдлыг багасгах, хүнсний ашиглалтын хугацааг уртасгах хадгалах зөвлөмж өгөх, орц бүрээс хэр хэмжээгээр худалдаж авахыг тодорхойлоход туслах, улирлын чанартай цэсээр хангах зорилготой юм.

7. Удахгүй хугацаа дуусах бүтээгдэхүүний хямдрал

Walmart³³ нь шинэ мах, талх нарийн боов, сүүн бүтээгдэхүүнийг хурдан борлуулах, дуусах хугацаанаас нь өмнө бүтээгдэхүүн худалдан авах боломжийг олгохын тулд “хэрэглэгчийн үнэ цэн”-ийн хөтөлбөрөөр дамжуулан үнийг бууруулж байгаа бөгөөд 2025 он гэхэд хүнсний хаягдалгүй болох зорилт тавин ажиллаж байна

Loblaws partners with Flashfood³⁴ нь хэрэглэгчдэд хугацаа нь дуусах дөхөж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг Loblaws хүнсний дэлгүүрүүдээс 50% хүртэл хямдралтай үнээр худалдан авах боломжийг олгодог программ юм.

We-Food³⁵ нь Дани дахь буяны байгууллага бөгөөд хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн худалдаалдаг супермаркет юм. Сайн дурынхны ажиллуулдаг We-Food компани 2016 он гэхэд Данийн хогийн цэг рүү явах байсан 125 тонн хүнсний бүтээгдэхүүнийг хэмнэсэн байна.

8. Хоол хүнсний ухаалаг худалдан авалт

³¹ [Wayback Machine \(archive.org\)](#)

³² [Solid Waste \(archive.org\)](#)

³³ [Walmart Canada - Sustainability \(archive.org\)](#)

³⁴ [Loblaw Introduces National Program to Save Customers Money While Reducing Store-Generated Food Waste \(archive.org\)](#)

³⁵ [Danish supermarket gives expired food another shelf life - CBC.ca | Metro Morning \(archive.org\)](#)

Loblaw³⁶ нь 2018 оноос хойш Канад даяар дэлгүүрүүдээрээ крикет гурил зарж байна. Энэ нь хэрэглээнийхээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахыг хүсдэг хэрэглэгчдэд зориулсан сонголт юм.

9. Тогтвортой хөгжилд суурилсан худалдан авалт

Westbury Street Holdings³⁷ нь хөдөө аж ахуйн ханган нийлүүлэгчдээс эхлээд зоогийн газар, хүнсний дэлгүүр хүртэлх нийлүүлэлтийн гинжин хэлхээний удирдлагыг хөнгөвчлөх зорилготой Их Британид үйл ажиллагаа явуулдаг компани юм.

6.2.2. Бүтээгдэхүүний дахин хэрэглээг эрчимжүүлэх /REUSE/

1. Хамтын супермаркетууд

BEES Coop³⁸ Брюссельд хамтын ажиллагаатай супермаркет байдаг бөгөөд үйлчлүүлэгч нь хамтран ажилладаг. Хамтран ажилладаг хүн супермаркетад сард 3 цаг ажиллах үүрэг хүлээдэг бөгөөд хариуд нь супермаркетаас худалдан авалт хийх эрх үүсдэг. Тус супермаркет нь дотоодын үйлдвэрлэгчид, экологийн цэвэр бүтээгдэхүүн, улирлын чанартай бүтээгдэхүүнүүдэд давуу эрх олгодог. Тэд сав баглаа боодлын хог хаягдлыг багасгах, хоол хүнс хэмнэх зан үйлийг дэмжих зорилгоор томоор савласан хүнсний бүтээгдэхүүнийг сурталчилдаг.

2. Хоол хүнс хуваалцах

FoodSharing³⁹ нь Герман, Австри дахь илүүдэл хүнсийг хэмнэж, түгээдэг онлайн платформ юм. Энэ нь бүхэлдээ сайн дурын ажил юм бөгөөд хувь хүн, жижиглэнгийн худалдаачдын хаягдах гэж байгаа хүнсийг цуглуулдаг. Хоол хүнс нь хугацаа нь дуусахаас өмнө үнэ төлбөргүй дамжуулагдах ёстой гэсэн агуулгатай юм.

6.2.3. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг сунгах

1. Илүүдэл хоолны менежмент

Bourse aux Dons⁴⁰ Бельги улсын Брюссель хотод байдаг дижитал платформ бөгөөд DREAM төслөөр цуглуулсан шинэхэн бүтээгдэхүүнийг хотын хэмжээнд 50 гаруй буяны байгууллагуудад нийлүүлдэг. DREAM төсөл нь Брюссель хотын өглөөний захын 20

³⁶ [Loblaws launches cricket flour in sustainability effort - The Fulcrum \(archive.org\)](#)

³⁷ [Wayback Machine \(archive.org\)](#)

³⁸ [Home - Bees Coop \(archive.org\)](#)

³⁹ [foodsharing | Rette mit! \(archive.org\)](#)

⁴⁰ [Bourse aux dons \(archive.org\)](#)

мэргэжлийн худалдаачидтай хамтран өдөр бүр нэг тонн илүүдэл жимс, хүнсний ногоо цуглуулдаг.

La Tablée des Chefs⁴¹ Монреальд төвтэй хөтөлбөр нь 2012 онд залуучуудад хоолны боловсрол олгох замаар эхэлсэн боловч богино хугацаанд хоол хүнс сэргээн ашиглах хөтөлбөр болон өргөжсөн. Тэд Ванкувер, Калгари, Франц, Мексикт хөтөлбөрийг эхлүүлж, 2013 онд бараг 250,000 порц хүнсний бүтээгдэхүүнийг хаяхаас сэргийлж чадсан.

2. Илүүдэл хоолыг өөр зориулалтаар ашиглах

Toast Ale Beer⁴² бол Лондоны бүх талх нарийн боовны дэлгүүрийн илүүдэл талхыг шар айраг үйлдвэрлэхэд ашигладаг Британийн компани юм.

Loop⁴³ Финландын ресторан нь зургаан ханган нийлүүлэгч, супермаркетаас өдөрт 600 кг илүүдэл хүнсний бүтээгдэхүүн цуглуулдаг. Энэ цуглуулсан бүтээгдэхүүнийг ашиглан өндөр чанартай хоолны газрын хоол, тансаг хоол, гар аргаар зайрмаг хийдэг. Үлдсэн идэж болох хоолыг буяны байгууллагад хүргүүлж эсвэл бордоо болгодог.

Boomerang⁴⁴ бол шар айрагны үлдэгдлээс гурил үйлдвэрлэдэг Канадын компани юм. Энэхүү бүтээгдэхүүн нь хүнсний хог хаягдлыг багасгахаас гадна гурил үйлдвэрлэлийн явцад шаардагдах тээвэрлэлт, газар болон усны хэрэгцээг багасгаж, нүүрстөрөгчийг бууруулдаг.

3. Хоол урьдчилан захиалах

HelloFresh⁴⁵ олон улсын захиалгат хоолны үйлчилгээ бөгөөд долоо хоног бүр шинэхэн, урьдчилан тохируулсан орц найрлага, жороор хэрэглэгчдэд үйлчилдэг. Хоолны орцуудыг урьдчилан хэмжиж бэлтгэх замаар өрхийн хүнсний хог хаягдлыг багасгахад тусалдаг.

6.2.4. Нөөцөд шинээр тойрог амьдрал бий болгох

1. Аж үйлдвэрлэлийн эко-парк

National Economic Technological Development Area (NETD)⁴⁶ БНХАУ-ын Жэнжоу дахь Үндэсний эдийн засгийн технологийн хөгжлийн бүс нь хөдөө аж үйлдвэрийн парк юм. Энэ нь жижиг дунд оврын, хорт утаа бага ялгаруулдаг фермийн машин, хөдөө аж ахуйн машин

⁴¹ [History - La Tablée des Chefs \(archive.org\)](#)

⁴² [Bread - Toast Ale \(archive.org\)](#)

⁴³ [The role of restaurants in a circular urban food system \(archive.org\)](#)

⁴⁴ [Wayback Machine \(archive.org\)](#)

⁴⁵ [Discover a Healthy Meal Plan | Weekly Recipes | HelloFresh \(archive.org\)](#)

⁴⁶ [The design of agri-industrial ecological park: A case study of Zhengzhou national economic-technological development area | 刘晶茹 LIU Jingru \(archive.org\)](#)

механизм үйлдвэрлэдэг. Мөн хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх эрэлт хэрэгцээг хангах техникийн зааварчилгаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг.

2. Ногоон хогийн сав

The City of Guelph's Green Bin Program⁴⁷ нь жил бүр 10,000 тонн хүнсний бүтээгдэхүүн цуглуулж, 32% органик хаягдлыг хогийн цэгээс холдуулдаг байна.

3. Шим тэжээлийг дахин сэргээх

Ostara Nutrient Recovery Technology⁴⁸ нь Ванкуверт төвтэй компани бөгөөд бохирын усан дахь фосфорын 85%, азотын 15 хүртэлх хувийг сэргээж, эдгээр гаргаж авсан материалыг "Болор ногоон" хэмээх өндөр үнэ цэнтэй бордооны бүтээгдэхүүн болгон хувиргадаг.

Lystek Inc.⁴⁹ нь хотын бохир ус цэвэрлэх байгууламжаас жил бүр үүсдэг 4500 тонн био хатуу бодисыг хувиргаж, ашигтай шингэн органик бордоо болгон борлуулдаг.

4. Илүүдэл хоолыг дахин ашиглах

Oreka Solutions⁵⁰ нь Веллингтон хотод төвтэй компани бөгөөд хүнсний хог хаягдлыг цуглуулж, хар ялаануудыг тэжээдэг. Дараа нь ялааг хөрсний бичил биетийг сайжруулдаг хатуу бордоо, аквапоник тариалах уусмалд зориулсан шингэн био бордоо, загас, гахай, тахианы хоол зэрэг гурван бүтээгдэхүүн болгон хувирган ашигладаг байна.

Arla Foods⁵¹ Скандинав дахь сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компани нь хүний хэрэгцээнд 100% тохирохгүй болсон хүнсний хаягдлаа малын тэжээл болгохоор илгээдэг.

BioBean⁵² Их Британи дахь компани хаягдал кофены шаарыг дахин боловсруулж биомасс халаах шахмал түлш, үрэл болгон үйлдвэрлэсэн анхны компани юм. Энэ нь дэлхийн анхны кофе дахин боловсруулах үйлдвэр бөгөөд одоогоор кофены шаараар хийсэн биохимийн бодисыг судалж байна.

5. Био хий ба цахилгаан

Maple Leaf Foods⁵³ 2017 онд 5,486 тонн савласан махны хаягдлыг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор StormFisher био задлагч байгууллага руу шилжүүлсэн. Энэ нь 2,178,000 кВт.цаг гаруй ногоон эрчим хүч үйлдвэрлэж, Онтариогийн хэрэглээнд өгсөн.

⁴⁷ [Wayback Machine \(archive.org\)](#)

⁴⁸ [Ostara Nutrient Recovery Technologies Inc. \(archive.org\)](#)

⁴⁹ [Wayback Machine \(archive.org\)](#)

⁵⁰ [Wayback Machine \(archive.org\)](#)

⁵¹ [Sustainable Dairy Production | Arla \(archive.org\)](#)

⁵² [About bio-bean - pioneers of recycling coffee waste into clean fuel \(archive.org\)](#)

⁵³ [Sustainability – Maple Leaf Foods \(archive.org\)](#)

Ингэснээр 1473 тонн CO₂ ялгарахаас сэргийлж, 390 гаруй тонн органик бордоо үйлдвэрлэсэн байна.

The Billund Biorefinery⁵⁴ Дани улсад хөдөө аж ахуй, үйлдвэр, орон нутгийн айл өрхийн органик хог хаягдлыг боловсруулдаг. Био хий гаргаж, цахилгаан дулаан болгон хувиргадаг. Дараа нь үлдсэн шим тэжээлийг үр дүнтэй органик бордоо болгоход ашигладаг.

Sainsbury superstore⁵⁵ Их Британийн Каннок хотод байдаг бөгөөд хүнсний хог хаягдлаас үйлдвэрлэсэн эрчим хүчээр ажилладаг. Тус цахилгааны кабель нь дэлгүүрийг хамгийн ойрын байгууламжтай холбож, сэргээгдэх эрчим хүчээр шууд хангадаг.

6. Био түлш

McDonalds France⁵⁶ нь хоолны газруудаасаа хэрэглэсэн тосыг цуглуулж, био түлш бэлтгэхийн тулд боловсруулах үйлдвэрт хүргэдэг. Тос цуглуулдаг машинууд нь тухайн үйлдвэрлэсэн био түлшээрээ ажилладаг байна.

Rothsay⁵⁷ нь Веллингтон хотод төвтэй компани бөгөөд ресторан, жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэр, мал аж ахуйгаас гаргаж авсан хуучин тос, махан төрлийн бүтээгдэхүүнийг био түлш болгон хувиргадаг.

⁵⁴ [Billund BioRefinery | State of Green \(archive.org\)](#)

⁵⁵ [Wayback Machine \(archive.org\)](#)

⁵⁶ [McDonald's recycles its waste to make biofuel for its delivery trucks | Living Circular \(archive.org\)](#)

⁵⁷ [Used Cooking Oil Collection, Pickup and Recycling Services | Rothsay \(archive.org\)](#)

7. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

ХААХУУҮС-ын судалгааны үр дүнгүүдийг нэгтгэж (1) Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбар тодорхойлох (2) ТЭЗ-ийн төлөвшлийн түвшин (Maturity level) тодорхойлох (3) Шалтгаан үр дагаврыг тодорхойлох гэсэн үндсэн гурван чиглэлээр дүгнэлтээ гаргалаа.

7.1. Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбар

Өөрийн үнэлгээний асуулгаар БЖДҮ эрхлэгчдийн ТЭЗ-ийн туршлага, байгууллагын чадавх, тэр дундаа санхүүгийн чадавх, сургалтын хэрэгцээ болон эко шошгожуулалтын тухай ойлголтуудыг тодруулсан бөгөөд дэд салбар бүрээр шинжилж тэдгээрийн ялгаатай байдлыг тодруулсан. Мөн салбар тус бүрээр нэмүү өртгийн сүлжээний шинжилгээг хийсэн бөгөөд бүтээгдэхүүн үйлчилгээг бүтээх үйл явцад тулгарч буй саад бэрхшээлүүдийг тодорхойлсон. Эдгээр 7 хүчин зүйлсийн дагуу салбаруудын ялгаатай байдлыг дараах хүснэгтэд нэгтгэж харууллаа.

Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбарыг сонгохдоо дээрх 7 хүчин зүйлсийн чухалчлах байдал нь ижил гэж үзэн тэнцүү хувийн жин өгсөн. Өөрийн үнэлгээний үр дүн болон нэмүү өртгийн сүлжээний шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэн эрэмбэлэхэд хамгийн өндөр боломжтой салбар бол **хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн дэд салбар**, удаах салбарт ЖХҮ, 3 дугаарт ЗАА, эцэст нь газар тариалангийн салбар орж байна.

Хүснэгт 28. Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбар тодорхойлох шинжилгээний үр дүн

| № | Хүчин зүйл | Үйлдвэр | Жижиглэн | Зөгий аж ахуй | Тариалан |
|---|---------------------------|--|---|--|---|
| 1 | ТЭЗ туршлага | <ul style="list-style-type: none"> ТЭМ-ийн худалдан авалтад анхаарч байна Зардалд чиглэсэн бодлого барьдаг Сав баглаа боодлыг эко байлгах бодлоготой | <ul style="list-style-type: none"> Хэрэгжүүлдэггүй Капиталд суурилсан | <ul style="list-style-type: none"> Эко байх оролдлого хийдэг Бүтээгдэхүүний онцлог – эко Хамтын ажиллагаа сайн | <ul style="list-style-type: none"> Нөөцөд түлхүү анхаарлаа хандуулсан Капиталд суурилсан |
| 2 | ТЭЗ бодлого хэрэгжилт | <ul style="list-style-type: none"> Хэрэгжүүлдэг | <ul style="list-style-type: none"> Тодорхойлсон | <ul style="list-style-type: none"> Бодлого, төлөвлөлт байдаггүй | <ul style="list-style-type: none"> Тодорхойлсон, сайн дагаж мөрддөг |
| 3 | Нэмүү өртгийн сүлжээ | <ul style="list-style-type: none"> Судалгаа шинжилгээ хийдэггүй Хог хаягдал боловсруулах туршлагатай Эко баталгаажуулалт хийгдсэн Бүтэц зохион байгуулалтын хувьд дунд ба том ХХК бүрдүүлдэг | <ul style="list-style-type: none"> Эко сертификат авсан туршлагатай | <ul style="list-style-type: none"> Хог хаягдал багатай Бичил, өрхийн аж ахуй давамгайлсан ТЭЗ туршлага хэрэгжүүлдэг Эко гэрчилгээ цөөн | <ul style="list-style-type: none"> Судалгаа шинжилгээ хийдэггүй Эрчим хүчний хэмнэлт хэрэгжүүлээгүй Цөөн ажилтантай, бичил бизнес Хаягдал боловсруулах туршлагатай Байршлын тархалт, сайтай Салбарын өсөлт нэмэгдэж байна |
| 4 | Эко шошгожуулалтын мэдлэг | <ul style="list-style-type: none"> Сонсож байсан | <ul style="list-style-type: none"> Сонсож байсан | <ul style="list-style-type: none"> Огт сонсож байгаагүй олон байна | <ul style="list-style-type: none"> Огт сонсож байгаагүй олон байна |
| 5 | Байгууллагын чадавх | <ul style="list-style-type: none"> Дижитал чадавх хамгийн өндөр | <ul style="list-style-type: none"> Бүх талаараа хамгийн өндөр чадавхтай | <ul style="list-style-type: none"> Чадавх султай | <ul style="list-style-type: none"> Байгууллагын соёл, судалгаа шинжилгээ, сургалт, санхүүгийн чадавх өндөр |
| 6 | Сургалтын хэрэгцээ | <ul style="list-style-type: none"> Тогтмол сургалт хийдэг | <ul style="list-style-type: none"> Сургалт авах бэлтгэл хангагдаагүй | <ul style="list-style-type: none"> Тогтмол сургалт явуулдаггүй | <ul style="list-style-type: none"> Тогтмол сургалт явуулдаггүй |
| 7 | Санхүүгийн боломж | <ul style="list-style-type: none"> Санхүүгийн чадавх сул боловч санхүүгийн хэрэгцээг тодорхойлсон судалгаа шинжилгээ хийдэг | <ul style="list-style-type: none"> Өөрийн үнэлгээгээр санхүүгийн чадавхтай | <ul style="list-style-type: none"> Санхүүгийн чадавхын өөрийн үнэлгээгээр сайжруулах шаардлагатай | <ul style="list-style-type: none"> Санхүүгийн чадавхын өөрийн үнэлгээ хангалтгүй гарсан сайжруулах шаардлагатай |

Хүснэгт 29. Нэн тэргүүнд хөгжүүлэх боломжтой дэд салбарын үнэлгээ үр дүн, эрэмбэ

| № | Хүчин зүйл | Хувийн жин | Үйлдвэр | Жижиглэн | Зөгий аж ахуй | Тариалан |
|---|---------------------------|---------------|-----------|-----------|---------------|-----------|
| 1 | ТЭЗ туршлага | 14% | 1 | 4 | 2 | 3 |
| 2 | ТЭЗ бодлого хэрэгжилт | 14% | 1 | 3 | 4 | 2 |
| 3 | Нэмүү өртгийн сүлжээ | 14% | 1 | 2 | 3 | 4 |
| 4 | Эко шошгожуулалтын мэдлэг | 14% | 1 | 2 | 4 | 3 |
| 5 | Байгууллагын чадамж | 14% | 3 | 1 | 4 | 2 |
| 6 | Сургалтын хэрэгцээ | 14% | 2 | 3 | 1 | 4 |
| 7 | Санхүүгийн боломж | 14% | 2 | 1 | 3 | 4 |
| | Жигнэсэн дундаж үнэлгээ | 100% | 1.57 | 2.29 | 3 | 3.14 |
| | Эрэмбэ | | #1 | #2 | #3 | #4 |

7.2. Тойрог эдийн засгийн төлөвшлийн түвшин (Maturity level)

Төслийн цаашдын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, БЖДҮ эрхлэгч нарын ТЭЗ-ийн хэрэгжилтийн өнөөгийн түвшинг харуулах, цаашдын сургалтын хэрэгцээг гаргаж ирэх зорилгоор Тойрог эдийн засгийн төлөвшлийн загварыг (Circular Maturity Model) ашигласан. ТЭЗ-ийн туршлагауудыг хэрэгжүүлж үйл ажиллагаагаа битүү цагариг болгох Тойрог эдийн засгийн төлөвшлийн загвар (Circular Maturity Model) нь төлөвшлийн 6 түвшинг санал болгодог. Тэрээр түвшин болгонд байх ёстой байгууллагын шинж чанар, болон хэрэгжүүлэх үйлдлүүдийг тодорхойлсон байна.

Зураг 18. Тойрог эдийн засгийн төлөвшлийн загвар



Эх үүсвэр: Taival. Circular Maturity Model. 2020

| Түвшин | Тайлбар |
|---|--|
| 0 түвшин Идэвхгүй | Бизнесийн загварт тойрог эдийн засгийн ойлголт тусгагдаагүй, стратегийн хувьд сонирхол үгүй, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа байхгүй. ТЭЗ-ийн тухай мэдлэг, туршлагагүй. Хуулийн шаардлагуудын хэсэгчлэн хэрэгжүүлдэг. |
| I түвшин Бэлтгэл байдал | Гадаад орчны шаардлагад хариу үйлдэл үзүүлэх нэг л үйл ажиллагааг хэрэгжүүлдэг (Жишээ нь: хуулийн шаардлага эсвэл хэрэглэгчийн эрэлт). Гэхдээ бизнесийн стратеги тодорхойлоогүй эсвэл тодорхойлсон стратеги нь ТЭЗ-тай хамааралгүй, үйл ажиллагаанууд нь гадаад, дотооддоо уялдаа холбоогүй. Хуулийн хамгийн шаардлагуудыг дагаж мөрддөг. |
| II түвшин Идэвхтэй | Байгууллагын стратеги, хэрэгжилтийн төлөвлөгөөнд ТЭЗ-ийн тухай дурдагдсан. Цаашлаад, ТЭЗ-ийн зорилгууд тодорхойлогдсон, байгууллагын ажилчид ТЭЗ-ийн тухай ойлголттой. Үйл ажиллагаанууд нь зардлыг бууруулах (Ж.нь: материалын хэрэглээг багасгах) болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Байгууллага оролцогч талуудыг мэдээллээр хангах, сургахад чиглэгдсэн гадаад үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Хуулийн шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлдэг. |
| III түвшин Нутагшсан | Стратегийн зорилт болон үйл ажиллагаандаа ТЭЗ ойлголтуудыг нэвтрүүлсэн, дээд удирдлагаас идэвхтэй дэмждэг. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн загвар зэрэг нь бүгд ТЭЗ-ийн зарчимд тулгуурлан загварчлагдсан байдаг. Үзэл санаа, хүчин чармайлт нь гадаад болон дотооддоо харилцаа холбоотой. Нэмүү өртгийн сүлжээний бусад оролцогч бусад түншүүдийн хамтаар ТЭЗ-ийн үзэл баримтлалыг баримталж ажилладаг. Хуулийн шаардлагуудыг нягт хэрэгжүүлдэг, илүү хатуу удирдамжуудыг сайн дураар хэрэгжүүлдэг. |
| IV түвшин Нэгтгэсэн | Үйл ажиллагаагаа битүү цагариг болгох байгууллагын зорилгыг дэвшүүлсэн. Бизнесийн стратегид тогтвортой байдлын гүйцэтгэлийн зорилтуудыг тусгасан, үйл ажиллагааг хянах шалгуур үзүүлэлт тодорхойлсон. Байгууллага дотроо болон нэмүү өртгийн сүлжээний гадаад оролцогч талуудын хүрээнд үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулдаг. Өөрийн амжилт, зорилгын биелэлтээ оролцогч талууд, түншүүддээ байнга мэдээлдэг. Байгууллагын ТЭЗ-ийн тухай мэдлэг, чадвар өндөртэй мэргэжлийн ажилтнуудтай. Хуулийн шаардлагуудыг давуулан биелүүлдэг ба хуулийн өөрчлөлтөд хувь нэмрээ оруулдаг. |
| V түвшин Санаачилга гаргах | ТЭЗ-ийн туршлагаараа салбартаа тэргүүлдэг. Хүрээлэн буй орчин, хүмүүсийн сайн сайхны төлөө ажилладаг. ТЭЗ-ийн экосистемийг түншүүд болон оролцогч талуудтайгаа хамтран ахисан түвшинд хөгжүүлдэг. Мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчинтэй. Хуулийн шаардлагуудыг давуулан биелүүлэг ба хууль эрх зүйн бичиг баримтад оруулах өөрчлөлтүүдийг санаачилдаг, засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. |

Судалгаанд оролцсон газар тариалан, зөгийн аж ахуй, хүнс, ус ундаа үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа үйлчилгээ гэсэн 4 дэд салбарын хувьд өөрийн үнэлгээний үр дүн болон нэмүү өртгийн сүлжээний шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэх замаар салбар тус бүрийн ТЭЗ-ийн төлөвшлийн түвшинг тодорхойлсон болно. Ингэхэд ЖХҮ дэд салбар 0

түвшинд, Газар тариалангийн дэд салбар I түвшинд, ХУУҮ болон ЗАА дэд салбарууд хэсэгчлэн II түвшний шаардлагуудыг хангасан байна.

Хүснэгт 31. Тойрог төлөвшилийн түвшин, дэд салбараар

| Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ 0 түвшин /Идэвхгүй/ | Газар тариалан I түвшин /Бэлэн байдал/ |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> ✓ Тойрог эдийн засгийн стратегийн сонирхол байхгүй ✓ Тойрог эдийн засгийн туршлагагүй ✓ Тойрог эдийн засгийн мэдлэггүй ✓ Шугаман бизнесийн загвартай | <ul style="list-style-type: none"> ✓ Гадаад орчны дэмжлэгт хариу үйлдэл үзүүлдэг ✓ Тойрог эдийн засгийн 1 туршлагатай ✓ Идэвхтэй зорилгогүй |
| Хүнс, ус, ундаа үйлдвэрлэл II түвшин /Идэвхтэй/ | Зөгийн аж ахуй II түвшин /Идэвхтэй/ |
| <ul style="list-style-type: none"> ✓ Тойрог эдийн засгийн стратеги болон хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй × SMART шинжтэй зорилтууд баталсан × Тойрог эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг | <ul style="list-style-type: none"> ✓ Тойрог эдийн засгийн чадамж тодорхойлогдсон ✓ Тойрог эдийн засгийн стратеги болон хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй × SMART шинжтэй зорилтууд баталсан × Тойрог эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаг |


Эх үүсвэр: Судалгааны баг

7.3. Шалтгаан, үр дагавар

Судалгаа шинжилгээний нэгдсэн үр дүнгүүдэд тулгуурлан манай улсын ХААХУУҮС-ын БЖДҮ эрхлэгч нарын ТЭЗ-ийн зарчмуудын хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа төдийгүй 7R зарчмын зөвхөн гурав нь (Refuse, Reduce, Repair) анхан шатны түвшинд хэрэгжиж эхэлж байгаа бол бусад шалгууруудын (Rethink/Redesign, Reuse, Remanufacturing, Recycling) үзэл санаа одоог хүртэл нэвтрээгүй байна. Шалтгаан үр дагаврын загвар ашиглан бизнесийн байгууллагуудад ТЭЗ-ийн нэвтрэлт хангалтгүй байгаа шалтгааныг тодруулж зургаар илэрхийллээ.

Үндсэн асуудал нь мэдлэг, чадвар өнгөцхөн, дутагдалтай байгаа тул ТЭЗ-ийн үзэл санааг нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, эцсийн гарцыг дахин ашиглах, өөр зориулалтаар ашиглах боломжийг бүрдүүлэх нааштай хандлагууд илрэхгүй байна. Үнэлгээний үр дүнгүүдээс харахад голлох шалтгаануудад эко стандартуудын танигдалт, нэвтрүүлэлт, хэрэгжилт хангалтгүй, бизнесийн байгууллагуудын санхүүгийн нөөц дутагдалтай, байгууллагын чадавх хязгаарлагдмал, ТЭЗ-ийн тухай мэдлэг, ойлголт хязгаарлагдмал байгаа зэргийг нэрлэж болно.

Зураг 19. Шалтгаан, үр дагаврын диаграм




8. САНАЛ ЗӨВЛӨМЖ

ХААХУУҮС-ын нарийвчилсан судалгааны үр дүнд үндэслэн ХХЯ, нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулах төслийн үндсэн зорилгын хүрээнд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Хүлэмжийн хийн ялгарал бууруулах. Монгол Улсын ХХЯ нь дэлхийн нийт ХХЯ-д 0.05%⁵⁸ хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох ХХЯ нь дэлхийн дунджаас 2.7 дахин их⁵⁹ байна. ХХЯ-ын хэмжээг салбараар нь авч үзвэл ХАА салбар бусад салбаруудаас маш өндөр байгааг харж болно.

Зураг 20. Хөдөө аж ахуйн салбарын Метан болон Хүлэмжийн хийн ялгаруулалт



Эх үүсвэр: Дэлхийн банк, Дэлхийн нүүрстөрөгчийн төсөл

“Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” баримт бичигт Монгол улсын засгийн газар ХХЯ-ыг бууруулах өмнөх зорилтыг 2030 он хүртэл шинэчлэн тооцон 22.7% болгон ахиулж, хэрэв шингээлтийг нэмж тооцвол ХХЯ-ын бууралтыг 38.4% хүргэх зорилт дэвшүүлсэн байна. Үүний дагуу “Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт” бичиг баримтыг 2019 оны 11 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар 407 тоот тогтоолоороо баталсан байна.

Уг бичиг баримтад ХХЯ-ыг бууруулах боломжуудыг олон улсад баримталдаг арга зүйн дагуу эрчим хүчний болон эрчим хүчний бус салбар гэж авч үзсэн байна. Эрчим хүчний салбарт эрчим хүчний үйлдвэрлэл болон аж үйлдвэр, барилга, зам тээвэр, ХАА салбар дахь эрчим хүчний хэрэглээг авч үзсэн бол эрчим хүчний бус салбарт ХАА, аж үйлдвэрийн процесс ба бүтээгдэхүүний хэрэглээ, хог хаягдлын салбарыг хамруулан тооцсон байна.

Зөвлөмж 1: Эрчим хүчний салбар. Эрчим хүч нь ХХЯ-ын томоохон хэсгийг эзэлдэг тул хэрэглээг багасгах нь зайлшгүй юм. “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”, “Ногоон хөгжлийн бодлого” зэрэг бодлогын баримтуудад эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг тусгасан байдаг.

⁵⁸ H.Ritchie and M.Roser. 2020. Mongolia: CO2 Country Profile


⁵⁹ “Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт” бичиг баримт 2019

“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”- д дулаан, цахилгааны үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэх, “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр (2018-2023)”-ийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг нэвтрүүлэх ажлуудыг тусгасан болно.

Эрчим хүчний чиглэлээр баримтлах бодлогод дулаан, цахилгааны станцуудад түлхүү төвлөрсөн байгаа боловч ХХЯ-д бодитой хувь нэмэр оруулах эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь ХХЯ-ыг хоёр аргаар бууруулах боломжтой: Бага эрчим хүч ашиглах замаар эсвэл ХХЯ багатай эрчим хүч ашиглах.

Эхний аргын хувьд ДНБ-ийн нэгжид зарцуулсан эрчим хүчний хэмжээг хэмждэг *Эрчим хүчний эрчим* гэдэг үзүүлэлтийг авч үзвэл манай улс эрчим хүчийг хэмнэлттэй ашиглаж байгаа дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд эрчим хүчийг үр ашигтай ашиглаж байгааг хэмждэг юм. Гэтэл *Нүүрстөрөгчийн эрчим* буюу нэгж эрчим хүчнээс ялгарах ХХЯ-ын хэмжээг тодорхойлдог үзүүлэлтээс харвал манай улс маш өндөр байна. Эрчим хүч бий болгож буй эх үүсвэрийг харьцааг харвал ХХЯ-ыг бий болгож буй гол шалтгаан нь нүүрсний хэрэглээ байна.

Зураг 21. Эрчим хүчний эрчим болон Нүүрстөрөгчийн эрчим




Эх үүсвэр: Дэлхийн банк, Дэлхийн нүүрстөрөгчийн төсөл

ДНБ-ийн өсөлтийн хувь ХХЯ-ын өсөлтийн хувиас 2 дахин их байснаар сая зөв харьцаа үүсдэг ба энэ харьцааг сайжруулж чадсан туршлагаар Бахрэйн, Итали, Грек зэрэг тэргүүлж байна.

Улс орнууд ХХЯ-ыг хэмжихдээ үйлдвэрлэлд суурилсан ялгаралт буюу тухайн улсын хилийн дотор ялгардаг нүүрсхүчлийн хийг тооцоолох хандлагатай байдаг байна. Гэвч өөр газар үйлдвэрлэсэн импортлолсон барааны ялгаруулалтыг тооцдоггүй байна. Манай улсын хувьд Дотоодын үйлдвэрлэлийн хорт ялгарал 2020 онд 796 хувиар, импортын бараа бүтээгдэхүүнээс үүсэж буй хорт ялгарал 714 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 22. Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарал



Манай орны хувьд эрчим хүчний нэг нэгжээс ялгарах нүүрстөрөгчийн хэмжээг бууруулахын тулд:

- Эрчим хүч бий болгох үйл явцаа нүүрстөрөгч багатай эх үүсвэр рүү шилжүүлэх (сэргээгдэх эрчим хүч эсвэл цөмийн эрчим хүч гэх мэт),
- Эрчим хүч бий болгоход ашиглаж буй нүүрсний хэрэглээг бууруулах нэн шаардлагатай байна.

ХААХУУҮС-ын судалгааны үр дүнгээс манай орны БЖДҮ-үүд саарал ус ашиглах, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, цахилгаан машин ашиглах туршлагыг огт хэвшүүлээгүй байна. Иймд Монгол улсын ХХЯ-ыг бууруулахад БЖДҮ эрхлэгч нарт энэ чиглэлийн сургалт, арга зүйн зөвлөмж өгөх, техникийн туслалцаа, шийдэл санал болгох нь чухал байна.

Зөвлөмж 2. Хамтын ажиллагаа

Бизнес загвар, бүтээгдэхүүний үйлчилгээ, технологийг байгальд ээлтэй болгож өөрчлөхийн (Rethinking/Redesign) тулд байгууллагын удирдлага болон ажилтнуудын хандлагыг өөрчлөх төдийгүй хамтран ажиллах, тууштай байх нөхцөлийг бүрдүүлэх, урамшуулж дэмжих нь чухал болохыг олон улсын туршлагаас харж болно. Өөрийн үнэлгээний асуулга судалгааны үр дүнгээс харвал манай орны БЖДҮ эрхлэгч нарын нэмүү өртгийн сүлжээ, тэр дундаа

тойрог эдийн засгийн туршлагауудыг нэвтрүүлэхэд хамтын ажиллагаа сул байгаа үр дүн гарсан. Гэтэл тойрог эдийн засгийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд цогц, өргөн хүрээний идэвхтэй хамтын ажиллагааг шаарддаг. Түүнчлэн бизнесийн шинэ орлогын эх үүсвэр бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээний дизайныг шинэчлэх, хамгийн чухал нь нэмүү өртгийн сүлжээний хамтын ажиллагааг бэхжүүлж сэргээгдэх эрчим хүч зэрэг байгалийн нөөцийг ухаалгаар хамтран хэрэглэх сорилт тулгарч байна.

Хамтын ажиллагааг хөгжүүлэх нь нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулахад үзүүлэх нөлөөг дараах жишээгээр тайлбарлая. Өөрийн үнэлгээний асуулга судалгааны үр дүнд ХААХУУҮС-ын борлуулалтын 50%-60% нь Улаанбаатар хотод хийгддэг байна. Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатараас Улаанбаатар хот хүртэл 327 км зайтай ба ирэх очих 2 талдаа 654 км зам туулна. Автомашин 14 км/литр бензин зарцуулдаг гэж үзвэл нийт 46.7 литр бензин зарцуулах бөгөөд энэ нь 0.11мт⁶⁰ CO₂ ялгаруулах болно. Сүхбаатар сумын 10 БЖДҮ нар хамтран Улаанбаатар хот руу 1 удаа тээвэрлэлт хийвэл эдийн засгийн агуулгаар 420.7 литр түлш, 1,005,473 төгрөгийн түлшний зардал (1 литр бензиний үнэ 2,390 төгрөг гэж үзвэл), түүнээс гадна жолоочийн хөлс, Улаанбаатар хотод байрлах байр, хоолны зардал хэмнэхээс гадна 0.99мт CO₂ ялгаруулалтыг бууруулах боломжтой юм.

ТЭЗ-ийн тайланд ХХЯ-ыг хязгаарлах замаар уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийг илүү гүн гүнзгий, үндсээр нь өөрчлөхөд хувь нэмрээ оруулах боломжтой бизнесийн байгууллагууд хэрэгжүүлэх 21 стратегийг⁶¹ санал болгосон байна. Тухайлбал: Органик хүнс, дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэх, гэрчилгээжүүлэх зэрэг стратегиуд нь 2.07гт CO₂ ялгаруулалтыг бууруулах боломжтой тооцоог хийжээ. Иймд эдгээр стратегиудаас сонголт хийж төслийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой юм.

Зөвлөмж 3. Сургалт, зөвлөх үйлчилгээ

Нарийвчилсан судалгаанд оролцсон БЖДБЭ-ын ТЭЗ-ийн төлөвшлийн түвшин 0 ба 1 дүгээр түвшинд байна. Эдгээр бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хөгжүүлэх нь төслийн гол зорилго бөгөөд үүний тулд ТЭЗ-ийн Төлөвшлийн загварыг ашиглаж төсөлд хамрагдах байгууллага өрхүүдийн сургалт зөвлөх үйлчилгээний өмнөх суурь болон дараах хүрсэн түвшинг тодорхойлж харьцуулснаар төслийн үр дүнг харуулах боломж бүрдэнэ гэж харж байна. Түүнчлэн суурь түвшинг зөв тодорхойлсноор тухайлсан хүнд тохирох сургалтын агуулга, арга барилгыг тодорхойлох боломж бүрдэнэ.

Тухайлбал: 0 түвшинд байгаа ЖХҮ-ийн дэд салбарын оролцогчид ТЭЗ-ийн стратегийн сонирхол байхгүй, тойрог эдийн засгийн туршлагагүй, тойрог эдийн засгийн мэдлэггүй, шугаман бизнесийн загвартай байна. Тэднийг 1 түвшинд хүргэхийн тулд ТЭЗ-ийн

⁶⁰ Greenhouse Gas Equivalencies Calculator, <https://www.epa.gov/energy/greenhouse-gas-equivalencies-calculator> ашиглан тооцоолов.

⁶¹ The Circularity Gap Report, 2022

туршлагаадаас дор хаяж нэгийг хэрэгжүүлэх, ойлголтыг нэмэгдүүлэх, байгууллагын стратеги, зорилго зорилтыг ТЭЗ-рүү чиглүүлэх, бизнесийн загварыг эргэн харах зэрэг үйл ажиллагаанд чиглэгдсэн сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлэх нь оновчтой юм. Орцоо багасгах (Reduce), дахин ашиглах (Reuse), засах (Repair), дахин боловсруулах (Recycle) туршлагаадаас мөн хэрэгжүүлж болно. Жишээ нь: (i) борооны ус, саарал усыг хуримтлуулах, усалгааны системийг хөгжүүлэх, (ii) эрчим хүчний ашиглалт бууруулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах, дулаан алдагдалтыг бууруулах, (iii) тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг дундаа ашиглах, засварлах (iv) ХАА, хүнсний хаягдлыг ангилах, цуглуулах, дахин боловсруулах, ашиглах гэсэн туршлагаудыг нэрлэж болно.

Зөвлөмж 4. Ногоон гэрчилгээ олгох үйл ажиллагаа

Манай орны органик бүтээгдэхүүний тэмдэг авах үйл явц нь үе шат олонтой, харьцангуй төвөгтэй, цаг хугацаа болон тууштай байдлыг шаарддаг байна. Нөгөө талдаа хүнсний үйлдвэрлэгчдийн хувьд энэ чиглэлийн мэдлэг мэдээлэл хангалтгүй, мэдээллийн технологийн мэдлэг чадвар дутмаг байгаагийн улмаас баримт бичгийн бүрдүүлэлт, органик хүнсний бүтээгдэхүүний мэдээллийн санд хандаж чаддаггүй байна.

ХААХУУҮС-ын БЖДБЭ-ийн техник технологийн чадвар тааруу, хүний нөөцийн хомсдолтой, санхүүгийн чадавх хязгаарлагдмал байдлыг харгалзан үзэж ногоон гэрчилгээ авах үйл явцыг энгийн хялбар, ойлгомжтой байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Баталгаажуулалтын үйл ажиллагааг дижитал хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцогчдын дижитал ур чадварыг хөгжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай ба баталгаажуулалтын үйл явцыг зураглах, бичлэг болон хэвлэмэл байдлаар үйл явцыг тайлбарлах, заан туслах (mentorship) хөтөлбөрийн хэрэгцээ өндөр байна.

Зөвлөмж 5. Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах ажлууд

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгч болон олон нийтийн мэдлэг, ойлголтын түвшинг нэмэгдүүлэх нь худалдан авах сэдлийг өгөх төдийгүй үйлдвэрлэгч нард тавих шаардлага нэмэгдүүлнэ. Тиймээс олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах дараах ажлуудыг хэрэгжүүлэх боломжтой юм.

Хүснэгт 32. Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах ажлууд

| Зорилго | Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах ажлууд | Хамтран ажиллах байгууллага |
|----------------------|---|---|
| Хамтын шийдэл | Их дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | Их дээд сургуулиуд |
| | Нэмүү өртгийн сүлжээний оролцогч талуудын уулзалт, зөвлөгөөн | Нийслэл, аймгийн Хөдөө аж ахуйн газар, бизнес эрхлэгчдийн холбоод, БЖДҮ |

| | | | |
|-----------------------------------|--|--------------------|---|
| | Ногоон эдийн засгийн бодлого, эрх зүйн орчны талаарх хэлэлцүүлэг | ХХАХҮЯ, МҮХАҮТ | БОАЖЯ, |
| Олон нийтийн танин мэдэхүй | НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас зарласан Хүнсний хог хаягдлын талаарх олон улсын өдрийг тэмдэглэх (9-р сарын 29-ний өдөр) | ХХАХҮЯ, БОАЖЯ, НҮБ | |
| Мэдлэг олгох | Өсвөр насны хүүхдүүдэд байгаль орчинд ээлтэй байх сургалт зохион байгуулах | ШУБЯ, аймгийн | Нийслэл, Ерөнхий боловсролын сургуулиуд |
